

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ”
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
2 БОЛОН 3 ДУГААР ТАЙЛАН**

2020-2023 оны нэмэлт мэдээлэл

Улаанбаатар хот
2023 он

**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ” НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН 2 БОЛОН 3 ДУГААР ТАЙЛАН**
(2020-2023 оны нэмэлт мэдээлэл)

4 дүгээр зүйл. Нийтлэг үүргүүд

Монгол Улсын Засгийн газраас дотоодын хууль тогтоомжийг конвенцын зарчим, агуулгад нийцүүлэн ажиллаж байна.

1. УИХ-ын Хууль зүйн байнгын хороо 2020 оны 9 дүгээр тогтоолоор “Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явцтай танилцах, санал дүгнэлт боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж хэрэгжилтийг нь тайлагнах үүрэг хүлээсэн 30 олон талт олон улсын гэрээний биелэлтийг дүгнэх, гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг нэг бүрчлэн үнэлэх ажлыг гүйцэтгэсэн. Ингэхдээ олон улсын гэрээнд заасан нэр томъёо, тодорхойлолт, зохицуулалт Монгол Улсын хууль тогтоомжид зохих агуулгаар туссан эсэхэд дүн шинжилгээ хийж, дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээнд нийцүүлэх, конвенцын хэрэгжилтийг сайжруулах талаар санал боловсруулж, олон улсын гэрээ, зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах асуудлаар тодорхой шийдвэр гаргахаар ажиллаж байна.
2. “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Тус хуулиар нийтийн тээврийн хүртээмж, барилга байгууламж, авто зам, замын байгууламжийн хүртээмж, мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж, үйлчилгээний хүртээмжийн асуудлыг зохицуулна. Хууль батлагдсанаар орон сууц, олон нийтийн барилга байгууламж, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийн болон үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон улсын түгээмэл загварт нийцүүлэн, иргэд нийгмийн харилцаанд оролцоход дэд бүтэц, мэдээлэл, үйлчилгээний хүрээнд тохиолдож буй саад бэрхшээлүүдийг арилгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэх юм. Түүнчлэн хүртээмжийн улсын байцаагчтай болж, хүртээмжийн үнэлгээ хийх ажлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хүртээмжийн чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж, гүйцэтгэлд хяналт тавих тогтолцоо бүрдэх юм. Хуулийн төслийг төрийн бус байгууллагад 8 удаа хэлэлцүүлж тэдний саналыг тусгасан.
3. ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисстой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, дотоодын хууль тогтоомж нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцтой хэрхэн нийцэж байгаа талаарх судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлыг Богд судалгааны хүрээлэнгээр гүйцэтгүүллээ. Уг судалгаагаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, дотоодын хууль тогтоомж нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцтой хэрхэн нийцэж байгаа талаарх зөвлөмж, Хүний эрхийн Үндэсний комисс болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудын сүүдэр тайланд үндэслэсэн бодлогын зөвлөмж, дотоодын хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт 2015 онд ирүүлсэн зөвлөмж болон конвенцын II, III тайланг боловсруулах богино асуумжийн дагуу сайжруулж, шинэчлэх хуулиудын жагсаалт, саналыг боловсруулсан.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж байгаа бөгөөд хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагын төлөөлөлд 9 удаа хэлэлцүүлсэн. Хуулийн төсөлд холбогдох нэр томъёог олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх сургалтыг тогтолцоог тодорхой болгох, бие даан амьдрах эрхийг хэрэгжүүлэх үүднээс “Дэмжих үйлчилгээ”-г тусган, ажлын байрны дадлагажуулагчийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг шинээр тусгасан.
5. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 онд батлан хэрэгүүлж, байна. Тус хуульд хөдөлмөрийн харилцаанд хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь ялгахгүй байх, НҮБ-ын хүний эрхийн хорооноос ирсэн зөвлөмжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын цагийг хорогдуулсан байдлыг устгах, ажил олгогч нь ажлын байрны тохируулгыг бүрдүүлж өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллах боломжтой ажлын байрны жагсаалтыг баталж байсан хүний эрхийн зөрчилтэй заалтыг хасах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд худалдан авах, зайнаас ажиллах боломж нөхцөлөөр хангах зэрэг зарчмын чухал өөрчлөлтүүдийг тусгаж өгсөн. Засгийн газрын 2022 оны 253 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх тухай журмыг баталсан.
6. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ баталлаа. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.5.13.1-т “Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасны дагуу дээрх хуульд байнгын асаргаатай хүүхдээ асарсны улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа эцэг эхийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс 100 хувь хариуцах зохицуулалтыг тусгасан.
7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл, Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын төлөөлөлд танилцуулж тэдний саналыг нэгтгэн тусгахаар ажиллаж байна.
8. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан олон нийтэд танилцуулан хэлэлцүүлж, иргэд олон нийтээс санал авах арга хэмжээг 2022-2023 оны хооронд өргөн хүрээгээр зохион байгуулж, олон нийт, төр, төрийн бус байгууллагын төлөөлөл, хуулиар эрх ашиг нь хөндөгдөх хэсэг, өрх толгойлсон эцэг, эхчүүдэд нийт 9 удаагийн томоохон хэлэлцүүлэг зохион байгуулсан. Гэр бүлийн тухай хуулийн төслийг сайтад байршуулан олон нийтийн саналыг авч байна. Хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлаар дараах тусгайлсан заалтыг тусгасан. Үүнд:
 - Гэр бүлийн харилцаанд хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэй, эсхүл бага насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах;
 - Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа тэргүүн ээлжинд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах;
 - Гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, тэтгүүлэх, эсхүл хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, эд хөрөнгийн талаар дурдсан эсэхээс үл хамаарч, гэрлэлт цуцлуулах үед харилцан тохиролцох;

- Гэрлэлтийн гэрээгээр гэрлэгчид бие биеэ, насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх, сурах эрхийг хангах үүргээс чөлөөлсөн, хязгаарласан харилцааг зохицуулахгүй байх;
 - Эцэг, эх насанд хүрээгүй хүүхэд болон насанд хүрсэн боловч байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг хүлээх;
 - Гэрлэлтээ цуцлуулах болон гэрлэлт хүчин төгөлдөр бус болсонд тооцогдохоос өмнө төрсөн, үрчлэн авсан гурван нас хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа бол тэжээн тэтгүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - Тэтгэлэг авагч өвчилсөн, хөгжлийн бэрхшээлтэй болсон, байнгын асаргаа шаардлагатай, сургуульд орсон зэрэг онцгой тохиолдолд тэтгэлэг төлөгчөөс нэмэлт тэтгэлэг гаргуулах, эсхүл зардлыг хариуцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болох;
 - Ганц бие, төрөл садангүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, гэр бүлийн гишүүд бие биеэ асран хамгаалах боломжгүй, төрөл, садангийн хүнгүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, эсхүл ахмад настныг асран хамгаалалтад хамруулах;
 - Асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй, сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн, ганц бие, төрөл садангүй, эсхүл бие биеэ асран хамгаалах боломжгүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, түүний гэр бүлийн гишүүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх.
9. Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан. Хуулийн төслийг бүх түвшний боловсролын байгууллагын нийт албан хаагчид, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл, аймаг орон нутгуудыг бүсчилж, нийслэл Улаанбаатар хотод гэсэн нийтийн хэлэлцүүлэг 4 үе шаттай зохион байгуулсан. Мөн ажлын хэсгийн 58, дэд ажлын хэсгийн 31 удаагийн хэлэлцүүлгээр хуулийн төслийг хэлэлцжээ.

Боловсролын багц хуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах эрхийг баталгаажуулж, боловсролын зарчим тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байна¹ гэж тодорхойлоод бүх дагалдах хуульд уг зарчмыг баримтлах бөгөөд багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлах арга зүйн ур чадварыг багш мэргэжлээр суралцаж байгаа бүх оюутан багш эзэмших, бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөр агуулгыг ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлогт тохируулна. Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуульд Тэгш хамран сургах боловсрол гэсэн бие даасан бүлгийг оруулж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, багшийн арга зүй, сургалтын орчин, санхүүжилт, эцэг эхийн оролцоо хамтын ажиллагааг бүхэлд нь тусгасан. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшинд харгалзсан сургалтын хөтөлбөрт тохируулга хийхээр тусгасан. Дээд боловсролын тухай хуульд сургалтын байгууллага нь боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэхээр тусгасан.

Боловсролын багц хуулийн шинэчлэлээр боловсролын бүх шатны сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын суралцах онцлогийг харгалзан сургалтын хөтөлбөртөө тохируулга хийхээр тусгаж багш бүр ялгаатай хэрэгцээтэй

хүүхэдтэй ажиллах, тэднийг сургаж хөгжүүлэх арга зүйн ур чадвар эзэмшсэн байхыг онцгойлон авч үзсэн.

10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний төрийн захиргааны албан тушаалд ажиллах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх хүрээнд төрийн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд 2 дахин бууруулсан зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмэлтээр тусган 2023 оны 6 дугаар сард УИХ-аар баталлаа.
11. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль “Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан, эсхүл өндөр мэргэшилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болох” зохицуулалтыг нэмж тусган баталсан.
12. Төрийн албаны шалгалт өгөх болзол, журамд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зохицуулалт байхгүй байсныг өөрчилж, шалгалт авах байрыг хүртээмжтэй болгох, төрийн албаны нөөцөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нэн тэргүүнд нөхөх зарчмыг баримтлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шалгалт өгөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.
13. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020.01.22-ны өдөр УИХ-д өргөн барьсан. УИХ-ын чуулганаар холбогдох хуулиудын хооронд нь уялдуулах хүрээнд Газрын багц хуультай хамтран хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Газрын тухай багц хуулийн төсөлтэй харьцуулсан судалгааг боловсруулсан ба хамтад нь УИХ-аар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Хуулийн төсөлд:
 - шинэчилсэн найруулгын хуулийн төслийн зорилт нь хүн амын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлсэн бүс нутаг, хот, суурин газрыг төлөвлөх, байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байгаа бөгөөд шинээр “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд хүн амын эрүүл, аюулгүй байдал, байгаль экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах” зарчим тусгагдсан.
 - “хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн эрх тэгш байдлыг хангах”;
 - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтцийн хэрэгцээг хангах нь хот байгуулалтын баримт бичигт тавигдах үндсэн шаардлага болох”;
 - “гадна тохижилтын ажил, барилга байгууламжийн орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүртээмжтэй орчинг бүрдүүлэн төлөвлөсөн байх”;
 - “хөгжлийн бэрхшээлтэй хүний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөл, барилгажилтын шийдэл, зураг төсөлд зөвшөөрөл олгохгүй байх”;
 - “хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчны талаарх мэдээлэл тусгах” зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн зүйл, заалтыг тусгасан.
14. “Орон сууцны ашиглалтын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газарт 12 дугаар сард танилцуулан, УИХ-д өргөн барихаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хуулийн төсөлд “орон сууцны барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан, хүртээмжийг сайжруулсан орчныг бүрдүүлэх” талаарх заалтыг тусгасан.
15. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 123 дугаар тушаалаар барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичиг “БАРИЛГА,

БАЙГУУЛАМЖИД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ ТӨЛӨВЛӨХ" /БНБД 31-23-22/-ийг баталж, мөрдөн ажиллаж байна. Энэ хүрээнд:

- Нийгмийн харилцаанд оролцогч бүх хүн түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүний материаллаг орон зай, орчны хүртээмж дээшилж байна.
 - Хүртээмжийг бодит амьдралд хэрэгжүүлэхэд захиалагч, зураг төсөл зохиогч, магадлан, барилгын гүйцэтгэгч, хяналтын байгууллагын харилцан уялдаа сайжирч байна.
 - Бүх хүний аюулгүй, илүү ая тухтай амьдарч, ажиллах, сурч боловсрон өөрийгөө хөгжүүлэх боломжтой архитектурын таатай орчинг төлөвлөж бүтээн байгуулахад техникийн чухал баримт бичиг болж байна.
 - Саадгүй байдал, хүртээмжийн тухай хууль гаргахад төлөвлөлт, техникийн талаас тулгуур материал болох зэрэг олон сайн үр дүнгүүд гарч байна.
16. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны А/117 дугаар тушаалаар Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.
 17. Монгол дохионы хэлний тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны төлөвөгөө, шаардагдах төсвийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/251 тоот тушаалаар баталсан бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж байна.
 18. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8.1-д “Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна” гэж заасантай нийцүүлэн Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тээврийн хэрэгслийг авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлнө” гэж тусгасан.
 19. Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Явган хүнийн зам, талбайн төсөвлөлт болон техникийн шаардлага”-ыг 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотойгоор боловсруулж батлуулахдаа “зам, замын байгууламжид үнэлгээ хийх “Шалгах хуудас”-ыг тусгаж, дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийх албан ёсны баримт бичигтэй болсон.
 20. “Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS 5633:2019” стандартыг шинэчлэн боловсруулж, Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хорооны 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар батлуулсан. Стандартын Норматив эшлэлд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг нэмж тусгасан.
 21. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 05 дугаар сард УИХ-аар батлуулсан. Хууль шинэчлэгдсэнтэй холбоотой дагалдан гарах журмуудыг шинэчилж байгаа бөгөөд Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэл тогтоох, түүнийг олгох, бууруулах, хүчингүй болгох журмын төсөл, жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох журмын төсөл, Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журмын төслүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх асуудлыг тусгахаар боловсруулж байна.
 22. Конвенц, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2017-2021 оны хооронд хэрэгжүүлсэн. Үндэсний хөтөлбөр нь 8 зорилт, 32 үйл ажиллагааны чиглэл бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нэн тэргүүнд тулгамдаж байгаа эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоонд бүрэндүүрэн оролцох, нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, статистик тоон мэдээллийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлуудыг тусгаж хэрэгжилтийг хангасан.

23. Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, зөвлөлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ахалдаг болсон.
24. 2020 оны 193 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ"-ийг шинэчлэн тогтоож, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Дотоодод үйлдвэрлэдэг 30 гаруй нэр төрлийн хэрэгслийн инфляцийн өсөлт, зах зээлийн бодит үнэ ханш, үйлдвэрүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн холбогдох тооцоо судалгааг хийж, жишиг үнийг нэмэгдүүлсэн. Харин дотооддоо үйлдвэрлэх боломжгүй, гадаад улсаас оруулж ирдэг сонсголын аппарат, тэргэнцэр, стомын уут зэргийг зах зээлийн дундаж үнэ ханшид ойртуулан 50 хувь, бусад хэрэгслийг 20 хувиар нэмэгдүүлсэн болно.
- Эмнэлгийн байгууллагаар хийгддэг, өндөр өртөгтэй хиймэл түнхний үе, хиймэл өвдөгний үе, нүдний болор зэрэг зарим төрлийн протезийг нийгмийн халамжийн сангийн хөнгөлөлтөөр хийлгэхийн тулд иргэд төлбөрийг өөрсдөө 100 хувь төлж, дараа нь холбогдох баримт, бичгийг бүрдүүлэн халамжийн сангаас нөхөн авах нь тэдэнд хүндрэл, бэрхшээлтэй байдаг. Тиймээс холбогдох хууль, журамд эрүүл мэндийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн аль нэгнээс хөнгөлөлтийг давхардуулан олгохгүй байх зохицуулалт тусгагдсан боловч байгууллага хооронд мэдээлэл солилцох, хяналт тавихад хугацаа алдаж иргэдэд хүндрэлтэй байгаа асуудлыг нэгмөр шийдвэрлэж 9 төрлийн протезийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр болсон.
25. Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 363 дугаар тогтоолоор дараах нэр төрлийн сэлбэг, хэрэгслийг нэмж тусган "Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ"-ийг шинэчлэн баталсан.
- Орчин үеийн технологийн дэвшилтэй холбоотойгоор хиймэл гар, хөл зэргийн протезийн шинэ төрлүүд болох БИОНИК хиймэл эрхтний сэлбэг, засвар үйлчилгээ
 - Бүрэн хараагүй, сонсголгүй хүний харилцаа холбооны хэрэгсэл /Ухаалаг гар утас/
 - Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэл засал, харилцаа, мэдрэхүйг хөгжүүлэх туслах хэрэглэгдэхүүн, тайвшруулах хэрэгслүүдийг жишиг үнийн жагсаалтад шинээр нэмж оруулсан.

5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл алагчлал

26. Ялгаварлан гадуурхалтын эсрэг зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд суурь зарчмыг хуульчлан, энэ хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөгөө эрх тэгш эдлэх боломжийг холбогдох бусад салбарын хууль тогтоомжид баталгаажуулсан.
27. Эрүүгийн хуулийн 14.1.1-т "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол эрүүгийн хариуцлага тооцох зохицуулалтыг тусгасан. Тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ялгаварлан гадуурхах гэмт хэргийн шинжийг өргөжүүлж уг гэмт хэргийг боловсролын байгууллагын орчинд, цахим сүлжээ ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэхээр тусгасан.
28. 2022 оны 12 дугаар сард батлагдсан Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгаар гэмт хэргийн улмаас сэтгэгцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох асуудлыг шинээр тусгасан ба энэ хүрээнд Эрүүгийн хуульд

- заасан гэмт хэргийн хохирогч болсон бол Иргэний хуульд заасан гэм хорын хохирол нэхэмжлэх эрхтэй байх зохицуулалтыг бүрдүүлсэн.
29. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтарч 5 тусгай сургуулийн 566 тусгай хэрэгцээт хүүхдэд “Хүүхдийн эрх, хамгаалал”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл өгч, “Сэргийлэгч хүү, сэргийлэгч охин”-ы аюулгүйн зөвлөмжийг үзүүлсэн.
 30. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, байгууллага, хэлтэс, салбар нэгж нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангаж, хөгжлийн бэрхшээлтэй алба хаагч, түүний гэр бүлийн гишүүд, хоригдлын эрхийг хамгаалж 2020-2021 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүний эрхийг хангах чиглэлээр 1 багц буюу 40 цагийн сургалтыг “Нийгмийн халамжийн чиглэлээр хийгддэг ажлууд”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Өөртөө итгэх итгэл” зэрэг сэдвүүдээр зохион байгуулсан.
 31. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө, үйлчилгээг бэрхшээлийн онцлогт нь тохируулан зохион байгуулж байгаа бөгөөд “Сэтгэл зүй, оюун санааны есөн дэвшил” хөтөлбөрийн сургалт, “Миннесота загвар эмчилгээ”-ний сургалт, “Танин мэдэхүй зан үйлийг засах” сургалтад нийт алба хаагчдыг хамруулсан.
 32. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-т заасны дагуу сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад хэлмэрч оролцуулахыг мэдэгдэн, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох эрхээр ханган ажилласан.
 33. Нийслэлийн дүүргүүдийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Прокурорын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэстэй хамтарч 173 хорооны Хамтарсан багийн гишүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголтыг сайжруулж чадавхжуулах сургалтыг 13 удаа зохион байгуулж, харааны бэрхшээлтэй иргэдэд брайл үсгээр хэвлэгдэн гарсан тусламжийн хуудас 2450 ширхэгийг тарааж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах ажлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.
 34. Нийслэлийн ЕБС-ийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг аливаа төрлийн осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр 75 дугаар сургуулийн захиргаа болон багш, нийгмийн ажилтнуудад 32 удаагийн сургалтыг зохион байгуулж, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, мэдээлэл, тусламжийн хуудас 3700 ширхэгийг брайл үсгээр хэвлэн тарааж, талаар мэдээлэл өгсөн.
 35. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 256 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын барилгын дүрэм, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл зохиох дүрмийн 3.5, 3.6-д заасны дагуу Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын нэг, хоёрдугаар хэлтэс, Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн байрны орц хэсгийн шатанд налуу зам хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Цагдаагийн байгууллагын үйлчилгээ авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.
 36. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, газар, хэлтэс, салбар нэгжүүд “Нэг цонхны үйлчилгээ”-ний хэсэг, үйлчилгээ үзүүлэх байрт налуу зам хийн засварлаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “Та дараалалгүй үйлчлүүлэх эрхтэй, дараалал харгалзахгүй үйлчилнэ” гэсэн бичвэр, таних тэмдэг, тэмдэглэгээг хийж байршуулсан ба алба хаагчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.
 37. **Хууль, хяналтын байгууллагын алба хаагчдыг сургалтад хамруулсан талаарх мэдээллийг конвенцын 78-82 дах хариултаас дэлгэрүүлж харна уу.**

6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд:

38. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар иргэд, охид, эмэгтэйчүүдийг тэгш боломжоор хангах, эрхийг нь хамгаалах, нийгэм, гэр бүлд аливаа хэлбэрээр, хүйсээр ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглодог бөгөөд хүйсээс болон хөгжлийн бэрхшээлээс үл хамааран эрх тэгш, нээлттэй хамруулах, хамгаалах зарчмыг баримталж байна.
39. Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд 2021 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн чанарын судалгаа”-г хөндлөнгийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүллээ. Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй хэлбэр, түвшин, нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлсноос гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүчирхийлэлд өртөж буй байдлаа ухамсарлан ойлгох, бусдад мэдээлэх, тусламж үйлчилгээ эрэлхийлэх ойлголт, зан үйлийг тодорхойлсон бөгөөд судалгааны тайланг холбогдох төрийн байгууллагын ажилтнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 16 төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлж, цаашид энэ чиглэлээр тодорхой төлөвлөгөө гарган хамтран ажиллахаар шийдвэрлэлээ.
40. Амгалан, Өргөө, Хүрээ амаржих газрууд хөгжлийн бэрхшээлтэй нөхөн үржихүйн насны 65 эмэгтэйд эх барих тусламж үзүүлж төрүүлсэн ба Амгалан амаржих газарт төрөхөөр ирсэн хөгжлийн бэрхшээлтэй эхчүүд, эмэгтэйчүүдэд хүртээмжтэй үйлчилгээг хүргэж байна.

7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

41. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Төв комисс ХНХЯ-ны бүтцэд, салбар комисс 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна. Салбар комисс нь 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий салбар дундын үйл ажиллагааг хэрэгжүүлэх орон тооны бус комисс бөгөөд бүрэлдэхүүнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, гэр бүлийн салбарын болон эцэг эхчүүдийн төлөөлөл ордог.
42. Комиссын дүрмийг Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Төв болон Салбар комиссын эрх үүрэг, бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, үйл ажиллагаанд тавих хяналт, мэдээллийн сан, шаардлагатай тохиолдолд комиссын хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг зохицуулалтыг нэмж тусгасан.
43. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/220/475/812 дугаар хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт”-ыг шинэчлэн баталсан. Тус тушаалаар хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлгийн үзлэгийг үйлчилгээг 9, 18, 36 сард нь зохион байгуулах, аймаг, дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах үүрэг бүхий “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”, “Дэмжлэгийн баг”-ийг сургуулийн өмнөх боловсролын байгууллагад байгуулах, эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хүүхдийг гэр бүлийн орчинд суурилан боловсролын хувилбарт сургалтын эрх зүйн орчин нөхцөл бүрдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд эцэг, эх асран хамгаалагчийн үүрэг оролцоог нэмэгдүүлсэн. Тушаалын хэрэгжилтийг сайжруулах, олон нийтэд танилцуулах зорилгоор 21 аймаг, 9 дүүргийн Боловсрол, шинжлэх ухааны газар/хэлтэс, Эрүүл мэндийн газрын

- удирдлага, мэргэжилтнүүд, Нэгдсэн эмнэлгийн эмч нар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн холбооны гишүүдэд цахим сургалт зохион байгуулсан.
44. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/807/216 дугаар хамтарсан тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд байнгын асаргаа тогтооход баримтлах өвчин гэмтлийн “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт”-ыг шинэчлэн баталсан. Тушаалд “Өвчний заалт, Шалгуур үзүүлэлт” хэсэг, өвчин, эмгэгийн заалт тус бүрийн шалгуур үзүүлэлт, тайлбарыг нэмж оруулсан. Өмнө оношийн нийт 14 бүлэг, 120 орчим өвчин, гэмтлийн заалт байсныг 20 бүлэг, 160 орчим өвчин гэмтлийн заалттай болгон өөрчилж өвчний нийт 58 шинэ заалт нэмэгдсэн. Мөн эмчлэн эрүүлжүүлж, нөхөн сэргээх хугацааг 24 сар, 36 сар байсныг 12-24, 12-36 сар болгох, байнгын асаргааг 16 нас хүртэл хугацаагүйгээр тогтоох нийт 29 өвчин, гэмтлийн заалт шинээр тусгагдсан. Түүнчлэн 16 насанд хүртэл хугацаагүй сунгасан тохиолдолд ХБХЭМБНХСК-ын шийдвэрийн дагуу холбогдох хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ, эмчилгээ, хяналтын үзлэгт хамрагдаж байгаа эсэхэд жилд 1 удаа цахим хэлбэрээр хяналт тавьж хамрагдаагүй тохиолдолд байнгын асаргааг цуцлах хүртэлх арга хэмжээ авахаар, асаргааг цуцалснаас хойш 3 сарын хугацаанд хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ, эмчилгээ, хяналтын үзлэгт хамрагдсан бол байнгын асаргааны хугацааг нөхөн сунгах зэрэг асуудлыг тусгасан.
 45. Шинэчлэн баталсан эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг сайжруулж, чадавх бэхжүүлэх хүрээнд 2022 оны эхний улиралд 21 аймаг, 9 дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, ХХҮГ/хэлтэс, ТББ-уудын удирдлагууд болон холбогдох ажилтнуудыг хамруулсан бүсчилсэн сургалтыг АХБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Жайка байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, нийт 1000 гаруй хүнийг хамруулсан.
 46. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институттэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах ойлголт, хандлага, нөхцөл боломж” судалгааг ерөнхий боловсролын сургууль /цаашид ЕБС/ болон сургуулийн өмнөх боловсролд /цаашид СӨБ/ хамрагдах насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургахад эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үүрэг оролцоо, үйл ажиллагааны хэрэгжилтийг тодруулах зорилгоор гүйцэтгэсэн.
 47. Салбар комиссын гишүүдийг чадавхжуулах хүрээнд 2023 оны эхний улиралд 2 удаагийн онлайн сургалтыг зохион байгуулсан.
 48. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төрийн нарийн бичгийн 2023 оны А/155 дугаар тушаалаар 8 ХБХЭМБНХСК-ын үйл ажиллагаанд хяналт үнэлгээг зохион байгуулсан.
 49. АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний оролцоог хангах үйлчилгээг сайжруулах төсөл”-тэй хамтран эрт үеийн хөгжлийн дэмжлэг оролцооны Портеж хөтөлбөрийн Монгол хувилбарыг боловсруулж, үндэсний 16, орон нутгийн 50 сургагч багшийг бэлтгэсэн.
 50. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 149 дүгээр сургуультай хамтран багш, ажилчид, эцэг эхчүүдийн хүүхдийн эрх хамгаалал, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг дээшлүүлж, зөвлөгөө өгөх, хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний чанарыг сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх үйл ажиллагааны “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй сургууль”-ийн загвар төслийг 2021 оны 06 дугаар сараас 2022 оны 02 дугаар сар хүртэл хугацаанд хэрэгжүүлсэн.
 51. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулахтай холбоотой Засгийн газрын хуралдааны 33 дугаар тэмдэглэлээр бүх яамд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 23 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

52. ХНХЯ, БШУЯ, ЖАЙКА-ын хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн нэгдсэн сангийн программ хангамжийг боловсруулж, 21 аймаг, 9 дүүргийн нийт 150 Салбар комиссын гишүүдэд НҮБ-ын Хүүхдийн сан, ЖАЙКА, Азийн хөгжлийн банк, Хүүхдийг ивээх сан, Монгол дахь Норвегийн тусламжийн байгууллага зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулсан.
53. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн сэргээн засах тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлэх, бусад байгууллагад мэргэжил, арга зүйн лавлагаа тусламж үзүүлэх чиг үүргийн дагуу АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-ийн дэмжлэгтэй “Бидэнд ойр” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах төслийн хүрээнд Телемедицин буюу алсын зайн үйлчилгээг www.eclinic.mn платформоор дамжуулан 2021 оны 08 сарын 12-ны өдрөөс эхлэн нэвтрүүлсэн.
54. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулж, Хүүхдийн төлөө санг байгуулсан. Тус хуулийн 212.3.3-т олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэхээр заасан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих” журмыг баталсан. Тус журамд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн олон улсын тэмцээн уралдаанд оролцох зардлыг Хүүхдийн төлөө сангаас гаргахаар тусгасан. Уг журам хэрэгжиж эхэлснээс хойш автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос 8,8 тэрбум төгрөг, “Хүүхдийн фонд” төрийн бус байгууллагаас 2,1 тэрбум төгрөг, байгууллага, иргэдээс өгсөн хандив 15,5 сая төгрөг, нийт 10,9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Үүнээс шагнал урамшуулалд 2021 онд 15 хүүхдэд 25 сая төгрөг, 2022 онд 117 хүүхдэд 249,4 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд 23,3 сая төгрөг, нийт 121 хүүхдэд 272,7 сая төгрөгийг зарцуулах шийдвэр гарсан байна.
55. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй эсхүл цаатан өрхийн нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад зэрэг суралцаж байгаа тохиолдолд нэг суралцагчийг зээлд хамруулдаг.
56. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, “Бага насны хүүхдийн хөгжил MNS-5420-1:2011 стандарт, Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015” стандарт зэрэг эрх зүйн баримтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллага хүрэлцээгүйн улмаас цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд хөгжил, хамгааллын үйлчилгээ үзүүлэх, ажилгүй иргэд ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эцэг эх, асран хамгаалагчийн ажил хөдөлмөрөө эрхлэх боломжийг олгох төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг 2015 онд баталсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээн Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг шинэчлэн баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой дараах зохицуулалтуудыг тусгасан:
- 1.3. Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дагнан хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хүүхдийн тоо гурваас илүүгүй байх;
 - 1.4. Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхэдтэй хамт хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэг байх;

- 2.2. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ногдох хувьсах зардлыг тооцохдоо "Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив"-ыг 2 дахин нэмэгдүүлж тооцох.
57. Хүүхэд харах үйлчилгээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар 142 хүүхэд харах төвд 356 хүүхэд харагч 1626 хүүхэд хамрагдсаны 113 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.
58. 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг тусгайлан оруулж батлуулсан. Үүнд Портеж эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны хөтөлбөр багтсан.
59. Байнгын асаргаатай болон хэвтрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг "Хүүхэд хөгжлийн төв"-ийг түшиглэн боловсролын үйлчилгээ үзүүлэх туршилтыг байнгын асаргаатай хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг Энэрэлийн түүчээ ТББ-ын дэргэдэх Энэрэл хүүхэд хөгжлийн төв болон Нийслэлийн 70 дугаар сургууль дээр туршин хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад холбогдох зардлыг төсөвлөөд байна.
60. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Хөтөлбөр арга хэмжээний төсвийн хуваарилалт батлах, эрх шилжүүлэх тухай" 07 дугаар тушаалын 2.2.15 дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх дэмжлэгийн зардлыг 2022 онд 100.000.000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.
61. ХНХЯ-аас 2018-2023 оны хооронд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийт 26 төрийн бус байгууллагад 699,064,740 төгрөгийн санхүүжилтийг Хүүхэд хамгааллын зардал болон ХБ-тэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс олгож дэмжлэг үзүүлж ирсэн.
62. "Найз байя" аяны хүрээнд Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 2023 оны 6 дугаар сарын 1-нд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хүүхэд өсвөр үеийнхэнд зориулсан өдөрлөг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 800 хүүхэд, үүнээс 300 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оролцлоо.
63. Иргэний нисэхийн ерөнхий газраас 2023 оны 05 дугаар 26-27нд зохион байгуулсан "BU" AIR SHOW-2023 арга хэмжээнд нийгмийн хариуцлагын хүрээнд Буянт-Ухаа нисэх онгоцны захиргаанаас Хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг урьж, тус арга хэмжээнд оролцуулан агаарын хөлөгтэй танилцуулж, агаарын хөлөгт суулгаж мөрөөдлийг нь биелүүлэх арга хэмжээ зохион байгуулсан.

8 дугаар зүйл. Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх

64. ХНХЯ, ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлсэн "Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төсөл" /2016-2020/-ийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сургалтыг зохион байгуулах хөгжлийн бэрхшээлтэй 46 сургагч багшийг бэлтгэж, 2023 оны байдлаар 500 гаруй удаагийн сургалтаар 40.000 гаруй төрийн болон хувийн хэвшлийн ажилтан албан хаагчдыг хамруулж, сургалтад хамрагдсан байгууллагууд гадна болон дотоод орчноо хүртээмжтэй болгоход анхаарч ажиллаж байна. Энэхүү сургалт нь дэлхийн 50 гаруй оронд зохион байгуулагддаг бөгөөд сургалтыг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүн заадаг учир үүгээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй залуусыг чадавхжуулан нийгмийн оролцоог нэмэгдүүлж байна. Түүнчлэн сургалтыг зохион байгуулах, сургагч багш бэлтгэх харилцааг зохицуулах "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалтыг зохион байгуулах, сургагч багшид эрх олгох" журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/86 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
65. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн албан хаагчдыг чадавхжуулах үйл ажиллагааны хүрээнд "Залуу манлайлагч бэлтгэх цуврал сургалт", "Хөгжлийн бэрхшээлийн тухай цуврал сургалт"-ыг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 1000 орчим хүнийг хамруулсан.

66. ХНХЯ, ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бэхжүүлэх төсөл” /2021-2024/-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг боловсронгуй болгох арга замыг тодорхойлж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байранд дадлагажуулагч бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг байгууллагуудын сүлжээг бий болгох, аж ахуйн нэгж байгууллага (ААНБ)-д нөлөөлөх хүний нөөцийг бий болгохоор ажиллаж байна.
67. Ажлын байрны дадлагажуулагч буюу Job Coach-ыг Үндэсний ажил мэргэжлийн жагсаалтад 2021 онд оруулж, “Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааны удирдамж”-ийг 2022 оны 06 сард батлуулан “Ажлын байрны дадлагажуулагчийн загвар төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Ажлын байрны дадлагажуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үнэлгээ хийх, ажлын байранд дадлагажуулах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх, ажил олгогчийн хөгжлийн бэрхшээлтэй хүнд хандах хандлагыг өөрчлөх, тохирсон ажлын байрыг олж үнэлгээ хийх, ажлын байрны таатай орчинг бүрдүүлэх үүрэгтэй юм. Төслийн хүрээнд ажлын байрны дадлагажуулагчийн танилцуулах семинарыг 7 удаа зохион байгуулж, 260 хүнийг, ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулж 67 хүнийг, ААНБ-д зориулсан нөлөөллийн семинарыг 9 удаа зохион байгуулж 380 хүнийг, ААНБ-д нөлөөлөх хүний нөөц бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулж 37 хүнийг, Малайз болон Япон улсад туршлага судлах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 37 хүнийг тус тус хамруулсан.
68. ХБХХЕГ нь 2018 оноос эхлэн “Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх” нөлөөллийн сургалтыг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагын удирдлага, ажилтан албан хаагчид, эцэг, эх асран хамгаалагчдад зохион байгуулж байна. Сургалтад 2020 онд 807, 2021 онд 1960, 2022 онд 2037 хүн, 2023 оны эхний хагаст 9 төрлийн сургалт, арга хэмжээг зохион байгуулж 2544 хүнийг тус тус хамруулсан.
69. Төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын оролцоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хөгжлийг дэмжих чиглэлээр “Монгол Абилимп” ур чадварын тэмцээн, “Зөв манлайлал ялгаварлалыг арилгана” оюутан залуучуудын чуулга уулзалт, “GLOBAL IT CHALLENGE” улсын уралдаан, “Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь” эрдэм шинжилгээний хурал, Парламентийн мэтгэлцээн, ЕБС-ийн сурагчдын “Нэг сургууль-Нэг хүүхэд” аян, “Мэргэжлээ зөв сонгоё” өдөрлөг, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт ба дэд бүтэц, мэдээллийн хүртээмж” хэлэлцүүлэг, “Дохионы хэлийг сурталчлах явган аялал, спорт өдөрлөг” зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр зарласан тэмдэглэлт өдрүүдийг угтсан олон талт арга хэмжээгээр дамжуулан жилд дунджаар 1000 гаруй хүнийг хамруулсан байна.
70. 2021 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоо, хандлагын талаар уриалга дэвшүүлж нийгэм, олон нийтийг уриалах нөлөөллийн аяныг зохион байгуулах хүрээнд Брэйносторм ХХК-тай гэрээлэн “Бэрх биш ээлтэй” аяныг 2021 оны 10 дугаар сарын 01-ээс 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл нийт 2 сарын хугацаанд “Яг чам шиг”, “Бид ээлтэй”, “Манай байгууллага ээлтэй” гэсэн 3 үе шаттайгаар зохион байгууллаа. Аяны хүрээнд нийтэд хамгийн өндөр хандалттай пэйж хуудас, олон нийтийн телевизийн сувгууд, өдөр тутмын сонинууд зэрэг 20 гаруй мэдээллийн хэрэгслээр “Бэрх биш ээлтэй” кампанит ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 2,000,000 гаруй хүнд хүрсэн. Цахим нөлөөллийн ажлуудаас гадна хотын төвийн Автобусны буудлын рекламн нийт 32 байршилд “Яг чам шиг” постерыг 2021 оны 10 дугаар сарын 02-15-ны өдрийг дуустал нийт 14 хоног байршуулж ойролцоогоор 5,769,762 хүнд давтамжтайгаар хүрсэн бол гудамжны самбарын 9 байршилд “Хэн хэнийхээ оршихуйг

хүлээн зөвшөөрье”, “Ээлтэй” постерыг 11 дүгээр сарын 04-өөс 12 дугаар сарын 04-ний өдрийг дуустал 1 сарын хугацаатай байршуулснаас гадна Ч40, Ч24А чиглэлийн автобусны 20 дэлгэцээр 2021 оны 11 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 01 хүртэлх 1 сарын хугацаанд видео сурталчилгааг цацаж ойролцоогоор давхардсан тоогоор 60,000 гаруй хүнд хүрсэн, Зорчигч тээврийн нэгдүгээр нэгдэл, Мяралзаа зорчигч тээврийн нийт 10 автобусны гадна талд “Яг чам шиг” постерууд байршуулаад явж байгаа нь мөн хүмүүсийн анхааралд нөлөөлсөн байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээжүүдийн үүсгэн байгуулсан Ээлтэй ертөнц ТББ-ын дэргэдэх “Ханни” зөөлөн тоглоомын үйлдвэртэй гэрээ байгуулсан 200 ширхэг “Бэрх биш ээлтэй унага”-ыг худалдан авч “Ээлтэй хүн”, “Ээлтэй байгууллага”-д гардуулсан.

71. ХХААХҮЯ-аас хүнс, газар тариалан, мал аж ахуй болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын албан хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүний зөв ойлголт хандлагын онлайн сургалтыг 2021 онд 4 удаа зохион байгуулав.
72. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бизнес төлөвлөгөө боловсруулах сургалтын сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуультай хамтран зохион байгуулав. Сургагч багш нар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төсөл боловсруулах, бизнесээ төлөвлөхөд дэмжлэг үзүүлж, сургалт мэдээллийн арга хэмжээг тогтмол явуулахад хамтран ажилласан. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, хөнгөлөлттэй зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ. Сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв, Түгээмэл хөгжил” төв, Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо, “Элэгсэг оршихуй” төрийн бус байгууллага, Арга билэг, Тулга тав зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 гаруй төр, төрийн бус байгууллагуудын төлөөлөл хамрагдлаа.
73. Улаанбаатар хотын хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр “Хүүхдийн эрхийн ойлголт” сэдэвт сургалтыг хэсэгчилсэн байдлаар 54 удаа 120 цаг зохион байгуулж, давхардсан тоогоор 105 хорооны 548 гишүүдийг хамруулан, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн.
74. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын жолооч нарт зориулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүндрэл бэрхшээл учруулалгүй зорчих боломжийг олгох” сургалтыг 06 дугаар сарын 21-ний өдөр ХБХХЕГ-аас зохион байгуулав. Нийтийн тээврийн жолооч нарт сургалтыг хийснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах харилцаа, хандлага өөрчлөгдөнө, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэх ур чадварт суралцах гэх мэт олон талын ач холбогдолтой үр дүн гарах бөгөөд цаашид ХБИ нийтийн тээврээр зорчиход илүү хүртээмжтэй болох юм. Энэхүү сургалтад нийтийн тээврийн 30 жолооч хамрагдаж, тэргэнцэртэй иргэн автобусанд хэрхэн суух, буух, тэргэнцрийг бэхлэх аргачлал, зааварчилгаа өгч, мөн харааны бэрхшээлтэй иргэн нийтийн тээврээр зорчих үед юуг анхаарах талаар зөвлөмж өгсөн, бодит байдал дээр жолооч нар дадлага ажил хийсэн үр дүнтэй сургалт болж өнгөрсөн. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-тай хамтран “Хүртээмжтэй нийтийн тээвэр” сургалтыг Автобус-2 баазын жолооч нарын дунд зохион байгууллаа. Энэхүү сургалтыг Автобус-1, 2 дугаар баазын 500 гаруй жолооч нарт шат дараатай зохион байгуулахаар төлөвлөсөн.
75. ХЗДХЯ нь “Түгээмэл хөгжил” ТББ-тай хамтран “Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах нь” сэдвээр сургалт зохион байгуулж, салбарын 350 алба хаагч хамрагдсан.
76. ГХЯ-аас хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт шинээр томилогдон ажиллах албан хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах эрх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн агуулгаар багц сургалтыг 2023 оны 05 дугаар сард зохион байгуулсан.

77. Булган аймаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн суурь үйлчилгээг хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын 29 дүгээр тусгай сургуультай хамтран сургагч багшийг орон нутагт урьж төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйлчилгээний ажилтнуудыг дохионы хэлний 1 болон 2 дугаар шатны сургалтад хамруулж, өссөн дүнээр 165 ажилтан албан хаагчийг хамруулсан.
78. Нийслэлийн хэмжээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд “Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч, эцэг эхэд зориулсан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, асаргаа сувилгаа хийх, гамшгийн эрсдлийн үед авах арга хэмжээ” сургалтыг Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд 2020 оны 06 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, дээрх дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран зохион байгуулж, нийт 348 иргэнийг хамруулсан.
79. 2023 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо” ТББ-тай хамтран нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшлийн 16 аж ахуйн нэгж, байгууллагын 160 автобусны жолоочид “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа хандлага”, “Нийтийн тээврээр зорчиход тулгардаг нийтлэг асуудлууд, харилцаа хандлага” сэдвээр сургалт зохион байгуулсан.
80. Баянгол дүүргийн Цагдаагийн газар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал, хэрэгжилт” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж, 2461 алба хаагчийг хамруулсан.
81. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас “Түгээмэл хөгжил” төрийн бус байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх ойлголтыг хаагчдад өгөх, тэдний хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаанд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.1.1 дэх заалтын хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах нь” сэдвээр сургалт зохион байгуулж, 350 гаруй алба хаагчийг хамруулсан.
82. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах хөтөч цагдаа бэлтгэх” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хүрээний цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 28 байгууллага болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн 21 газар, хэлтэс, сум дундын 5 цагдаагийн хэлтсээс нийт 66 алба хаагч хамрагдсанаас Эрүүгийн цагдаа, Мөрдөн байцаах, Тээврийн цагдаагийн алба, нэгж, газар, хэлтсийн 33 албан хаагчийг бэлтгэн гэрчилгээ олгосон.
83. Архангай, Сүхбаатар, Хэнтий аймгийн Цагдаагийн газраас “Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах хөтөч цагдаа бэлтгэх нь” сургалтад хамрагдсан 3 алба хаагч тус аймгуудын Цагдаагийн газар (Архангай 72, Сүхбаатар 96, Хэнтий 56)-ын нийт 224 алба хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харилцах дохионы хэлний сургалт зохион байгуулсан.
84. Дорноговь аймгийн Цагдаагийн газар “Хүний эрхийн тухай ойлголт, үндсэн зарчим”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн ойлголт” сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулж, 236 алба хаагчийг хамруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харьцах дохионы хэлний анхан шатны хичээлийг алба хаагчдаар судлуулж, тэмдэглэл үйлдүүлсэн.

9 дүгээр зүйл. Хүртээмж

85. **Хүртээмжтэй орчин нөхцлийг бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулж буй талаар 2 дахь хариултаас дэлгэрүүлж харна уу.**

86. 2020-2023 оны хооронд төр, төрийн бус байгууллага хамтарч, эсвэл төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх байдлаар хүртээмжийн үнэлгээний ажлыг 10 гаруй удаа зохион байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/190 дүгээр тушаалаар саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг Улаанбаатар хотын хэмжээнд судалж, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр үнэлгээ хийх ажлыг хараа, сонголт, тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхий ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт байрлах Төрийн ордон, бүх яам, Нийслэлийн ЗДТГ-ын зам, замын байгууламж, нийтийн тээврийн үйлчилгээний саадгүй байдал, хүртээмжийг үнэлж зөвлөмж гарган ажиллалаа.

А. Мэдээллийн хүртээмж:

87. Төрөөс хөгжлийн бэрхшээлийн салбарт авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээг ард иргэдэд мэдээлэх зорилгоор 2017 оноос эхлэн жил бүр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал. Бодлого үйл ажиллагаа”: Мэдээллийн лавлах (цагаан ном)-ыг боловсруулан энэ чиглэлээр ажилладаг салбарууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэдэг болсон.
88. Төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор E-Mongolia, E-halamj системээр нийгмийн даатгалын 33, нийгмийн халамжийн 64 үйлчилгээг цахимаар хүргэж эхэлсэн.
89. Интернетийн олон улсын стандартын байгууллага /W3C/-аас батлан гаргасан “Цахим хуудас, контентын хүртээмжийн удирдамж /WCAG/-ийг өөрийн оронд нэвтрүүлэх, 2023 онд Цахим хуудас, контентын хүртээмжийн стандарт” батлуулах хүсэлтийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн стандартын хороонд хүргүүлж, батлахаар ажиллаж байна.
90. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 01 тогтоолоор батлагдсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.17-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2.4-ийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Тус төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг Зохицуулах хороонд ирүүлэх ба хагас жил тутам тайлагнана” гэж заасан. Энэ хүрээнд телевиз тус бүрээр төлөвлөлт, хугацааны хуваарь гаргах боломж, нөхцөлийг бүрдүүлж, өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлгийн төлөвлөлтийг гарган авч, хэрэгжилтэд мониторинг хийж байна.
91. 2023 оны байдлаар Монголын үндэсний олон нийтийн телевизийн 5 сувгаас гадна Монгол Улсад хамрах хүрээтэй 45 телевиз (Улаанбаатар хотын нийт 73 телевиз) үйл ажиллагаа эрхэлж байгаа тул эдгээр телевиз дээрх үүргийг хүлээж байгаа юм.
92. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 60 дугаар тогтоолоор “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.5-д “6+, 12+ насны буюу бага, өсвөр насны хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн нийт цаг (жилд 130-аас багагүй)-ийн 20 хувиас доошгүйг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэх” гэсэн агуулга бүхий заалтыг нэмэлтээр оруулсан. Энэхүү заалт нь одоогоор Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевизэд хамаарах юм.
93. Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Цахилгаан холбооны Стандартчиллын Сектор (ITU-T)-оос гаргасан “IPTV системийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал /Accessibility profiles for IPTV systems (Recommendation ITU-T H.702/, “Цахим хуудас, контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал” /Web Content Accessibility Guidelines 2.0/ зэрэг баримт бичгүүдийг тус тус орчуулж, аргачлалыг товхимол болгож хэвлүүлсэн бөгөөд IPTV технологи бүхий Олон

- суваг дамжуулах үйлчилгээний эрхлэгчд д болон веб сайтын үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн. Аргачлалыг хэрэгжүүлэх зааварчилгаа боловсруулж байна.
94. Мэдээ, мэдээллийн хөтөлбөр, нэвтрүүлгээ дохионы хэлмэрчтэйгээр хүргэхдээ хэлмэрчийн хэмжээг томруулахтай холбоотой олон улсын туршлагыг судлан зөвлөмж боловсруулж, 2023 оны 04 дүгээр сард бүх телевизийн үйлчилгээ эрхлэгчид рүү хүргүүлсэн.
95. Харилцаа холбооны зохицуулах хорооноос дохионы хэлний хэлмэрчийн хүрэлцээ муутай байдлыг харгалзан үзсэнээс гадна телевизүүдийн дотоод нөөц боломж, хөтөлбөрийн бодлого төлөвлөлт, хөтөлбөрийн төрөлжилт зэргээс хамаарч телевиз тус бүрийн төлөвлөлт харилцан адилгүй байх боломжтой тул 2022, 2023 онд нэвтрүүлэх дохионы хэлтэй, хадмал тайлбартайгаар нэвтрүүлэх нэвтрүүлгийн төлөвлөлтийг гаргаж, үе шаттай нэмэгдүүлэх хувь хэмжээг өөрсдөө тооцон ирүүлж, төлөвлөгөөнийхөө дагуу нэвтрүүлэх боломжийг телевизүүдэд олгосон. Иймд телевиз нь өөрийн хөтөлбөрийн ямар нэвтрүүлгийг дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэхээ өөрсдөө тооцож төлөвлөх юм.
96. Ковид-19 цар тахлын үед 2020 онд теле хичээл, төрийн байгууллагаас цар тахлын тухай мэдээлэл, зөвлөмж болон УИХ-ын сонгуулийн сурталчилгаа, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг зэрэг нь дохионы хэлтэй гарч байсан учраас хүртээмжтэй телевизийн тоо, нэвтрүүлгийн хувь өмнөх жилүүдээс өндөр гарсан. Харин 2022 онд нийт 35 телевизээр мэдээ, мэдээлэл, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн бол 2023 оны байдлаар нийт 42 телевизээр нийт хөтөлбөрийн 3.79% нь дохионы хэлтэй, харин 16 телевизийн хөтөлбөрүүдийн 1.27% нь хадмал тайлбартай байсан.
97. ТВ8, С1, Парламент, Сүлд, ТВ9, Монгол ТВ, ЕТВ, MNC, SBN, NTV зэрэг телевиз өдөр тутмын мэдээ, мэдээллийн хөтөлбөр, С1 телевиз Парламентын тэмцээнийг, Монгол телевиз “Өнөө өглөө” хөтөлбөрийн амралтын өдрийн дугаараа, Like, NTN телевизүүд “Эрүүл мэндийн зөвлөгөө” нэвтрүүлгээ, Малчин телевиз “Цаг агаарын хөтөлбөр” зэргийг дохионы хэлмэрчтэйгээр нэвтрүүлж байна. Түүнчлэн төрийн байгууллагууд нэвтрүүлгүүдээ дохионы хэлтэйгээр тогтмол бэлтгэн хүргэж байна. Central, TenGer, Star, C channel, Авто телевизүүд мэдээллийн хөтөлбөр, танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг, Монгол телевиз зарим хүүхэлдэйн киногоо хадмал тайлбартайгаар нэвтрүүлж байна.
98. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Бүгд найрамдах Солонгос Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яамтай хамтран иргэдийн цахим ур чадварыг сайжруулах зорилгоор 2022 онд Мэдээлэл, технологийн үндэсний паркын 1 давхарт 360 м.кв талбай бүхий “Мэдээлэл хандалтын төв”-ийг байгуулж, 1 давхарт нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй сургалтын танхим байгуулж, хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын тоног төхөөрөмжөөр тоногловсон.
99. Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хурдасгуур лабораторитай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим хуудас ашиглалтын судалгаа” буюу түгээмэл хэрэглэгддэг зарим цахим хуудсанд үнэлгээ хийсэн. Судалгаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Худалдаа хөгжлийн банк, Nomin.mn, И-баримт, Look tv, Unread.mn, Ikon.mn зэрэг 7 цахим хаягийг хамруулсан. Мөн Халамжийн нэгдсэн систем, Өргөө кино театрын нийт 2 цахим хуудсанд WCAG2.0 стандартын шалгуурын дагуу хүртээмжийн үнэлгээ хийн зөвлөмж боловсруулсан бол ХБХХЕГ нь “Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо”-той хамтран хэвлэл мэдээллийн Livetv.mn, Zindaa.mn, Zarig.mn, News.mn, Montsame.mn, Gogo.mn, Dnn.mn нийт 7 цахим сайтад WCAG олон улсын аргачлалын дагуу үнэлгээ хийж зөвлөмжийг хүргүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох талаар цахим хуудас эзэмшигч нарт сургалт зөвлөгөө өгч ажилласан.

100. Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хурдасгуур лабораторийн дэмжлэгтэйгээр цахим боловсрол олгох “Microsoft”-ын сургалтын агуулга бүхий нийт 6 сэдвийн 82 видео хичээлийг дохионы хэлээр бэлтгэн БШУЯ-ны Medle.mn платформд “Цахим ур чадвар” цэс үүсгэн байршуулсан. Мөн дээрх лабораторийн дэмжлэгтэйгээр цахим хуудас болон ухаалаг утасны аппликэйшн хөгжүүлэгчдэд зориулсан “Цахим хуудас, аппликэйшны хүртээмжийг сайжруулах нь” сургалтыг 2022 оны 01 дүгээр сард зохион байгуулж, 9 байгууллагын 21 хөгжүүлэгчийг хамруулав.
101. Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэд болон ахмад настай иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх 14 цагийн сургалтын хөтөлбөр боловсруулан “И-Монгол академи”-ийн Цахим ур чадвар хөгжүүлэлтийн албаны сургагч багш нартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 35, ахмад настай 105 иргэнийг сургалтад хамруулав.
102. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор сонсголын бэрхшээлтэй иргэдийг Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээллийг хурдан шуурхай, хүртээмжтэй хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор “Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо” ТББ сонсголын бэрхшээлтэй иргэдэд гамшгаас хамгаалах бэлэн байдалтай холбоотой мэдээлэл зөвлөгөө өгөх үүрэг бүхий “Дохионы хэлний видео дуудлага” фейсбүүк пэйжийг 24 цагаар ажиллуулсан. Энэ хүрээнд 6 дохионы хэлмэрч орчуулагч тодорхой цагийн хуваарийн дагуу гэрээр зайнаас болон оффист ажилласан бөгөөд өдөрт дунджаар 20-30 гаруй дуудлага ирсэн байна.
103. Улсын бүртгэлийн ерөнхий газар албан ёсны www.burtgel.gov.mn цахим хуудсаар дамжуулан хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулсан аудио, дохионы хэлмэрчтэй видео болон текст мэдээ, мэдээллийн үсгийн фонтыг томруулж унших боломжийг бүрдүүлсэн платформыг хөгжүүлсэн. Тус платформыг ашигласнаар “Цахим Монгол” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг сайжруулах зэрэг тэргүүлэх чиглэлийн зорилтыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм.
104. Нийслэлийн Улсын бүртгэлийн газраас “Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан улсын бүртгэлийн үйлчилгээний гарын авлагыг 200 ширхэгийг брайл үсгээр хэвлүүлэн бүх дүүргийн нэг цонхны үйлчилгээний танхим, хорооны ажлын байранд байрлуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээлэл хүргэж байна.
105. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудаст орсон эрх зүйн актыг сонсголын бэрхшээлтэй иргэд “чимэгэ” системийн тусламжтай сонсох боломжийг бүрдүүлснээс гадна харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан үсгийн хэмжээг 3 төрлийн хэмжээтэй харах боломжтой болсон.
106. Улаанбаатар хотын хэмжээнд 160 уулзварт тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио байгаагаас 46 байршилд тоноглогсон, дуут дохио бүхий гэрлэн дохио ажиллаж байна.
107. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, хувиараа хөдөлмөр, бичил бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнесийн үйл ажиллагааны стандартыг хангаж ажиллахад чиглэсэн мэдлэг, мэдээлэл өгөх зорилгоор 2021 онд “Үжин тайж студи” ТББ-тай хамтран “Хүнсний стандартчилал, сав баглаа боодлын стандартчилал”, “Баталгаажуулалт тохирлын үнэлгээ”, “Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн стандартчилал”, “Тохирлын үнэлгээний тогтолцоо”, “Хумс заслын үйлчилгээний ерөнхий шаардлага”, “Үсчний газрын стандарт түүнд тавигдах шаардлага, хамрах хүрээ, нийтийн хоолны стандартчиллын тухай” 8 сэдвээр видео хичээлүүд боловсруулан дохионы хэлний орчуулага, тайлбартай бэлтгэн цахим орчинд байршуулж, түгээсэн.

108. ХЗДХЯ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхэнд хамаарах эрх зүйн баримт бичгийн эмхэтгэлийн төслийг боловсруулан “Иргэдийн оролцоо-2” төслийн санхүүжилтээр Монголын хараагүйчүүдийн үндэсний төвтэй хамтран тус бүр нь 153.000 төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг номыг нийт 4.590.000 төгрөгөөр хэвлүүлсэн.
109. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилтын хүрээнд НДЕГ, ННДГ холбогдох ажилтнууд болон дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэвэр, тэтгэмжийн байцаагч нарыг дохионы хэлний сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулав. Уг ажлын хүрээнд аймаг дүүргийн хэмжээнд 20 гаруй удаагийн сургалтаар давхардсан тоогоор 230 гаруй албан хаагчийг хамруулсан байна. Дохионы хэлэнд суралцсанаар сонсголын бэрхшээлтэй иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлэх нөхцөл бүрдсэн.
110. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх Нийгмийн даатгалын салбарын бодлогын шинэчлэл, хууль эрх зүйн мэдлэг олгоход зориулсан гарын авлагыг “брайль” хөрвүүлэлт хийж, хэвлэн бүх хэлтэст тараан хүргүүлэн, угтах үйлчилгээ, нэг цэгийн үйлчилгээнд байршуулсан.

Б. Замын болон нийтийн тээврийн хүртээмж:

111. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах ажлыг зохион байгуулах байгууллага болон ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулж, стандартын дагуу хүртээмжтэй дэд бүтэц хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн.
112. Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлөөс 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “хөгжлийн бэрхшээлтэй иргэд хот болон орон нутагт хөнгөлөлттэй үнээр зорчих” шийдвэр гаргасан. Уг шийдвэрийн дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллагууд дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:
- “МИАТ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны А/53 дугаар тушаалаар “МИАТ ТӨХК-ийн Нислэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөнгөлөлттэй зорчих зөвшөөрөл олгох журам”-ыг баталж хэрэгжилтийг хангаж байна. МИАТ ТӨХК-ийн нислэгээр 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар нийт 91 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олон улсын чиглэлэд 50 хувийн хөнгөлөлттэй тийз олгосон байна.
 - Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Замын даргын 2023 оны “Тариф батлах тухай” А/286 дугаар тушаалаар унтлагын вагонд 20 хувь, тасалгаат вагонд 30 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр шийдвэрлэсэн.
113. Зам, замын байгууламжид үнэлгээ хийх “Шалгах хуудас”-ыг 2020 онд анх удаа ашиглан, гадаад дотоод орчны хүртээмжийг сайжруулахаар “Түгээмэл хөгжил төв” ТББ-тай хамтран Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, МИАТ ТӨХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН зэрэг байгууллагад үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийн дагуу налуу шатыг шинэчлэх, авто зогсоолыг зориулалтын дагуу тохижуулах зэрэг ажлыг хийсэн.
114. Зам, тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “АПУ” ХХК-тай хамтран харааны бэрхшээлтэй иргэд, бага насны хүүхдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор явган хүний гарцын хажууд зогсож буй хүний хөдөлгөөнийг мэдэрч улаан, ногоон гэрэл ассаныг самбарт болон хоолойгоор зарлах авто замын ухаалаг гарцыг 2022 оны 01 дүгээр сард Монгол Улсад анх удаа Нийслэлийн Хан-Уул дүүрэгт ашиглалтад оруулсан. Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан дуут гэрлэн дохиог Бээжингийн гудамж, Бага тойруугийн баруун хойд уулзварын урд талын явган хүний гарц, Олимпын гудамж, ЮНЕСКО-ийн гудамжны баруун урд уулзварын хойд талын явган хүний гарц, Их сургуулийн гудамж, Ерөнхий сайд Амарын гудамжны Төрийн ордны зүүн урд уулзварын урд талын явган хүний гарц, Д.Сүхбаатарын

- гудамж, Жуулчны гудамжны Төрийн ордны баруун урд уулзварын баруун талын явган хүний гарцны хоёр талд тус тус байрлуулсан.
115. Зорчигчийн 482 дугаар вагоныг MNS:5876:2012 стандартыг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан дотоод нөөц бололцоогоо ашиглан өөрчлөн тоноглох зураг төслийг боловсруулан, техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж түүний дагуу өөрчлөн тоногложноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэргэнцэртэйгээ төмөр замаар хүндрэл чирэгдэлгүй, ая тухтай аялуулах боломжийг бүрдүүлсэн. Уг галт тэрэг нь 2020 оноос батлагдсан хуваарийн дагуу 7 хоногт 2 удаа аялж 216 удаагийн аяллаар 2160 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ая тухтай тээвэрлэн үйлчилж байна.
 116. Нийтийн тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд 1,239 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас шугам замд 992 тээврийн хэрэгсэл бүрэн хараагүй хүнд зориулсан зогсоолын нэр зарлах төхөөрөмжтэй, сонсголгүй хүнд зориулсан урсдаг дэлгэцтэй, тэргэнцэртэй хүний зорчих зориулалтын тоноглол бүхий 56 тээврийн хэрэгсэл байна.
 117. Нийслэлийн “Лавай” автобуудал, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Зорчигч тээврийн төв болон орон нутгийн автотээврийн төвүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөн шуурхай дугааргүй үйлчлэх “Тусгай цонх” гарган ажиллаж байна. Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд ХБИ, ахмад настан, 0-3 насны хүүхэдтэй хүмүүс, жирэмсэн эхчүүдэд зориулсан суудлын таних тэмдгийг автобусны 1, 2 дугаар суудалд байршуулсан бөгөөд www.transdep.mn сайтад байрлах онлайн тасалбар захиалгын системд уг суудлыг сонгох боломжийг олгосон. Орон нутгийн Автотээврийн вокзалуудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх тусгай өрөө, тусгайлсан суудал захиалга бий болгон ажилласан.
 118. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто машины зогсоолд тавигдах шаардлагыг сурталчлах зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүртээмжтэй зогсоол” контентыг 2021 онд хийж Зам, тээврийн хөгжлийн яамны сайт болон харьяа байгууллагын сайтад байршуулан сурталчилж байна.
 119. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын захирлын 2022 оны тушаалаар “Угтах үйлчилгээний заавар”-ыг шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна.
 120. “Буянт-Ухаа” нисэх буудалд үйлчилгээ үзүүлж буй “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-ны 1 кабиныг 2022 онд ХБИ үйлчлүүлэх стандарт хэмжээтэй болгон засварлаж, Нисэх буудлын үйлчилгээний тэргэнцрийн хүртээмжийг 4-өөр нэмэгдүүлсэн.
 121. 2020-2023 оны хооронд нийслэлийн 8 дүүрэгт явган замыг 356279 м.кв-аар нэмэгдүүлж, тухайн зам талбайд нэмэлтээр харааны бэрхшээлтийн иргэдийн зорчих орчныг бүрдүүлж хөтөч хавтанг байршуулж иргэдийн ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлсэн. MNS 4596:2014 стандарт, шаардлагын дагуу 2021-2022 онд 311 байршилд хөтөч хавтан байршуулж, налуу зам гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
 122. Улаанбаатар хотын хэмжээнд 156 уулзварт тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио байгаагаас 29 байршилд буюу Энхтайваны өргөн чөлөөнд 10, Наадамчдын замд 4, Их сургуулийн гудамжинд 1 тоногдсон, дуут дохио бүхий явган гэрлэн дохио ажиллаж байна.

В. Барилга, байгууламжийн хүртээмж:

123. Барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг боловсруулах, магадал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулж, гэрчилгээжүүлэхэд санал авах, оролцоог хангах, саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хийхэд оролцож ажиллах боломжтой мэргэжлийн зохих чадамжтай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн жагсаалтыг гаргаж, сургалтад хамруулан хүний нөөцийг бүрдүүлж, тус нөөцөд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагын төлөөллийг “барилгын үйл ажиллагаа”-нд сонголтоор заавал оролцуулан ажиллаж байна.
124. Барилга байгууламжийн норм нормативын сангийн хөрөнгөөр, тухайн жилийн сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2020 -2023 он хүртэлх хугацаанд 150 гаруй

- норм дүрэм, 80 гаруй стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулан, салбартаа хэрэгжүүлж, мөрдүүлэн ажиллаж байна.
125. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 123 дугаар тушаалаар "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 31-23-22/ барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийг баталсан. Энэхүү норм ба дүрэм хэрэгжснээр хүртээмжийг бодит амьдралд хэрэгжүүлэхэд захиалагч, зураг төсөл зохиогч, магадлан, барилгын гүйцэтгэгч, хяналтын байгууллагын харилцан уялдаа сайжирна. Энэ нь бүх хүний аюулгүй, илүү ая тухтай амьдарч, ажиллах, сурч боловсрон өөрийгөө хөгжүүлэх боломжтой архитектурын таатай орчинг төлөвлөж бүтээн байгуулахад техникийн чухал баримт бичиг болсон.
126. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр"-ийг Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/164, А/102 тоот хамтарсан тушаалаар батлуулсан.
127. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны А/02 дугаар тушаалаар төрөөс хэрэгжүүлж буй түрээсийн орон сууцны үйлчилгээний хамрах хүрээ, хүрээмжийг оновчтой тодорхойлох, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, үйл ажиллагааг бие дааж хэвийн хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ, түүнд хамрагдах зорилтот бүлгийн иргэдийн орлогын түвшин, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох ажлуудын хүрээнд төрийн өмчийн түрээсийн орон сууцны 1м.кв талбайн түрээсийн төлбөрийн хэмжээг тогтоох болон зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам"-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Түрээсийн орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдах хувийг 5% байсныг 10% болгохоор урьдчилан шийдвэрлэсэн.
128. Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулиудын дагуу Барилгын хөгжлийн төв нь хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх шатанд "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" /БНБД 30-01-04/, "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 31-23-22/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД 31-112-11/ болон холбогдох бусад норм, стандартын шаардлагыг хангуулан хянаж баталгаажуулан ажиллаж байна.
129. Засгийн газрын 2019 оны 108 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм" хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш магадлал хийгдсэн улс орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд хот байгуулалтын баримт бичиг, ТЭЗҮ, барилга байгууламжийн нийт 10401 зураг төсөлд магадлал хийж ажиллсан байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6917, худийн хөрөнгө оруулалтаар 3473, Гадаадын заал тусламжийн хөрөнгөөр 11 зураг төсөлд магадлал хийгдсэн байна.
130. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ажиллах, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээний чиглэлээр Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас санаачлан Монгол Улсад анх удаа харааны бэрхшээлтэй иргэд, сурагчдад зориулсан 4 төрлийн брайль газрын зургийг зохион, хэвлүүлээд харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн сурагчдын газар зүйн хичээлийн сургалтын хэрэгцээнд зориулан тус бүр 150 ширхэгийг хүлээлгэн өгөв. Үүнд:
- Дэлхийн газрын зураг;
 - Монгол орны засаг, захиргааны зураг;
 - 116 дугаар сургууль орчмын тойм зураг;
 - 116 дугаар сургуулийн хашаан доторх тойм зураг зэрэг болно.
131. Барилга, хот байгуулалтын сайд 21 аймгийн Засаг дарга нар, НЗД-тай байгуулсан 2020, 2021, 2022, 2023 оны гэрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад

хамруулах, ажлын байраар хангах, барилгын зураг төсөлд тэдний эрх, ашгийг хамгаалахад чиглэсэн шийдлүүдийг тусган хэрэгжүүлж байх, үйл ажиллагааг тогтмол тайлагнах” ажлыг тусгаж, хэрэгжүүлж ажиллах чиглэлийг өгснөөр орон нутагт 200 гаруй барилга байгууламжийг барьж ашиглалтад өгөхөд комисст ХБИ-ийг оролцуулан ажиллуулах, зарим барилгуудад үзлэг хийж, тэдний хэрэгцээнд нийцүүлэн шинэчилсэн ба байгууллагууд ХБИ-ийг авч ажиллуулах нь нэмэгдсэн. Тухайлбал: Увс аймгийн 28 хуучин эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгуудыг норм стандартын дагуу налуу шат, насны онцлогт тохирсон ариун цэврийн өрөөнүүдийг төлөвлөн барьж ашиглалтад өгсөн., улсын комисст ХБИ-ын ТББ-аас 2 гишүүнийг оролцуулсан.

132. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тушаал батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 2.2-т заасны дагуу Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалаас хамааран барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс томилогдон үзлэг шалгалт хийн ажиллаж үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан актыг баталгаажуулан ажиллаж байна. Тус комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагын төлөөллийг байнга оролцуулан ажиллуулж байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2008 оноос хойш гарсан дүгнэлт, холбогдох мэдээллийн улсын хэмжээнд нэгтгэн шилэн системд www.shilen.gov.mn оруулах Ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын сайдын 2023.05.05-ны өдрийн 104 дүгээр тушаалаар байгуулагдаж, 2008-2023 онд улсын хэмжээнд 8414 барилга байгууламжийн комиссын дүгнэлтийн мэдээллийг нэгтгэн бүрдүүлж, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн ба www.shilen.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулахаар ажиллаж байна.
133. Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 123 дугаар тушаалаар "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" БНБД 35-01-22 барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийг батлуулан мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Дархан-Уул аймаг: 77 барилгын архитектурын даалгаварт ХБИ-ийн эрх ашгийг хамгаалах шаардлагыг тусгасан.
 - Говь-Алтай аймаг: Шарга сумын Эрүүл мэндийн төвийн барилга, хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан 12 айлын 2 орон сууцны барилга байгууламжид ХБИ-ийн хэрэгцээнд нийцсэн пандус, ариун цэврийн байгууламжийг зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх захиалагчийн техник хяналтыг тавьсан.
 - Дорноговь аймаг: Аймгийн хэмжээнд байгаа барилга байгууламжуудад үзлэг хийсэн. Аймгийн нийт барилга байгууламжуудын 10% нь ХБИ-ийн хэрэгцээг хангах шаардлагад нийцэж байна. 34 барилгын төлөвлөлтийн зургийн ажлын даалгаварт ХБИ-ийн нийгмийн дэд бүтцийг хангах норм ба дүрэм, стандартуудыг биелүүлэх талаар тусган ажилласан.
 - Дундговь аймаг: ГХБХБГ, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс хамтран аймгийн төвийн 51 байгууллага, ААН-ийн барилгад үзлэг хийсэн. Эдгээрээс 5 барилга стандартын шаардлага хангаж, 46 барилга байгууламж шаардлага хангахгүй байгаа тул Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт, зөвлөмжийг тухайн ААН-д хүргүүлсэн. 4 байгууллага зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухайгаа мэдэгдсэн. Орон сууц, олон нийтийн 15 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварт ХБИ-ийн норм стандартыг тусгах талаар заалт тусгасан.
 - Өвөрхангай аймаг: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3, хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдах 15 барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт “ХБИ-д зориулсан барилгын төлөвлөлтийн норм БНБД31-101-04”, “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны шаардлага MNS6055:2009”, “Явган хүн, ХБИ-д зориулагдсан MNS5682:2006” стандартыг зураг төсөвт тусгах заалтыг

- оруулсан. Шинээр ашиглалтад орсон 8 барилгад налуу зам, ариун цэврийн өрөөг ХБИ-ийн хэрэгцээг хангахуйц байх шаардлагыг тавьж хэрэгжүүлсэн.
134. БХБЯ-ны харьяа "ТОСК" ТӨХХК нь Засгийн газрын 2016 оны 38, 169, 298 дугаар тогтоолуудаар Улаанбаатар хотод "Буянт-Ухаа 2", "Хангай" хотхонуудад зорилтот бүлгийн нийт 787 өрхийн 8% буюу 62 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, орон нутагт баригдсан түрээсийн орон сууцад зорилтот бүлгийн нийт 725 өрхийн 4% буюу 31 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан. Түүнчлэн "Залуус 1", "Солонго 1, 2" зэрэг түрээсийн орон сууцнууд ашиглалтад орох үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тодорхой хувийг эдгээр орон сууцад хамруулах боломж бүрдэнэ.
135. 02.3 кодтой "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах", 02.3.1 кодтой "Барилга байгууламжийн архитектур төлөвлөлтийн хэрэгжилтийг шалгах" хяналтын хуудсуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн талаар 10 асуудлыг тусган батлуулж, эрсдэлийг үнэлэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Хот байгуулалтын тухай хуулийн 20 дугаар зүйл, Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, 12 дугаар зүйлийн 12.1.6, 15 дугаар зүйл зөрчсөн бол Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1-ийн 1.1, 5-ын 5.1, 6-ын 6.1, 6.2, 7-ын 7.2 дахь хэсгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.38 дахь хэсэгт заасны дагуу хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцохоор хуульчлагдсан.
136. ХХҮЕГ-ын харьяа хөдөлмөр халамжийн үйлчилгээний байгууллагууд барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичиг "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 31-23-22/ ба бусад норм дүрэм, стандартуудын шаардлагыг хангасан эсэхийг тухайн орон нутгийн хэмжээнд өөрсдийн албан байгууллагын болон бусад байгууллагын гадна болон дотор байр талбайг холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран тохижилтыг хийн ажилласан байна. Тухайлбал, Сүхбаатар, Дархан-Уул, Дорноговь, Булган, Говьсүмбэр, Өвөрхангай аймгууд ХХҮГ болон нийслэлийн, БЗД-ийн ХХҮХэлтэс нь явган хүний зам, талбайн төлөвлөлт, техникийн шаардлага MNS 6808:2019, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин үндсэн шаардлага MNS 6055:2009-ийн дагуу бүтээн байгуулалтын ажил, зам талбайн тохижилт, барилгын орц гарц, ариун цэврийн өрөө зэргийг төлөвлөсөн зураг төслийн дагуу ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад оруулах талаар онцгой анхааран ажиллаж ашиглалтад оруулсан. Аймгуудын Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд орж норм, дүрэм стандартын шаардлага хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангуулах арга хэмжээ авч ажилласан байна.
137. Дархан-Уул аймаг ХБИ-дэд хүртээмжтэй орчин бий болгох, стандартыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмжийг 4 цэцэрлэг, 3 сургуулийн өргөтгөлийн ажилд хүргүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчныг бүрдүүлж, бүх шатны боловсролд тэгш хамрагдах боломжтой болсон. Сум дундын шүүхэд харааны бэрхшээлтэй иргэдийн брайл үсгэн товгор хаяг хийх, брайл самбар, брайл цагаан толгой, брайл үсэг шивэх 50 ширхэг брайл цаас, шивүүрийг байрлуулж, булан нээсэн.
138. Өвөрхангай аймаг Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоотой хамтран төрийн байгууллагуудад хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. Аймгийн 3 Өрхийн эрүүл мэндийн төв, 2 Багийн нэгдсэн төв, Нийгмийн даатгалын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, Хаан банк, Бүсийн оношлогоо эмчилгээний төв гэх байгууллагуудад зөвлөмжийн дагуу ажилласан эсэхэд хяналт хийн, зөвлөн тусалж, хүртээмжтэй орчны талаар харилцан санал хүсэлтээ солилцон ажилласан. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот

байгуулалтын газар, Тэргэнцэртэй иргэдийн холбоотой хамтран Нарны дөш, Уян сэтгэл, Түшиг дөлгөөн зэрэг Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд, 1-13 дугаар Багийн төвүүд, Төв барааны захын Хангамж, Андууд худалдааны төв болон Үүрэн холбооны Skytel, Gmobile-ийн орчны хүртээмжид үнэлгээ хийж, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.

139. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2020 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлүүлэх тусгай зөвшөөрлийг олгох журмын хүрээнд худалдаа үйлчилгээний байгууллага, хоол үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагуудад налуу замыг шинээр журмын дагуу хийж гүйцэтгүүлсэн байна.
140. ХБХХЕГ-аас “Түгээмэл хөгжил” бие даан амьдрах төвтэй хамтран 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл “Хүннүмолл”, “Гэгээнтэн төв”, “Улаанбаатар палас”, “Сансар худалдааны төвийн яармаг дахь салбар”, “Сinema next” зэрэг байгууллагуудад дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн үнэлгээг хийж, зөвлөмжийг хүргүүлсэн.
141. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/607, 2020 оны А/574 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/176 дугаар тушаалын дагуу Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Маршалын гүүрний баруун тал Туул голын урд эргийн 1,9 га газарт иргэдийн ая тухтай амрах, орчин нөхцлийг бүрдүүлсэн амралт зугаалгын талбай байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус ажил нь 2 үе шаттайгаар 2019-2020 онд хэрэгжсэн бөгөөд 1 дүгээр ээлжийн ажилд 14.5 м урт, 4.5 м өргөн түшиц хана бүхий налуу зам хийж хүлээлгэж өгсөн. Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Туул голын эрэг дагуух тохижилтын ажлын хүрээнд 14,5м урт, 4,5 өргөн түшиц хана бүхий налуу зам хийсэн.
142. Нийслэлийн харьяа эрүүл мэндийн бүх байгууллагууд налуу замтай бөгөөд ханын бариул, дуугүй хөтөч, үйлчилгээний ажилтан ажиллуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэд бэрхшээл хүндрэлгүй тусламж үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Шинээр баригдсан эрүүл мэндийн байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчин бүрдүүлэх гадаад дотоод тохижилтууд хийгдсэн. Үүнд: СХД-ийн нэгдсэн эмнэлэг, тус эмнэлгийн Баянхошуу дахь салбар, Туул тосгоны ЭМТ, ЧД-ийн 13, 14, 17 хорооны 3 ӨЭМТ, СБД-ийн 17-р хорооны ӨЭМТ, **НД-ийн** 1, 7 хорооны ӨЭМТ, ХУД-ийн Хүүхдийн эмнэлгүүд байна.
143. Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэгт ХБИ-дэд хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүнд хөнгөний зэргээс хамаарч дугаар харгалзахгүй үйлчлэх, хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг картаар, цахимаар сунгах, гэрийн эмчилгээнд хамруулах, утсаар зөвөлгөө мэдээлэл өгөх, ТББ-тай хамтран дэмжлэг үзүүлэх зэргээр тусламж үйлчилгээ үзүүлж байна.
144. Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газраас хот байгуулалт, тохижилт, нийтийн тээврийн салбарын чиглэлээр хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг боловсруулан, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/456, 2021 оны А/276 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд дагаж мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Эдгээр баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, ээлтэй байдлыг хангах, тэдний нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, тэмдэг тэмдэглэгээ аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх дараах шаардлагууд тусгагдсан.
 - Нийтийн бие засах газар
 - Чийрэгжүүлэх төхөөрөмж бүхий талбай / Спорт талбай / Биеийн тамирын талбай
 - Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага
 - Бага, дунд, ахлах сургуулийн гадна орчны ерөнхий шаардлага
 - Эрүүл мэндийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага
 - Төрийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага
 - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын харилцаа, үйлчилгээ, хувцаслалт, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл стандарт

- Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага
 - Нийтийн тээвэр зорчих гудамжны төлөвлөлт хийх удирдамж
 - Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтанд тавигдах шаардлага
 - Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах шаардлага
 - Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага
 - Ногоон байгууламж бүхий гудамжны төлөвлөлт хийх удирдамж
 - Авто машинаар зорчих гудамжны төлөвлөлт хийх удирдамж
 - Гудамжны уулзварын төлөвлөлт хийх удирдамж
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн техникийн зураг төсөл
 - Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах шаардлага
 - Такси зогсоолд тавигдах шаардлага
 - Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага
 - Хүүхдийн автобусанд тавигдах шаардлага
 - Такси үйлчилгээнд тавигдах шаардлага
145. Байгаль орчин, аялал жуулчлалын яам “КОЙКА”-тай хамтран Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийг 2020 оны Засгийн газрын 182 дугаар тогтоолоор байгуулсан. Төвийн барилгын хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:
- Барилгын төв хаалга руу тэргэнцэртэй иргэд саадгүй нэвтрэх зам, бариул, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан хаалга, хаалганы хажууд зориулалтын тэмдэглэгээ бүхий авто зогсоол 2, 1-3 давхрын шат болон ариун цэврийн өрөөний өмнө харааны бэрхшээлтэй хүнд зориулсан зориулалтын тэмдэг, бариул, 1-3 давхрын ариун цэврийн өрөөнд зориулалтын 3 суултуур, 1-3 давхарт зориулалтын бариулаар тус тус тоногловсон.
 - Цаг уур, орчны шинжилгээний газар хөгжлийн бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй үйлчлүүлэгч нарт зориулсан шатыг 2022 оны 07 сард стандартад нийцүүлэн хийлгэсэн.
146. СБД-ийн Засаг даргын Тамгын газартай хамтран ХБХХЕГ, ЕБ-ын 2 дугаар сургуулийн гаднах /СБД 7 дугаар хороо/, Ж.Батмөнхийн гудамжинд явган хүний зам, гарц, авто замын тэмдэг, тэмдэглэгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгож жишиг гудамжтай болсон. Цаашид СБД-т дэд бүтцийн хүртээмжийг хангахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр хүргүүлсэн.
147. Нийгмийн даатгалын байгууллага Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоотой хамтран НД-ын барилга, байгууламжууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үйлчлүүлэхэд тавигдах стандартад нийцсэн эсэхэд үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Тухайлбал Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Багануур, Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн барилга, байгууламж холбогдох стандартад нийцсэн эсэхэд үнэлгээ хийлгэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчинг бүрдүүлсэн. Мөн аймаг дүүргийн бүх нийгмийн даатгалын хэлтсүүдийн орох хаалганы шатыг налуу замтай, ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэйгээр тохижуулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэлтэст ирж үйлчлүүлэхэд саадгүй байх зорилгоор Хан-уул, Сонгинохайрхан, Багануур дүүрэг, Өмнөговь, Хөвсгөл, Дархан-уул, Говь-алтай аймгуудын нийгмийн даатгалын хэлтсийн гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан автомашины зогсоолыг тусгайлан гаргаж өгсөн.
148. Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэж буй Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд

ээлтэй байлгах чиглэлээр аймаг дүүргийн ЭХМК-ууд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Харьяа аймаг, дүүргийн Эрүүл мэндийн байгууллага дээр хуралдаж буй ЭХМК-ууд эмнэлгийн удирдлагуудтай хамтран хурлаар орж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүлээлгийн сандал, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй ариун цэврийн өрөө, эмнэлэг орох үүдийг налуу замтай болгон тохижуулсан байна.

- Сонгинохайрхан дүүрэг нь Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв байгуулан, Багануур дүүрэг нь Нийгмийн эрүүл мэндийн төвийн байранд, Баянхонгор аймаг нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн ордонд тус тус хуралдаж буй бөгөөд эдгээр байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй хүлээлгийн танхим, ариун цэврийн өрөө налуу зам, шат зэргээр тохижуулсан.

10 дугаар зүйл. Амьд явах эрх.

11 дүгээр зүйл. Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал

149. Онцгой байдлын ерөнхий газраас гамшгийн эрсдлийг бууруулах мэдлэг, чадварыг олон нийтэд олгох www.ontsquoisur.gov.mn сайтад 374 гаруй хичээлийг байршуулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгосон. Иргэдэд болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг олгох “Онцгой байдлын цаг” 15 минутын нэвтрүүлгийг 3 телевизээр 14 хоногийн давтамжтайгаар дохионы хэлмэрчтэйгээр хүргэж байна.
150. Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Дэлхийн зөн-Монгол” ОУБ-тай хамтран “Аврагч мазаалайн зөвлөмж” сэдэвт объектын болон ой, хээрийн гал түймэр, газар хөдлөлт, мөс цөмрөлт, үер усны аюул, хүчтэй цасан болон шороон шуурга зэрэг аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх 14 төрлийн телевизийн видео шторк, “Аюулгүй сургууль” инфографикийн шторкыг дохионы хэлмэрчтэйгээр хүргэсэн.
151. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас гамшагаас хамгаалах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулж улсын хэмжээнд 2020 онд 98 хүнийг 9 удаа 9 цагийн, 2021 онд 463 хүнийг 26 удаа 42 цагийн, 2022 онд 324 хүнийг 8 удаа 16 цагийн сургалтад хамруулсан. Хөгжлийн бэрхшээлийг нийгэмд зөвөөр таниулах “Бэрх биш ээлтэй аян”, “Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлье” нэгдсэн арга хэмжээ, Гал унтраах тактикийн сургуульд “Тэргэнцэртэй иргэнийг аврах ажиллагаа” сургалт, “Гал түймэр болон газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээ, “Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх” арга хэмжээ, “Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх” сэдвээр зохион байгуулсан сургалтуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамрууллаа.
152. УИХ-аас 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталж, тус хуульд иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, ажлын байрыг хадгалах, үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж байгууллага, цалин орлого нь тасалдсан иргэдэд тусламж үзүүлэх, бүх шатны сургалтын байгууллага цахим, зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх зэрэг арга хэмжээг шуурхай төлөвлөн, хэрэгжүүлэх зохицуулалтуудыг тусгасан. Үүнтэй холбогдуулан Засгийн газраас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд асардаг хүний байнгын асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлэх, хүнсний дэмжлэг шаардлагатай нэн ядуу өрхийн гишүүдийн хүнс худалдан авах эрхийг бичгийг нэмэгдүүлэн олгох, хүүхдийн тэтгэмжийг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг өрхийн

орлогыг дэмжих, тогтвортой байлгах зорилготой арга хэмжээнүүдийг авч ажилласан. Энэ хүрээнд ХНХЯ-аас дараах үйл ажиллагааг зохион байгуулсан:

- НҮБ-ын Хүн амын сан, Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр нийгмийн эмзэг хэсэгт дэмжлэг үзүүлсэн бөгөөд ХБИ-ийн хэрэгцээг судалж, тэдэнд зориулсан ариун цэвэр, эрүүл ахуйн 29 нэр төрлийн 400 ширхэг 44,4 сая төгрөгийн өртөг бүхий багцыг ХБИ-ийн гэрийн хаягаар нь хүргэсэн.
 - Бүгд найрамдах Турк улсын Хамтын ажиллагааны зохицуулах агентлаг (ТИКА)-ийн Улаанбаатар дахь Суурин төлөөлөгчийн газартай хамтран ХБИ-дэд дэмжлэг үзүүлэхээр 200 ширхэг хүнсний багцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 28 төрийн бус байгууллагад олгосон.
 - Хөдөлмөрийн эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөр”, ХНХ-ын сайдын 2021 оны А/49 дүгээр тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйлчилгээг 2021-2022 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийг шинэчлэн баталж, хувиараа бизнес эрхлэгч ХБИ-ийг ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамруулах арга хэмжээг ХХҮЕГ хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд ХБХХЕГ-аас Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр үйл ажиллагааг нь хязгаарласан ТББ, ААНБ-дад ажлын байр хадгалах дэмжлэг үзүүлэхээр арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн. Энэ хүрээнд 41 ААНБ-д ажиллаж байгаа 150 ХБИ-ийн ажлын байр хадгалах дэмжлэг болох 145,440,000 төгрөгийн санхүүжилт олгосон.
 - ХБХХЕГ-ын харьяа СЗСҮТ, ХБХСЗХТ-үүд нь Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны А/242/54, А/555/135 дугаар тушаалуудын дагуу мэргэжлийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжид тулгуурлан ЭМЯ, УОК-ын заавар зөвлөмжийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтлан коронавирусын халдвартай өвчтөнг хүлээн авч үйлчиллээ. Энэ хүрээнд төвүүд эмнэлгийн байрыг улаан, шар, ногоон бүсэд хуваан холбогдох бэлтгэл ажлыг ханган, эмч, ажилтныг сургалтад хамруулж харьяа дүүргийн цагдаагийн хэлтэс, шуурхай штабтай хамтран ажиллаж дараах үйлчилгээг үзүүлсэн:
 - ХБХСЗХТ нь 120 ор дэлгэн 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн хооронд коронавирусын халдвараар өвчилсөн нийт 732 өвчтнийг;
 - СЗСҮТ нь 32 ор дэлгэн, 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 31, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сар хүртэлх хугацаанд коронавирусын халдвараар өвчилсөн 365 өвчтнийг тус тус эмчиллээ.
153. Тандалт судалгаагаар коронавирусын халдварын магадлалтай, шинж тэмдэг бүхий тохиолдол илрэх бүрт шуурхай хариу арга хэмжээ зохион байгуулах баг бүрэлдэхүүнээрээ ажиллаж, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай хэрэгжүүлсэн.
154. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Ковид-19 цар тахлын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх үүднээс зайнаас харилцах шуурхай дуудлагын төвийг дохионы хэлмэрчтэйгээр ажиллуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, цар тахлын үр нөлөөг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүн коронавирусын халдвар авсан тохиолдолд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тухай зөвлөмж боловсруулан эрүүл мэндийн болон анхан шатны төрийн үйлчилгээний байгууллагад хүргүүлэн ажилласан. Мөн НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос гаргасан Ковид-19-ын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах зөвлөмжийг орчуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.

155. СЗСҮТ нь ДЭМБ-тай хамтран 21 аймаг, 9 дүүргийн эмнэлгийн эмч, ажилтан болон боловсролын байгууллагын багш, нийгмийн ажилтнуудад “Ковид 19 цар тахлын үед хөгжлийн бэрхшээлийг хамруулсан сэргээн засах тусламж үйлчилгээ болон сэтгэл зүйг дэмжих нь” сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж, нийт 250 хүн хамрагдлаа. Сургалтын үр дүнд ковидын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сэргээн засах тусламж үйлчилгээ болон ажиллах арга зүйн мэдлэгтэй болсон.

12 дугаар зүйл. Хуулийн өмнө тэгш байх эрх

156. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас 2022 онд баталсан бөгөөд тус хуулиар Эрүүгийн хуульд заасан хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байлдлын эсрэг, ялгаварлан гадуурхах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүн худалдаалах гэмт хэргүүдийн төлбөрийн чадваргүй, эсхүл 18 насанд хүрээгүй хохирогч, иргэний хэргийн тухайд хүүхдийн тэтгэлэг гаргуулах шаардлага гаргасан төлбөрийн чадваргүй нэхэмжлэгч, захиргааны хэргийн тухайд үл хөдлөх хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн төлбөрийн чадваргүй оролцогч, мөн Зөрчлийн тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн үйлдлийн улмаас эрх нь зөрчигдсэн хүүхэд, түүнчлэн эрсдэлт нөхцөл байдалд байгаа болон гэмт хэргийн гэрч хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэхээр эрх нь хангагдахаар зохицуулсан.
157. Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, өрх толгойлсон олон хүүхэдтэй эцэг, эх, төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран төрөөс хууль зүйн туслалцаа авах боломжийг бүрдүүлсэн. Энэ хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн:
- “Лигал сорс” ХХК буюу ILAW.mn-тэй 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан санамж бичгийн хүрээнд 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, бусад холбогдох хууль, журам, стандартыг олон нийтэд сурталчлан таниулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
 - ХХБХЕГ-ын байранд “Лигал сорс” ХХК-иас хуулийн зөвлөх ажилтан үнэ төлбөргүй ажиллаж брошур, гарын авлага, сурталчилгааны материал бэлтгэн хэвлүүлж иргэд олон нийтэд түгээсэн. Мөн компанийн хуулийн ажилтан хөгжлийн бэрхшээлтэй 40 гаруй иргэд, олон нийтэд утсаар болон цахимаар тогтмол үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, бусад холбогдох хууль, журам, стандартын талаар 43 сэдвээр нийт 20 контентыг хамтран бэлтгэсэн. Үүнээс 20 контентыг дохионы хэлээр орчуулан хүртээмжтэй байдлаар бэлтгэн www.llaw.mn сайтад байршуулсан.
 - “Барилгын зураг төслийг боловсруулахад баримтлах хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зорчих хэсгийн тухай”, “Барилга байгууламжийг анх байгуулах үед баримтлах явган хүний замын стандартын тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоолд тавигдах шаардлага” зэрэг 5 контентийг дохионы хэлний орчуулгатайгаар бэлтгэн ХБХХЕГ-ын www.gadpwd.gov.mn сайтад байршуулсан.
 - 2021 онд “Бэрх биш ээлтэй” нөлөөллийн аяны хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний аливаа олсон орлого нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах, Нийгмийн халамжийн тухай хуулинд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг төрөөс

дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүнд төрөөс үзүүлэх нийгмийн халамж, протез, ортопедийн хэрэгслийн талаарх мэдээллийг багтаасан 12 цахим постерийг бэлтгэж байгууллагын Facebook хуудсанд байршуулж олон нийтэд хүргэсэн.

13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох

158. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 4.6.3-д “шүүхээр үйлчлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх, ахмад настан, насанд хүрээгүй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авна” гэж заасан. Үүний дагуу зарим шүүхийн Тамгын газар дохионы хэлний сургагч багштай болж, шүүхийн захиргааны ажилтнуудыг дохионы хэлний сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан.
159. 2023 онд “Шүүхийн байрны нийтлэг стандарт”-ыг шинэчлэн батлахаар төлөвлөөд байна.
160. Нэхэмжлэлийн загварууд, нэхэмжлэл гаргахад бүрдүүлэх материал, гарын авлагыг брайлаар хэвлүүлж үйлчилгээний хэсэгт байршуулсан. Мөн 2022 онд Дархан-Уул аймгийн анхан шатны шүүх дохионы хэлний www.duudlaga.mn -аар дамжуулан хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцан шүүхийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.
161. Монгол Улсын хэмжээнд анхан болон давж заалдах шатны 116 шүүхэд 41 шүүхийн Тамгын газар ажиллаж байгаагаас 40 буюу 97.5 хувь нь тэргэнцэртэй хүмүүст зориулсан налуу замтай, 22 буюу 54 хувь нь хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан брайл үсгээр хэвлүүлсэн шүүхийн үйл ажиллагааны талаарх гарын авлага, нэхэмжлэлийн загвартай, 9 буюу 22 хувь нь дохионы хэлмэрчтэй видео шторк бэлтгэн шүүхийн байр болон гадаах дэлгэцээр гарган мэдээлэл өгдөг бол 3 шүүхийн Тамгын газар хараагүй хүнд зориулсан хөтөч замтай. Мөн зарим шүүхийн Тамгын газар хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн видео дуудлагаар зөвлөн туслах үйлчилгээний ажилтнаар дамжуулан шүүхээр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэдээлэл өгөх, автомашины зогсоол, ариун цэврийн өрөө, босгогүй шүүх хуралдааны танхим, өрөө, тэргэнцэр, томруулдаг болон харааны шил, сонсголын аппарат, тусгай гэрэлтүүлэг, таяг зэргийг бэлтгэн байршуулж шүүхээр үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг авсан байна.
162. 7 шүүхийн Тамгын газрын нийт 18 албан хаагч Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар(хэлтэс), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны салбар зөвлөл, “Насан туршийн боловсрол” ТББ, “Үжин тайж студи” ТББ зэрэг байгууллагаас зохион байгуулсан дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалтад хамрагджээ.
163. 2020-2023 оны хооронд анхан болон давж заалдах шатны 116 шүүхэд 41 шүүхийн Тамгын газарт 700 хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлсэн байна.
164. Иргэн, эрүү, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний хүсэлтээр тухай бүр шүүгчийн захирамжаар хэлмэрчийг томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэлмэрчийн тусламж авах эрхийг хангадаг.
165. Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор нийслэлийн хороодын 154 нийгмийн ажилтнуудад “Олон нийтийн сүлжээний гадуурхал, хүчирхийлэлд өртөж буй хүүхдийг илрүүлэх, туслалцаа үзүүлэх” сэдвээр зохион байгуулсан 2 цагийн цахим сургалтын үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд холбон зуучлах үйлчилгээг үзүүлэх талаар мэдээлэл хийсэн.
166. Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, тэдэнд хууль эрх зүйн мэдлэг олгох, алба хаагчдад тэдний сэтгэл зүйн онцлогийг танин мэдүүлэх зорилгоор Хэвлэл, мэдээллийн төвөөс эмхэтгэн гаргадаг “Цагдаа” сэтгүүлийн “Албаны сургалт” буланд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй

- харилцах ажиллагаа, анхаарах асуудал” сэдэвт зайны сургалтын материалыг бэлтгэн нийтлүүлсэн.
167. ХБХХЕГ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах онцлог, анхаарах асуудал” нэртэй 500 ширхэг гарын авлагыг хэвлүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.
 168. Хоригдож буй сонсголгүй хоригдол, хоригдогч, баривчлагдсан этгээдийн эрхийг хангах, тэдний гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх, бүх төрлийн мэдээллийг дохионы хэлээр хэлмэрчлэн орчуулах үйлчилгээг үзүүлэх зорилгоор “Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо” төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр байгуулан, хамтран ажиллаж байна.
 169. 2020 онд 77, 2021 онд 164, 2022 онд 117 хоригдлын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгуулах, шинээр тогтоолгох ажлыг зохион байгуулсан.
 170. “Эрхэм чанар” протезын үйлдвэр, “Асралт төв” төрийн бус байгууллага, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоонд хөгжлийн бэрхшээлтэй хоригдолд ортопед, протез олгуулах хүсэлт хүргүүлэн, нийт 21 хоригдолд тэргэнцэр, харааны шил, таяг, сонсголын аппарат зэргийг олгосон.
 171. Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын эмч, сэтгэл зүйч нар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах анхан шатны мэдлэг олгох сургалтад хамрагдсан ба эмчилгээ, үйлчилгээ, сургалт мэдээллийн арга хэмжээнд сонсгох, дүрс бичлэг үзүүлэх зэрэг аргуудыг ашиглаж байна.
 172. 2021 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээлэл хүргэх зориулалт бүхий мэдээлэл дамжуулах төхөөрөмжийг суурилуулан үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын эрүүл мэндийн байдлыг харгалзан хөдөлмөрт хуваарилж, гар урлал, оёдлын цехэд ажиллуулан цалин хөлс олгож байна.
 173. Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангийн эмнэлэг нь 2022 оны 08 дугаар сард эмнэлгийн байранд 4.200.000 төгрөгийн өртөг бүхий урсгал засвар хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан стандартын шат, шатны бариулыг байрлуулсан.
 174. ХБХХЕГ болон ЦЕГ-ын 2019 оны 03/2019 дугаар “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн хүрээнд Улаанбаатар хотод оршин суугаа сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдээс яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг богино зурвас /sms/-аар тусгай дугаарын 101,102,103,105 утсанд (гал команд, цагдаа, эмнэлэг, онцгой байдлын байгууллага) хүлээн авах техникийн боломжийг бүрдүүлэхэд хамтран ажиллалаа. Энэ хүрээнд тусгай дугаарын утсанд мессэж илгээн шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй авах нөхцөл бүрдсэн. Энэ мэдээллээр постер сурталчилгааг бэлтгэн ЦЕГ-ын Мэдээлэл шуурхай удирдлагын www.eincenter.police.gov.mn ХБХХЕГ-ын цахим хуудас www.gadpwd.gov.mn цахим хуудсаар түгээсэн. Мөн сонсголгүй иргэдийн “Сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо”, “Монголын сонсголгүй иргэдийн үндэсний холбоо” болон Нийслэлийн 9 дүүрэгт мэдээллийг хүргүүлж, түгээсэн.
 175. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах, туслах журам”-ыг сайжруулах чиглэлээр Цагдаагийн Ерөнхий газартай хамтран ажиллаж, ЦЕГ-ын даргын 2020 оны А/114 дүгээр тушаалаар батлан цагдаагийн байгууллагын албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

14 дүгээр зүйл. Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх

176. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Билиг” дээд сургуультай хамтран 2020 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд 401, 407, 409, 421, 441 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж байгаа хоригдлууд болон Баривчлах төв, байрны баривчлагдсан этгээдүүдэд “Хүний эрхийн тухай ойлголт” сэдвээр сургалт зохион байгуулсан ба сургалтад нийт 708 хоригдол, 231 баривчлагдсан этгээд хамрагдсан.
177. Дорноговь, Өмнөговь аймгийн Цагдаагийн газар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэхэд зориулж тэргэнцэр байрлуулж, үйлчилгээ үзүүлж байна. Иргэдийг хүлээн

авах танхимд 2 төрлийн брайл үсгийн гарын авлага байршуулсан. Өмнөговь, Ховд аймгийн Цагдаагийн газрууд гадна талбайд тусгай тэмдэглэл бүхий авто зогсоол, Өмнөговь аймгийн Цагдаагийн газар тэргэнцэртэй иргэнд зориулан налуу зам, явган хүний замын голд товгор хавтан хийсэн.

178. Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ сонсьё” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 45 хүнийг оролцуулсан. Мөн “Гэр бүлийн өдөрлөг”-ийг 3 удаа зохион байгуулж, Улаанбаатар хотоос сургагч багш урьж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 20 эцэг эхийг 7 хоног “оёдлын сургалт”-д хамруулж, үнэмлэх олгосон.
179. Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын эрхийг хангах ажлын хүрээнд 2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 407, 421 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй 31 хоригдолд сургалтыг зохион байгуулсан.
180. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2022 оны 09 дүгээр сард “Хөдөлмөрийн тухай хууль, түүний онцлог зохицуулалт”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн талаар эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, Баянзүрх дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнийг хамруулсан.
181. Хүний эрхийн үндэсний комисстой хамтран 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр урьж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт алба хаагчдад “Хорих байгууллага дахь хүний эрх” сэдвээр сургалт зохион байгуулсан ба сургалтад нийт 2000 орчим алба хаагч хамрагдсан.
182. Хорих ял эдэлж буй хоригдлын эрхийг хангах чиглэлээр зохион байгуулах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран “Нийгмийн даатгалын сайн дурын даатгал, халамж, үйлчилгээний талаар”, “Билэг” дээд сургуультай хамтран “Хүний эрхийн тухай ойлголт”, “Хорих байгууллагын нөхөрлөл” төрийн бус байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хоригдолд зохион байгуулах “Өөрийгөө таньж, өөдрөг амьдрах нь сэдвээр видео сургалтын материалыг бэлтгэн хорих анги, байгууллагад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
183. Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хоригдолтой харилцах наад захын жишиг дүрэм, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг судлуулах, хууль эрх зүйн актыг ашиглах ур чадварыг сайжруулах, хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтыг тогтмол зохион байгуулсан.
184. Түүнчлэн Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн хэрэгжилт болон хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаарх үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, байгууллагуудад өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
185. **Цагдаа, шүүхийн алба хаагчдыг сургалтад хамруулсан талаарх мэдээллийг 78-82 дах хариултаас дэлгэрүүлж харна уу.**

15 дугаар зүйл. Эрүүдэн шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх

186. Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаарх бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах, гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж, зөвлөгөө өгөх, холбон зуучлах утсыг 24 цагаар ажиллуулах үүргийг хүлээж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажилладаг бөгөөд Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, Түр хамгаалах байр үйл ажиллагаа тогтмол явуулж байна.

187. Улсын хэмжээнд ажиллаж байгаа Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны үйл ажиллагаа, үйлчилгээнд болон хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод хийсэн дүн шинжилгээний тайлангийн хэлэлцүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс хамтарсан багийн гишүүдийн жишиг ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх, аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нарт харьяалах нутаг дэвсгэрт ажиллаж байгаа Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байруудын үйл ажиллагааг тогтмолжуулах, орон тооны ажилтантай болгох, орон нутгийн төсөвт зардал тусгуулах асуудлаар ажлын чиглэл хүргүүлсэн.

16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх

188. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн, сэтгэл зүйн, нийгмийн халамжийн, хүүхэд хамгааллын, эрх зүйн, холбон зуучлах зэрэг 7 төрлийн тусламж, үйлчилгээг 34 Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар дамжуулан үзүүлж байна. Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвд 2018-2023 оны 04 сарын байдлаар 18,463 хүн үйлчлүүлсний 68,3 % нь хүүхэд, 31,6%-ийг насанд хүрэгч байна.

189. 2023 эхний 4 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 35 Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвд шинээр ирсэн 1207 иргэнээс 937 хүүхэд /520 эмэгтэй 55,4%, 417 эрэгтэй 34,5%/ 270 насанд хүрэгч, урт хугацаагаар байрлан үйлчилгээ авч буй 217 иргэнээс 190 хүүхэд /105 эмэгтэй 55,2%, 85 эрэгтэй 44,7%/, 27 насанд хүрэгч нийт 1424 иргэнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 21 хүүхэд, 24 насанд хүрэгчийн аюулгүй байдлын хамгаалалтад авч үйлчилгээ үзүүлж байна.

190. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн мөрдөж эхэлснээс хойш хуулийг хэрэгжүүлэх 33 журам, 1 стандартыг батлан, хэрэгжүүлж байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авахаар хандсан тохиолдолд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч хэрхэн ажиллах талаарх зохицуулалт тусгагдаагүй байна.

191. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрнаас үзүүлэх үйлчилгээний удирдамжийг боловсруулж төр, төрийн бус байгууллагын дэргэдэх гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хамгаалах байрны дотоод хэрэгцээнд ашиглахаар батлан хэрэгжүүлж байна. Энэхүү удирдамжийн дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн амын сангийн Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь төслийн хүрээнд Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, зохицуулагч нийт 70 гаруй хүнд “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн Б.Чулуундолгор хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй үйлчилгээ үзүүлэх удирдамжийг танилцуулсан. Энэхүү удирдамж нь аймаг, дүүргийн Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байранд хохирогчоор ирж буй хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй үйлчилгээ үзүүлэх, мэргэжил, арга зүйн томоохон дэмжлэг болох юм

192. Хүчирхийллийн хохирогчид хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх www.etuslamj.mn мэдээллийн сайтыг ажиллуулж байна.

193. 2023 оны хагас жилийн байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд нийт 48,919 дуудлага ирснээс зорилтот дуудлага 26,070, зорилтот бус 22,849 дуудлага байна. Кейсийн тоо 4490, үүнээс хаагдсан кейс 2335, хяналтад 2155 байна. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн хүүхдийн эрхийн зөрчлийн

- дуудлага мэдээлэл, кейс шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанарыг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээлэл солилцох зорилготой кейс хэлэлцүүлгийн төлөвлөгөөг батлуулан, сард нэг удаа 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийг оролцуулан зохион байгуулж байна.
194. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүчирхийллээс ангид байлгах, тэдэнд төрийн үйлчилгээг хүртээмжтэйгээр хүргэх ялангуяа сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессеж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, 1800-0724 утас, www.duudlaga.mn дохионы хэлмэрчийн үйлчилгээг нэвтрүүлсэн. Үүнийг ковидын үеийн шуурхай дуудлага утас 119 дугаартай холбон сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэйгээр хүргэсэн.
- 195. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх хөтөч цагдаа хөтөлбөр”-ийн мэдээллийг 80, 81 дэх хариултаас дэлгэрүүлж харна уу.**
196. Аймаг, дүүргийн хууль сахиулах албан хаагчдыг “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт”-д хамруулж, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн уг сургалтын үеэр дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болгох, дэлхий нийтийн хөгжлийн бэрхшээлийн чиг хандлагын талаарх мэдээллийг энэ чиглэлээр мэргэшсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж байна. Одоогоор дээрх хөтөлбөрт 500 гаруй цагдаагийн албан хаагчид хамрагдсан.
197. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/116 дугаар тушаалын хавсралтаар “Цагдаагийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг шинэчлэн баталсан. Тус зохион байгуулалтын бүтэцэд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, хүүхдийн эрх, хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэйгээр Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийг шинээр байгуулж, орон тоог баталсан.
198. Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн ЕБС-д сурч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний асран хамгаалагч нарт “Сэтгэлзүйн хямрал түүнийг удирдах нь”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр лекц сургалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээс сэтгэлзүйн оношилгоо тест авч, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, асран хамгаалагч, хүүхдүүдтэй ажиллаж буй багш нарт сэтгэл зүйн болон хууль эрх зүйн ганцаарчилсан зөвлөгөө мэдээллийг нийт 307 хүүхэд, залуучуудад өгч ажилласан. Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийг 2019 оноос хэрэгжүүлж байна.
199. Дээрх төслийн хүрээнд түр хамгаалах байруудад хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх нөхцөл, дэд бүтцийг сайжруулах зорилгоор Увс аймаг, Сонгинохайрхан дүүргийн түр хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байдлаар байгуулагдахаар төлөвлөгдсөн. Увс аймгийн (406 м2, 29 өрөөтэй, 13 ортой) түр хамгаалах байрыг засварлан хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байдлаар тохижуулсан. Үүнд, тэргэнцэртэй хүнд хүртээмжтэй налуу зам, коридорт хананд суурилуулсан бариул, Хөгжлийн бэрхшээлтэй нд хүртээмжтэй дотроо тусгай тоноглолтой ариун цэврийн өрөөтэй 1 өрөөг тохижуулсан. Түүнчлэн 2023 онд Сонгинохайрхан дүүрэгт 446 м2, 2 давхар, 19 ортой түр хамгаалах байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байдлаар шинээр барьсан.
200. IRIM судалгааны хүрээлэнгээс тус төсөл хэрэгждэг Сонгинохайрхан дүүрэг, Налайх дүүрэг, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс аймгийн 220 хүнийг хамруулан 2020 онд хийгдсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн

талаарх судалгаа"-ны үр дүн, зөвлөмжид тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих бүлгийн үйл ажиллагааг төсөл хэрэгжиж буй 5 газарт хэрэгжүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хууль зүй, нийгэм, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн тусламж үйлчилгээний талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 30 сургагч багш (үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүн 15, хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагч 15) бэлтгэсэн. Сургагч нар төсөл хэрэгжиж буй 5 газарт нийт 25 дэмжих бүлэг байгуулж 125 хөгжлийн бэрхшээлтэй хүн, 152 асран хамгаалагчид зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажилласан.

17 дугаар зүйл. Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах

18 дугаар зүйл. Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх

201. Зорчих эрхтэй холбоотой мэдээллийг 109-120 дах хариултаас дэлгэрүүлж харна уу.
202. Өдөр тутамд эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээ, сувилгаа шаардлагатай байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн санал, гомдол, хэрэгцээ, шаардлагыг үндэслэн дугаарын хязгаарлалтгүй зорчих зөвшөөрлийг олгох асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Зам, тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан тоот хүргүүлж холбогдох зөвшөөрлийг ХБХХЕГ, Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран олгож байна. Тус зөвшөөрлийн бичгийг авахад бүрдүүлэх 7 төрлийн материалыг бүрдүүлэн хүлээн авч нэрсийн жагсаалтыг долоо хоног бүрийн баасан гаригт Замын хөдөлгөөний удирдлагын төвд бүртгэлжүүлэн илгээж байгаа бөгөөд 2021 онд 32 эцэг эхэд, 2022 онд (10 дугаар сарын 25-наас эхлэн авч эхэлсэн бөгөөд 11 дүгээр 14-ний байдлаар) нийт 85 эцэг, эхэд тус тус олгосон байна.

19 дүгээр зүйл. Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх

203. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/108 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Монголын хараагүйчүүдийн массажийн холбоо, Ахуй үйлчилгээний ажилтны мэдээлэл зөвлөгөөний Чандмань төв төрийн бус байгууллага зэрэг байгууллагуудын төлөөллийг оролцуулан “Алжаал тайлах бариа заслын үйлчилгээний стандарт MNS6922:2021”-ыг боловсруулан баталсан.
204. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/187 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, “Хувийн туслах үйлчилгээнд тавигдах шалгуур”, “Зөвлөлдөх бүлэг буюу харилцан суралцах, зөвлөгөө өгөх үйлчилгээнд тавигдах шалгуур”-ыг шинэчлэн баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд 2021-2022 онд ХБХХЕГ нь “Түгээмэл Хөгжил” төвтэй хамтран 2021-2022 онд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх “Хувийн туслах бэлтгэх” сургалт зохион байгуулах, хөдөлмөрт бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, зөвлөгөө мэдээлэл өгөх 61,270,000 төгрөгийн санхүүжилтэй туршилтыг төслийг хэрэгжүүлсэн. Тус туршилтын төсөлд хувийн туслах үйлчилгээний дэмжлэг шаардлагатай 35 хөгжлийн бэрхшээлтэй хүн хамрагдаж, 100 орчим хувийн туслах ажилтан бэлтгэж, хувийн туслах үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нь нийцсэн үйлчилгээ болгож хөгжүүлснээр хөдөлмөр эрхлэх, нийгмийн амьдралд бусдын адил эрх тэгш оролцох, асран хамгаалагч нь хөдөлмөр эрхлэх боломжтой гэдгийг туршилтын судалгааны үр дүн харуулсан байна. Бэрхшээлийн төрлөөр нь авч үзвэл харааны бэрхшээлтэй 5, полимлеттэй 3, Даунтай 1, хавсарсан

- бэрхшээлтэй 1, нуруу нугасны гэмтэлтэй 11, хүзүү нугасны гэмтэлтэй 6, сонсголын бэрхшээлтэй 3, тархины саажилттай 5 иргэн тус тус хамрагдсан байна.
205. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, аргачлал”-ыг Нийслэлийн Баянгол, Хан-Уул дүүргийн хороодын хөдөлмөр, халамжийн нийт 216 ажилтнуудад танилцуулах сургалтыг 2023 оны 06 дугаар сард зохион байгууллаа. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэн хорооныхоо хөдөлмөр, халамжийн ажилтанд хандаж, батлагдсан асуумжийн дагуу нэг сард хэдэн цагийн хувийн туслахын үйлчилгээ авч болох талаар нөхцөл байдлын үнэлгээг хийлгэж үйлчилгээнд хамрагдах эрх нээгдэх юм. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувийн туслах үйлчилгээний зардлын 90 хувийг санхүүжүүлнэ.
206. Түгээмэл Хөгжил төв, Тэгш хүртээмж бие даан амьдрах төв, Бяцхан жаал хүү ТББ, Гэрэлтэх гэгээн ирээдүй гэрэлт ТББ, Хүмүүн бие даан амьдрах төв (Орхон аймаг) Хөтөч анд бие даан амьдрах төв (Завхан аймаг) хувийн туслах үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэлийн гэрчилгээг авсан байна.
207. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд, ялангуяа зочид буудал, жуулчны бааз бусад газруудын стандартыг шинэчлэн боловсруулж зочлох, байршуулах үйлчилгээ авч буй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тав тухтай үйлчилгээ авах үзүүлэлтүүдийг нарийвчлан тусгаж байна. Энэхүү стандартын шаардлагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан өрөөтэй байх, орох хаалга налуу байх, лифтийн товчлуур брайлаар бичигдсэн байх, өрөөн доторх хөдөлгөөн төвөггүй байх гэсэн заалтууд тусгагдсан. Одоогийн байдлаар улсын хэмжээнд 3-5 одны зэрэглэлийн шаардлага хангасан 86 буудал байна.
208. Аялал жуулчлалын салбарт 11 стандарт мөрдөгдөж байна. Үүнээс 2 стандартад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хамгааллыг тусган хэрэгжүүлж байна.
- Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019 стандартын 4.4.2 “Амралтын газар, жуулчны бааз нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах, үйлчлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна”;
 - Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор MNS 5537:2016 стандартын 5.11 “Үйлчилгээний цогцолбор нь “Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Авто замын байгууламж. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага” MNS 5682:2006 стандартуудын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж тусгасан.

20 дугаар зүйл. Хувийн хөдөлгөөн

209. 2020-2022 оны хооронд нийт 3848 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд протез, ортопед, туслах хэрэгсэл, тэргэнцэрийг олгосон байна.
210. Тайпэйн худалдаа эдийн засгийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газар болон бусад олон улсын байгууллагуудтай хамтран тусгай хэрэгцээт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд хэрэглэх зориулалттай туслах хэрэгслийг хандивласныг хүлээн авч нэн шаардлагатай иргэдийн бичиг баримтыг үндэслэн жил бүр үнэ төлбөргүй олгож ирсэн. 2020-2022 оны байдлаар нийт 592 иргэнд шаардлагатай байгаа тэргэнцэр, туслах хэрэгслийг олгосон байна. Тухайлбал, 2020 онд 200 иргэнд, 2021 онд 274, 2022 онд 118 туслах хэрэгслийг тус тус олгосон байна.
211. Чанар стандартын шаардлага хангахгүй, чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлэх, ойлголт, мэдлэг хандлагагүйн улмаас иргэнд олгох ёстой бүтээгдэхүүнийг олгохгүй орлуулж өгөх, таарч тохирохгүй хэрэгсэл хэрэглэснээр гарч болзошгүй хоёрдогч хүндрэл, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, зөв хэрэглээ, дадал, хандлага, ойлголтыг нэмэгдүүлэх, салбар дундын уялдаа холбоог хангах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, ХБХХЕГ-ын харьяа Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн Протез, ортопедийн үйлдвэртэй танилцаж харилцан туршлага солилцсон зөвлөн туслах сургалтыг

ХБХХЕГ, ХХҮЕГ-тай хамтран 4 дэх жилдээ зохион байгуулж байна. 2019 онд 30 гаруй байгууллага, 2020 онд 40 гаруй байгууллага, 2021 онд 40 гаруй байгууллага, 2022 онд 30 гаруй байгууллага хамрагдсан.

212. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд протез, ортопед, тусгай хэрэгсэл дотоодод захиалгаар хийх болон гадаад улсад үйлдвэрлэсэн ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлэх байгууллагын жагсаалтаар нийт 140 гаруй байгууллагуудыг хамруулсан.
213. ЭМЯ-ны харьяа ЭМБ-д 51.323.536 төгрөгийн санхүүжилт бүхий 258 ширхэг тэргэнцэрийг олгосон.

21 дүгээр зүйл. Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө

214. Сонсголын бэрхшээлтэй хүнд мэдээлэл хүргэх хүрээнд Засгийн газрын мэдээллийг болон Төрийн ордонд зохион байгуулагдаж буй бүх чуулга, уулзалт, төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагааны хэлэлцүүлгийг дохионы хэлмэрчтэйгээр зохион байгуулж байна.
215. СЗСҮТ-ийн МБУЧОС нь Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн дэмжлэгтэйгээр Сонсголгүй иргэдийн ТББ-ууд, 29 дүгээр Тусгай сургууль, дохионы хэлний багш нартай хамтран “Монгол дохионы хэлний хэлмэрч” мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэхээр “Монгол дохионы хэлний хэлмэрч” мэргэжлийн “МБС-ын стандарт, хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/67 дугаар тушаалын дагуу 2 жилийн хугацаатай, мэргэжлийн V-VI түвшинд бэлтгэх туршилтын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр 2021-2022 оны хичээлийн жилийн II улирлаас буюу 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Монгол дохионы хэлний хэлмэрч мэргэжлийн ангид 20 суралцагчийг элсүүлэн суралцуулж байна.
216. Дохионы хэлний болон ХБИ-тэй ажиллах арга зүй, Сонсголгүй хүний соёл, Дохионы хэлний анхан шатны сургалтыг 2021 онд 12 гаруй байгууллага, 120 багш, ажилтнууд, 2022 онд 6 байгууллага, 50 орчин багш, ажилтнуудад зохион байгуулан хос хэлний боловсролыг олгох зорилго тавин ажиллаж байна.
217. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/49 дүгээр тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, үйлчилгээг 2021-2022 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийг шинэчлэн баталсан бөгөөд Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч болон орон зайн чиг баримжааны сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах арга хэмжээ нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн цогц арга хэмжээ үзүүлэх” арга хэмжээнд багтаан нэмэлт өөрчлөлт оруулж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн зохион байгуулахаар тусгагдсан. Уг арга хэмжээнд нийт 79 ХБИ хамрагдаж сонсголын бэрхшээлтэй 10 иргэн дохионы хэлмэрч багшаар чиглүүлж, харааны бэрхшээлтэй 16 иргэн хөтөч, чиглүүлэгчээр чиглүүлж дадлагажин ажиллаж байна.
218. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 14 алба хаагч дохионы хэлний хэлмэрч, хөтөч хийх чадвартай ба мэдлэгийн түвшинг ангилан харуулбал сайн 5, дунд 9 байна.
219. Улсын бүртгэлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан, тэдний нийгмийн оролцоо, мэдээлэл авах эрхийг хангахад зориулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын вэб хуудсан дээр хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан 45 удаагийн текст болон аудио мэдээг бэлтгэн байршуулсан байна. Мөн 12 видео мэдээг дохионы хэлмэрчтэй бэлтгэн байршуулсан байна.
220. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг тусламж үйлчилгээг сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор лавлагаа үйлчилгээний 1 ажилтан, угтах үйлчилгээний 1 ажилтныг дохионы хэлний хэлмэрчийн сургалтад хамруулан, тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.
221. Хууль зүйн туслалцааны төв нь 2022 оны 11 дүгээр сарын байдлаар телевизийн нэвтрүүлэг, мэдээ, подкастад 10 удаа мэдээ, ярилцлага өгч ажилласнаас 2022 оны 09

дүгээр сарын 14-ний өдөр шууд дамжуулалтыг дохионы орчуулгатай Улсын Их хурлын хуулийн цаг нэвтрүүлгээр Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын танилцуулга хийсэн.

22 дугаар зүйл. Хувийн нууцыг хүндэтгэх

222. Монгол Улсын Засгийн газраас 2021 онд Хувь хүний нууцын тухай хуулийг шинэчлэн “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийг баталсан. Тус хууль нь Монгол Улсын иргэдэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран тэгш үйлчилнэ.

23 дугаар зүйл. Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх

223. Гэр бүлийн тухай хуулийн төслийг өргөн олон нийтэд танилцуулах хэлэлцүүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулж саналыг авч ажилласан. Тухайлбал, 2023 оны 04 дүгээр сарын 10-ний өдөр Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ээлжит хэлэлцүүлгийг тусгайлан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн чиглэлээр ажилладаг төр, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, саналыг авсан ба саналуудыг нэгтгэж ХЗДХЯ-ны Ажлын хэсэгт хүргүүлсэн. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлаар тусгагдсан тусгайлсан заалтыг 8 дугаар хариултаас дэлгэрүүлж харна уу.
224. Хөгжлийн бэрхшээлтэй 16-18 насны охидод нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар сургалтыг 60 гаруй охид, хөвгүүдэд, 7 удаагийн бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 54 эцэг, эх, асран хамгаалагчдад, ДЭМБ-тай хамтран “Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлага-удирдамжийг олон нийтэд сурталчилан таниулах” сургалтыг 2022 оны 04 дүгээр сард 30 ажил олгогч байгууллагуудад, 05 дугаар сард ХБХСЗХТ, 70 дугаар сургуулийн багш нийгмийн ажилтнуудад, хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх сургалтыг 3 удаа нийт 310 хүнд зохион байгуулсан.
225. ХБХСЗХТ нь 2020-2023 онд 23 удирдамжийн хүрээнд 61,580 хүнд хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг, ойлголтыг сургалтаар болон, аян өрнүүлэх хэлбэрээр зохион байгуулж, төвөөр үйлчлүүлэгч эцэг эх, асран хамгаалагч, төр, төрийн бус байгууллагуудад хүргэсэн байна.
226. 2020 онд ГБХЗХГ болон ХБХСЗХТ-ын хооронд 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан 155 тоот гэрээний хүрээнд Эцэг эх, асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй “Аами Таами” тасагт 22 хүүхдэд эрүүл мэндийн болон тэгш хамруулах, нийгмийн сэргээн засалтын тусламж үйлчилгээг үзүүлсэн.
227. 2021 онд “Аами Таами” тасагт хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай 4-16 насны 17 хүүхэд эмчилгээ, үйлчилгээнд хамрагдсан. “Өнөр бүл” хүүхдийн төвөөс 9, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрнаас 6, Хүүхдийн төв сувилалаас 1, “Цөлийн сарнай” хүүхдийн төвөөс 1 зэрэг төрөлжсөн асрамж, газруудаас тус тус хүлээн авсан.
228. 2022 онд Урт хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээнд давхардсан тоогоор 49 хүүхэд хамрагдсан ба Өнөр бүл хүүхдийн төвөөс 17, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрнаас 6, Дархан-Уул аймгийн “Нарны хүүхдүүд” асрамжийн төвөөс 2, Манай гэр асрамжийн төвөөс 6, SOS хүүхдийн төвөөс 8, Өвөрхангай аймгийн ГБХЗХГ-аас 2, Төв аймгийн Түр хамгаалах байрнаас 1, ЧД-ийн Түр хамгаалах байрнаас 2, СБД-ийн Түр хамгаалах байрнаас 1, СХД-ийн Түр хамгаалах байрнаас 1, БГД-ийн Түр хамгаалах байрнаас 1, Ховд аймгийн Түр хамгаалах байрнаас 1, Хүүхэд залуучуудын цогцолбороос 1 хүүхэд тус тус хамрагдсан байна. Тус хүүхдүүдийг хяналтад авснаар эмчилгээ, үйлчилгээнд цаг тухайд нь хамруулах, хяналтын дэвтэр нээх, цахим мэдээллийн сан бий болгож эхэлсэн.

229. Монгол Улсад нийт 21 байгууллагын 31 халамж, асрамжийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 26, Дархан-Уул аймагт 2, Дорнод аймагт 1, Орхон аймагт 1, Өвөрхангай аймагт 1 төв ажиллаж байна. Эдгээр төвүүдээс 3 төв нь улсын төсвөөс, 28 төв олон улсын болон төрийн бус байгууллага, хувь иргэний санхүүгийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэшсэн, цогц, гэр бүл төвтэй байх тухай хуульд заасан зарчмыг баримтлан, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос ирүүлсэн сүүлийн 3 зөвлөмжийн дагуу төвлөрсөн асрамжийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд үе шаттайгаар шилжүүлэхийг зорьж, 2017 онд “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS5852:2017” стандарт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/209 тушаалаар “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам” болон холбогдох бусад журам, стандартыг баталж, хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Асрамж, халамжийн төвүүд Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг мөрдөн, гэр бүлдээ дүйцэхүйц орчин бүрдүүлж, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлсэн нийгэмшүүлэх, хөгжүүлэх, бие даан амьдрах хөтөлбөр хэрэгжүүлж, хүүхэд бүрийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулан, боломжтой тохиолдол бүрд Хамтарсан баг болон орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтсүүдтэй хамтран хүүхэд, тэдний гэр бүлийг дэмжих үйлчилгээ үзүүлж, боломжтой тохиолдол бүрд гэр бүлд нь эргэн нэгтгэх, бусад хувилбарт үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж байна. Мөн 18 нас хүрч бие даан амьдрах, мэргэжил эзэмших, ажил орлоготой болгоход дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
230. Асрамж, халамжийн төвүүдэд 2020 онд 1069, 2021 онд 1031, 2022 онд 1035 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 77 хүүхэд, залуус байна.
231. Аймаг, дүүргийн Гэр бүлд зөвлөгөө өгөх төв, Залуучуудын хөгжлийн төвийн зохион байгуулж буй сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үйлчилгээнд жилд дунджаар зорилтот бүлгийн 20-40 хувь үйлчлүүлдэг бөгөөд одоогоор үйлчлүүлэгчдийн тоог хүйсээр болон хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр гаргадаггүй байгаа хэдий ч ХБИ-д хамрагдан үйлчлүүлэх бололцоотой.
232. Хүүхдийн Тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 2020-2022 онд нийт 323201 дуудлага мэдээлэл ирсэн. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой асуудлаар 21 дуудлага байгаагийн 5 дуудлага мэдээллийг орон нутгийн ГБХЗХГ, дүүргийн ГБХЗХХ-т шилжүүлж, 5 дуудлага үйлчилгээ үзүүлээд хаасан байна. 0-18 насны хүүхдийн нийт 67403 мэдээлэл бүртгэгдсэн байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй 99 хүүхдийн бүртгэл мэдээлэл байна. Орон нутгийн ГБХЗХГ-т шилжүүлсэн дуудлагын хувьд хүүхдийн асаргааны мөнгөн тэтгэмж өгөхгүй байгаатай холбоотой мэдээлэл байна.
233. 2023 оны 01-05 дугаар сард нийт 48931 дуудлага мэдээлэл ирсэн. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой асуудлаар 1 дуудлагад зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. 0-18 насны хүүхдийн нийт 7109 мэдээлэл бүртгэгдсэн байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй 24 хүүхдийн бүртгэл мэдээлэл байна.
234. Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төвд ирсэн дуудлага бүрийн дагаа хариу үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө мэдээллээр ханган шаардлагатай тохиолдолд кейс нээж асуудлыг шийдвэрлэн ажилладаг.
235. Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-д “Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ.” гэж заасан. Хүүхдийг ямар ч тохиолдолд эцэг эхийн аль нэг нь, эсхүл хоёулаа, эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар хүүхдийг эцэг эхээс нь тусгаарладаггүй. Хүүхдийг аль болох эцэг, эхтэй нь гэр бүлд нь болон гэр бүлийн орчинд амьдруулахыг анхаардаг.

236. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74,1-д заасны дагуу иргэн гэр бүлдээ авч, өөрийн зардлаар асран хүмүүжүүлж болдог.

24 дүгээр зүйл. Боловсрол

237. Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 0-18 насны 11,835 хүүхэд байна. 2022-2023 оны хичээлийн жилийн эхэнд бүх шатны сургалтын байгууллагад нийт 1.195.6 суралцагч суралцаж байна.² Тэдгээрийн 8228 буюу 0,7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Эдгээрийн 1498 нь сургуулийн өмнөх боловсролд, 5673 нь ерөнхий боловсролд, 643 нь мэргэжлийн боловсролд, 414 нь их дээд сургуульд суралцаж байгаа бөгөөд нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 64 хувийг боловсролд хамруулсан байна.

238. Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургадаг 2 тусгай цэцэрлэг, 6 тусгай сургууль үйл ажиллагаа явуулдаг. Тусгай цэцэрлэг, сургуульд нийт 1993 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Энэ нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн 27.7 хувь болж байна. Өөрөөр хэлбэл 72.3 хувь нь ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг сонгон суралцаж байна.

239. Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангахдаа тэгш хамран сургах зарчмыг түлхүү баримтлахыг эрмэлзэж байна. Манай улсын хувьд 2018 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын тогтоол 3, салбарын сайдын 14 журам, заавар, тушаал батлан хэрэгжүүлж байна. баримт бичгийг тоймловол:

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журамд нэмэлт оруулах тухай” 208 дугаар тогтоолоор³ ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэсэн,
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 208 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар”-ыг БСШУС-ын сайдын 2020 оны А/296 дугаар тушаалаар баталлаа. Энэхүү заавар нь 2021 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжиж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын орон нутаг дахь салбар комисс”-ын дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй болох нь тогтоогдсон хүүхэдтэй ажиллаж байгаа цэцэрлэгийн багш, туслах багш, бага, дунд, ахлах анги удирдсан болон хүүхэд хөгжлийн танхимын багш ажлын үр дүнгээ үнэлүүлж нэмэгдэл хөлс авах нөхцөл бүрдсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 235 дугаар тогтоолоор “Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээ”-г баталсан,
- Монгол Улсын Засгийн газрын Хувьсах зардлын дундаж норматив аргачлал батлах тухай 2022 оны 91 дүгээр тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсах зардлыг индексжүүлэн нэмэгдүүлэх зохицуулалтыг шийдвэрлэсэн. Энэ хүрээнд Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 тоот тушаалаар “Хичээл сургалтын үйл ажиллагааны зардал төлөвлөх, хуваарилах заавар” батлагдаж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ногдох хувьсах зардлыг 3 дахин индексжүүлж олгох, хичээл практикийн зардлын 5-аас багагүй хувийг суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн материал хэрэглэгдэхүүн авахад хуваарилах харилцааг зохицуулсан,

² Боловсрол шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээлэл 2022-2023, хуудас- 23

³ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2022

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/249 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл” баталсан,
 - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/305 дугаар тушаалаар “ Хэл ярианы хөгжил” сургалтын жишиг хөтөлбөр батлагдаж, хүүхдийн хэл яриаг засан сайжруулах, бусдын яриаг зөв ойлгох, өөрийгөө илэрхийлэх болон сургуульд дасан зохицох, унших, бичихийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдсэн,
 - Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/184 дүгээр тушаалаар “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам” баталсан,
 - Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/309 дугаар тушаалаар “Харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа, орон зай, хөдөлгөөний баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр” баталсан,
 - Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны А/177 тоот тушаал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах” журам, мөн сайдын 2022 оны Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө батлагдан гарснаар сургуулийн өмнөх боловсролд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн онцлогийг харгалзсан хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамран сургах, танхимын сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд хувилбарт сургалт, явуулын багшийн сургалт зохион байгуулах нөхцөл бүрдсэн,
 - Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/325 дугаар тушаал “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэхэд баримтлах чиглэл” батлагдсан нь 2018 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын хэрэгжилтийн үр дүнг тодорхойлоход хүүхэд, багш эцэг эхэд баримжаа болсон,
 - “Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэл”-ийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/553 тоот тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийн зорилго нь хүн бүрийн чанартай боловсрол эзэмших, сурч хөгжих эрхийг хангах, тэгш боломж олгох, сурах үйл ажиллагаанд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах бөгөөд энэхүү баримт бичгийн хүрээнд танхимын сургалтад хамрагдаж чадахгүй байгаа байнгын асаргаатай болон хэвтрийн хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх “Явуулын багшийн жишиг хөтөлбөр”-ийг Монгол хэл, Нийгэм ахуйн баримжаа хичээлүүдээр Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны А158 тоот тушаалаар баталсан. Явуулын багшийн жишиг хөтөлбөр хэрэгжсэнээр сургуулийн гадна байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлж, гэр бүлд суурилсан хөгжлийн дэмжлэг, эцэг эх боловсрол, сургалтын байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлж, аажмаар танхимын сургалтад цагийн зохицуулалттайгаар хамрагдах нөхцлийг бүрдүүлэх юм. Боловсролын ерөнхий газраас (2022 оны 3 дугаар сард Аймаг, нийслэлийн боловсрол, шинжлэх ухааны газар, хэлтсээс авсан судалгаагаар тухайн орон нутагт боловсролд хамрагдаагүй 6-17 насны 1878 хүүхэд байгааг илрүүлсэн).
240. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тэгш хамруулан сургах бусад суралцагчидтай хамтран сургах, оюутан солилцооны хөтөлбөрүүдийг 2021-2022, 2022 -2023 оны хичээлийн жилд МСҮТ, Политехникийн коллеж дээр хэрэгжүүлж дадлагын хичээлийг хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй суралцагчдыг хамтад нь зохион байгуулж байна.
241. Жил бүр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн олон улсын өдрийг угтан “Боловсролд тэгш хамруулан сургах” сургалтын ач холбогдлыг таниулах, хандлагыг өөрчлөх сургалт мэдээллийг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшлээ.
242. Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын

- 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.3 дахь заалтын дагуу Боловсролын зээлийн сангаас сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг 3 төрлөөр хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад олгож байна. Хөгжлийн бэрхшээлтэй 548, эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй 370, эцэг эх нь хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бакалаврт сурч байгаа 1699 суралцагчид нийт 4.396.3 төгрөгийн тэтгэлгийг 2022-2023 оны хичээлийн жилд олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дээд боловсролын салбарт суралцахад тогтмол дэмжлэг үзүүлж сүүлийн 6 жилд 1000 гаран суралцагчид 9 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон байна.
243. Монгол Улсын Их Сургуульд 2022 оны байдлаар 93 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж байгаа нь нийт суралцагчдын 0,5 орчим хувийг эзэлж байна. МУИС-д суралцагч хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Монгол Улсын Их Сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг дэмжих дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”-ийг МУИС-ийн Захирлын 2019 оны А/568 тоот тушаалаар баталж, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.
244. Боловсролын үнэлгээний төв нь хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч элсэлтийн ерөнхий шалгалтад бүртгэгдсэн тохиолдолд шалгалтын үед шаардлагатай тохируулгын талаар урьдчилан өргөдөл бичүүлж авч байна. Хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөд зориулсан тусгай өрөө бэлтгэх, шалгалтын цагийг уртасгах, шалгалтын даалгаврыг брайлаар, том форматаар хэвлэх, дохионы хэлмэрч, туслах багш ажиллуулах зэрэг дэмжлэг үзүүлдэг. Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тоо нэмэгдэж байгаа нь тэдний тусгай хэрэгцээг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаатай холбоотой байж болох юм. 2020 онд 13 шалгуулагч бүртгүүлж 12, 2021 онд 22 шалгуулагч бүртгүүлж 20, 2022 онд 31 шалгуулагч бүртгүүлж 31, 2023 онд 33 шалгуулагч бүртгүүлж 29 хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдсан байна. 2020-2023 онд элсэлтийн ерөнхийн шалгалтад нийт 99 хөгжлийн бэрхшээлтэй хүн бүртгүүлж, 92 нь шалгалтаа өгсөн байна.
245. Засгийн газрын 2020 оны 235 дугаар тогтоолд багш мэргэжлээр суралцаж буй оюутанд “Тусгай хэрэгцээт боловсрол” хичээлийг заавал судлах хичээлээр судлуулах зохицуулалт хийхийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгасан. 2020-2021 оны хичээлийн жилд “Тусгай хэрэгцээт боловсрол” хичээлийг МУБИС-д бусад мэргэжлээр сурч байгаа 281 оюутан сонгон судалсан. Цаашид дээрх хичээлийг заавал судлах хичээлийн жагсаалтад оруулах талаар МУБИС-ийн Боловсрол судлалын сургуульд болон багш мэргэжил олгож буй их дээд сургуулиудад чиглэл өгч хамтран ажиллаж байна.
246. ТХБ-ын багш бакалавр мэргэжлээр 2020-2023 онд нийт 4 удаагийн төгсөлтөөр нийт 64 оюутан төгсөж тусгай боловсролын салбарт ажиллаж байна. Тэдний мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлт 87-94 хувьтай байна. 2022-2023 оны хичээлийн жилд 1-3 дугаар курст нийт 42 оюутан тусгай хэрэгцээт боловсролын багш мэргэжлээр суралцаж байна.
247. 2019-2020 оны хичээлийн жилээс Тусгай хэрэгцээт боловсролын магистрын сургалт анх удаа элсэлт авч эхэлсэн. Энэ чиглэлээр 2 магистр төгссөн, одоо 12 оюутан магистрын хөтөлбөрт суралцаж байна. Тусгай хэрэгцээт боловсролын магистрын хөтөлбөрийг сайжруулахаар Японы Хёго боловсролын их сургуультай хамтарсан төсөл 2022-2024 онд хэрэгжүүлэн ажиллаж байна.
248. “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс” 2 кредитийн хичээлийг 2020 оноос хойш нийт 900 гаруй оюутан багш сонгон судалсан. Хөтөлбөрийн агуулгыг сайжруулан “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс” хичээлийг “Тэгш хамруулах боловсрол” болгон өөрчилж, ном гарын авлага боловсруулан ажиллаж байна.
249. Багшийн мэргэжил дээшлүүлэх, давтан бэлтгэх үйл ажиллагааг 2012-2021 он хүртэл Багшийн мэргэжил дээшлүүлэх институт хариуцан зохион байгуулж ирсэн. Монгол

- Улсын Засгийн газрын 2012 оны 180 тоот тогтоолын дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо дахин сэргэж, цэцэрлэг, ерөнхий боловсрол, насан туршийн боловсролын багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлэх болсон. Энэ үеэс Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтэд (БМДИ) тусгай хэрэгцээт боловсрол хариуцсан арга зүйчийн бие даасан орон тоо бий болж, тусгай хэрэгцээт боловсрол, тэгш хамран сургах боловсролын чиглэлээр багшийн хөгжлийг дэмжих нөхцөл бүрдсэн.
250. 2017 онд анх удаа сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр Тусгай сургуулийн багш ажилтнуудад “Дохионы хэлний эрчимжүүлсэн сургалт” зохион байгуулж багш нарын дохионы хэлийн чадварыг сайжруулсан нь Ковид -19 цар тахлын үед бэлтгэгдсэн, зайн сургалтын 2000 гаруй теле хичээлийг дохиожуулах хүний нөөц болж байв. Мөн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдаж байгаа бүх багш, ажилтнуудад тараагддаг гарын авлагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, тэгш хамран сургах боловсролын үзэл баримтлал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах эрх, суралцахуйн түгээмэл загварын талаар уншиж судлах материал бэлтгэн түгээн дэлгэрүүлдэг болсон.
251. 2020-2021 оны хичээлийн жилд мэргэжил дээшлүүлэх сургалт онлайн зайн хэлбэрт шилжиж, сургалтад хамрагдаж байгаа бүх багш, ажилтан тэгш хамран сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн хичээлийг заавал судлаад мэргэжлийн агуулгаа судалж дүгнүүлдэг тогтолцоонд шилжсэн. Мөн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтаас гадна захиалгат, сонголтод, төрөлжсөн сургалтаар сургалтын байгууллага дээр очиж, тухайн байгууллагын хэрэгцээнд тохирсон сургалт зөвлөн туслах үйл ажиллагааг жилдээ ойролцоогоор 20-30 сургалтын байгууллагад зохион байгуулж, багшийн арга зүйд дэмжлэг үзүүлж иржээ.
252. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Насан туршийн боловсролын үндэсний төвийг нэгтгэн Засгийн газрын 2021 оны 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Боловсролын ерөнхий газар”-ыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулсан. Боловсролын ерөнхий газрын Тэгш хамран сургах боловсролын хэлтэс ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хөгжил хамгаалал, сургалтын байгууллагын хүртээмжтэй орчин, багшийн хөгжлийн асуудлыг хариуцдаг болов.
253. 2021 онд ЮНЕСКО-оос зохион байгуулсан "Тэгш хамруулан сургах боловсролын үнэлгээ, төлөвлөлт" 14 орны оролцогчдыг хамруулсан олон улсын онлайн сургалтад Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр БШУЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн 6 мэргэжилтэн хамрагдаж, тэгш хамруулан сургах боловсролын төлөвлөлт, бодлого зохицуулалтын талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлж, туршлага судлан бодлого, хэрэгжилтэд тусган ажилласан.
254. 2020-2023 онуудад сургалт нөлөөллийн үйл ажиллагааг тогтмолжуулж, тэгш хамран сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэхэд бүх талын оролцоог чухалчлан постер, подкаст, анимейшнээр дамжуулан олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах ажлуудыг төсөл хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр тасралтгүй зохион байгуулж иржээ. Дээрх сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн Боловсрол шинжлэх ухааны газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга мэргэжилтэн 207, цэцэрлэг сургуулийн Дэмжлэгийн багийн гишүүн 280, цэцэрлэг багш, удирдах ажилтан 668, Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтан 2116, аймаг дүүргийн Салбар комиссын гишүүн 120, цэцэрлэг, сургуулийн Дэмжлэгийн багийн гишүүн 280, нийт 3671 хүнд сургалт, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаанд 4995 хамруулжээ.
255. Төрийн өмчийн багш бэлтгэх их дээд сургууль МУБИС түүний харьяа сургуулиуд, Ховд, Дорнод, Архангай аймгийн багш бэлтгэх сургуулиудын арга зүйн тэнхимийн

- багш нарт тэгш хамран сургах боловсролын агуулга, аргазүйн чиглэлээр 3 удаагийн сургалтыг МУБИС-иас зохион байгуулсан.
256. Хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох, тэгш хамран суралцах эрх, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх талаар олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөлөл, сурталчилгааны контентуудыг мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээн дэлгэрүүлэх ажлыг төсөл хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр тогтмол зохион байгуулж байна.
257. 2022-2023 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих тусгай болон туслах нэмэлт хэрэглэгдэхүүнийг худалдаж авахад зориулж улсын төсвөөс 100.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн бөгөөд худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, 80 цэцэрлэгт 25 нэр төрлийн 384 ширхэг тохирох хэрэглэгдэхүүнийг тус тус нийлүүлжээ.
258. ТИКА олон улсын байгууллагын санхүүжилтээр /21,0 сая төгрөг/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахад шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнийг нийслэлийн Сүхбаатар дүүргийн 51 дүгээр цэцэрлэгт нийлүүлэх ажлыг хийж байна. Мөн ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл-2” төсөлд үндэсний хэмжээнд, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ үзүүлэх бааз (тогтолцоо, төлөвлөгөө, хүний нөөц зэрэг) бүрдүүлэхээр туршилтын 2, түгээн дэлгэрүүлэх нийслэлийн 25, бүсийн төвийн 5 аймгийн 11 цэцэрлэг хамрагдсан. Тус төслийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх цэцэрлэг, нийслэлийн 25 цэцэрлэгт тус бүр 5,0 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тохируулгат хэрэгслийг нийлүүлсэн.
259. Азийн хөгжлийн банкны “Тэгш хамран сургах төсөл”-ийн хүрээнд 4 цэцэрлэгийн хүүхэд хөгжлийг дэмжих танхимд 36,630,000 төгрөгийн тавилга, 108,658,000 төгрөгийн компьютер, цахилгаан хэрэгсэл, 120,512,574 төгрөгийн жижиг тоног төхөөрөмж, 5,431,160 төгрөгийн ном, 20,630,000 төгрөгийн тоглоом нийлүүлэх ажил, 465.0 сая төгрөгийн өртөг бүхий хараа, сонсгол, харилцаа, суралцахуй, хөдөлгөөн, зан төлөв, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах үйлийг дэмжих сургалтын хэрэглэгдэхүүн, төхөөрөмж нийлүүлэх тендер зарлаж, шалгарсан компаниудтай гэрээ байгуулан ажиллаж, нийт 756,8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.
260. Цаашид ердийн цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн тусгай болон тохируулгат хэрэглэгдэхүүнийг жил бүр нийлүүлэх чиглэл баримталж байгаа бөгөөд 2023 оны улсын төсөвт 200.0 сая төгрөгийг тусган батлуулсан.
261. 2023-2024 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих, тэгш хамруулан сургахад шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнийг худалдаж авахад зориулж улсын төсвөөс 300.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.
262. 2023 оны 08 дугаар сараас эхлэн 43 нэр төрлийн 3225 ширхэг тоног төхөөрөмж, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдаж буй ердийн 100 цэцэрлэгт нийлүүлнэ. 2023 онд 100 сая төгрөгийн санхүүжилтээр 80 цэцэрлэгт 25 нэр төрлийн 384 ширхэг тохирох хэрэглэгдэхүүнийг нийлүүлж байсан бол 2024 онд санхүүжилт 2 дахин өссөн байна.⁴

Ерөнхий боловсролын салбарт:

263. 2020-2021 оны хичээлийн жилд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулагдсан тохижилт шийдэлтэй Ерөнхий боловсролын 4 шинэ сургууль ашиглалтад орсон.

⁴ БШУЯ, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн тайлан

264. 2021 онд Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр боловсролын салбарт хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамран сургах зорилгоор “Хүүхэд хөгжлийн танхим байгуулахад 672.2 сая төгрөгийн өртөг бүхий тавилга, тоног төхөөрөмж, ном хэрэглэгдэхүүн, туслах хэрэгсэл нийлүүлж, хүртээмжтэй орчныг нэмэгдүүлсэн. Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд монгол хэлний хичээлийг хос хэлний арга зүйгээр заах арга зүйн зөвлөмж боловсруулах, Монгол дохионы хэлний анхан, ахисан шатны хөтөлбөр боловсруулан 140,6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.
265. 2022 оны эхний улиралд ЕБС-д тэгш хамран суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар болон сургалтын үед нэмэлтээр ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан “Хэл ярианы хөгжил”, “Танин мэдэхүйн хөгжил”, “Дүрслэх урлагтехнологи”-ийн бие даан ажиллах дэвтрийг хэрхэн ашиглах тухай видео бэлтгэж, олон нийтийн онлайн платформд байршуулсан.
266. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээнд нийцсэн хэрэглэгдэхүүн боловсруулах зорилгоор бичил төсөл хэрэгжүүлж, доорх хэрэглэгдэхүүнийг боловсруулсан:
- Харааны бэрхшээлтэй хүүхэд брайл үсэг сурахад дэмжлэг үзүүлэх хэрэглэгдэхүүний багц, гарын авлага, тайлбар видео
 - Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, багш нарт зориулсан дохионы хэлний цахим цуврал хичээл
 - Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн орчинд дэмжих гарын авлага, тайлбар видео
 - Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан математикийн төсөөлөл олгох апплекэйшн Эдгээр хэрэглэгдэхүүнийг Боловсролын Ерөнхий Газар(БЕГ) болон Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэнгийн вебсайтад байршуулсан.
267. Боловсролын чанарын шинэчлэл төслөөр аймгийн төвийн 21 сургуульд "Хүүхэд хөгжлийн танхим" нээж, танхим бүрийг 30.0 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн ном сурах бичиг, тавилгаар хангасан.
268. НҮБ-ын “Хүн амын сан”-тай хамтран Нийслэлийн 29, 116 дугаар сургуулиудад тусгай хэрэгцээт сурагчдын хөгжил, боловсролд дэмжлэг үзүүлэх “Эрүүл мэндийн боловсролын танхим”-ыг байгуулах төслийг хэрэгжүүллээ.
269. Ерөнхий боловсролын 70 дугаар Тусгай сургуульд хүртээмжтэй орчин бүрдүүлэн тархины саажилттай хүүхдийн 2 бүлгийг нээн ажиллуулсан.
270. НҮБ-ын хүүхдийн сантай хамтран тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд зориулсан 27 интерактив хичээлийг жишиг байдлаар боловсруулан www.econtent.edu.mn сайтад байршууллаа.
271. Хийж бүтээх даалгавартай 1500 ширхэг ном, дагалдах хэрэгсэл бүхий 1000 ширхэг багцыг хөгжлийн бэрхшээлтэй бага ангийн бүх хүүхдэд түгээх ажлыг зохион байгууллаа.
272. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурах бичгээр хангах хүрээнд тусгай хэрэгцээт боловсролын 1-5 дугаар ангийн Монгол хэл, Математик, Дүрслэх урлаг, Технологийн нийт 11 нэрийн сурах бичгийг тус бүр 500 ширхгийг нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлсэн.
273. Аймаг, нийслэлийн Боловсролын газраар дамжуулан ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй харааны бэрхшээлтэй 23 хүүхдэд брайл сурах бичгийн багц болон ном уншигч төхөөрөмжийг олголоо.

Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын салбарт:

274. Монголын хараагүйчүүдийн үндэсний төвийн дэргэдэх Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах зорилгоор 250 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 А/283 дугаар тушаал батлагдан санхүүжилтийг шийдвэрлэсэн.

275. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын суралцахад шаардагдах асуудлыг суралцагч бүрээр судлан тухайн хичээл бүрд тохирсон “тохиргоо”-г боловсруулан 42 багшид хүргүүлэн ажиллалаа.
276. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан цахим үйлчилгээний ажилтан, архив, бичиг хэргийн ажилтан, үйлчилгээний ажилтан мэргэжлээр багш, суралцагчийн гарын авлагыг чадамжийн нэгж бүрээр боловсруулж Европын холбооны санхүүжилттэйгээр хэвлэх ажлыг эхлүүлсэн.
277. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дагнан сургадаг МСҮТ-үүд ТИКА төслийн 100 сая төгрөгийн санхүүжилттэйгээр тогооч, талх нарийн боов үйлдвэрлэлийн ажилтан мэргэжлийн дадлагын газрын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчилсэн. Мөн Дэлхийн зөн ОУБ, Lend MN, Макс шил цонхны үйлдвэр, Зориг сантай хамтран “Зоригтой бай” төслийн хүрээнд “Нөхөн сэргээх, сэтгэл заслын өрөө”-г бүрэн тохижуулсан.
278. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид тохирсон ширээ сандал бэлтгэж, зориулалтын шат, ханын бариул, ариун цэврийн өрөөг тохижуулж сургалтын төлбөрийг 70-100%, хөнгөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлээ.
279. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч болон зориулан мэргэжлийн багшид зориулсан суралцагчийн 5 төрлийн гарын авлагыг Европын холбооны төслийн хүрээнд боловсруулж ашиглаж байна.

Их дээд боловсролын салбарт:

280. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй оюутны сурах орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын боловсролын их сургуулийн оюутны 5 дугаар дотуур байранд Хараагүйчүүдийн нийгэмлэгээс “Харааны бэрхшээлтэй оюутнуудад зориулсан танхим” байгуулагдсан.
281. 2021 оноос Боловсрол шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөхөөр хөгжлийн бэрхшээлтэй 2 хүн ажиллаж байна.
282. “Виртуал дохионы хэлний хэлмэрч” аппликэшн бүтээх 249,5 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Дохионы хэлний хөтөлбөр, монгол хэлийг дохионы хэлтэй хосолсон аргаар заах арга зүйн зөвлөмж, Монгол Улсын Боловсролын Их сургуулийн “Дохионы хэлний хөтөлбөр” зэргийг боловсруулахад Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо, Сонсголгүйн боловсрол төрийн бус байгууллага, Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо хамтран ажиллалаа.
283. “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал, шийдэл” хэлэлцүүлгийг 2022 онд зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжид үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Төлөвлөгөө батлах тухай” 2022 оны А/110 дугаар тушаалаар сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролын чанарыг сайжруулах 15 үйл ажиллагааг батлуулан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын Боловсролын Их сургуулийн “Тусгай хэрэгцээт боловсролын багш” бакалаврын сургалтын хөтөлбөрт Монгол дохионы хэлний анхан, ахисан шатны агуулга, арга зүйг сайжруулах, ерөнхий боловсролын сургуулийн багш ажилтныг мэргэжил дээшлүүлэх сургалтад Дохионы хэлний сургалтын модуль боловсруулах ажлыг тусган Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газрын Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын даргын 2022 оны 5/1501, 5/1502 дугаартай албан бичгээр үүрэгжүүллээ. Дээрх үйл ажиллагааг 117,0 сая төгрөгөөр санхүүжүүлэн “Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо”, “Сонсголгүйн боловсрол” төрийн бус байгууллагуудтай хамтран гүйцэтгэлээ.
284. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх, мэргэжлийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Сонсголгүйн боловсрол” ТББ, Дохионы хэлний хэлмэрч, орчуулагчдын холбоо, Сонсголгүй бэрхшээлтэй иргэдийн үндэсний холбоо

- зэрэг байгууллагуудтай хамтран “Монгол дохионы хэлмэрч” мэргэжлийн хөтөлбөр, стандартыг шинээр боловсруулж тус мэргэжлээр сургалт явуулж байна.
285. Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэгш хамруулан сургах зорилгоор “Түгээмэл хөгжил” ТББ-тай хамтран Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллежид хүртээмжийн үнэлгээ хийлээ.
286. Швейцарын хөгжлийн агентлагийн 77.7 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр Монголын хараагүйчүүдийн холбоо болон түүний дэргэдэх Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагатай хамтран 10 радио жүжиг, монгол киног харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан дуун тайлбартай бүтээсэн.
287. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд E-NURTEEMJ платформ, HAND PRO аппликейшныг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, дизайн зураглал гаргах 19,100.000 төгрөгийг шийдвэрлэсэн.

Коронавирусын цар тахлын үеэр болон дараах үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах чиглэлээл авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

288. Монгол Улс 2019-2020 оны хичээлийн жилд нийт 75 өдөр, 2020-2021 оны хичээлийн жилд 110 өдөр танхимын сургалтын үйл ажиллагааг зогсоож, зайн, цахим хэлбэрээр хичээллэсэн байна.
289. 2019-2020 оны хичээлийн жилийн сүүлийн хагас жилд буюу цар тахлын улмаас үүссэн хөл хорионы үед цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн болон тусгай хэрэгцээт боловсрол, элсэлтийн ерөнхий шалгалтад зориулж нийт 4210 цагийн теле хичээлийг үндэсний хэмжээнд хүргэхдээ 2144 теле хичээлийг дохионы хэлний тайлбартай болгож, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн суралцах хүртээмжийг хангасан. Теле хичээл үзэх боломжгүй алслагдсан малчин айлын хүүхдүүдийн сурах үйл явцыг дэмжих, сургалтын хоцрогдлыг багасгах зорилгоор 4-7 хүртэлх насны хүүхдүүдэд зориулсан 30 аудио контент бүтээсэн. Энэхүү контент нь үлгэр, өгүүлэгийг сургалтын хэлбэрт шилжүүлж зохиол болон түүхийн сэдэвтэй болгож, монгол, казах, тува, дохионы хэлний сонголттойгоор бүтээсэн.
290. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад зориулж, хүүхдээ хичээлд нь хэрхэн бүрэн хамруулах, гэрээр хичээллэж байгаа үед хүүхдэдээ ямар дэмжлэг үзүүлэх талаарх агуулгыг багтаасан 2 зөвлөмж боловсруулан онлайн хэлбэрээр хүргэсэн.
291. Математик, Монгол хэлний хичээлийн I-V дугаар ангийн дасгал ажлын дэвтрийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тохируулан боловсруулж орон нутгийн боловсролын байгууллагуудад цахимаар хүргүүлж, хүүхэд бүрд хүргэх чиглэл өгсөн.
292. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын теле хичээлийн үр дүнг сайжруулах, зорилгоор тусгай цэцэрлэг, сургуулийн багш нарт zoom программ ашиглан цахим хичээл зохион байгуулах сургалт явуулж, байгууллага тус бүрд тус программын 14 эрх олгож, нийт 32 цахим хичээл зохион байгуулж, хүүхэд эцэг эхтэйгээ хамтран хичээлд оролцох, багш нар туршлага судлах боломжийг бүрдүүлсэн.
293. Цар тахлын үед зохион байгуулсан теле хичээлд хамрагдалтыг тандах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, нэмэлт хэрэгцээг тодорхойлох зорилгоор тандан судалгаа хийсэн. Судалгаанд хот, хөдөөгийн нийт 795 эцэг эх, асран хамгаалагч оролцсон. Энэхүү судалгаа нь тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүд цар тахлын үед боловсролын үйлчилгээг хэрхэн авч байна.вэ?, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ хичээл, сурлага, хөгжилд дэмжлэг үзүүлж байна уу?, гэр бүлийн орчинд сургалтын ямар дэмжлэг хэрэгтэй байна, сургалтын хэлбэр ямар арга хэлбэртэй байвал илүү үр дүнтэй явагдах вэ гэх мэт асуултад хариулт өгсөн. Судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдээ дэмжлэг үзүүлэхэд нь зориулсан арга зүйн зөвлөмж боловсруулан цахимаар хүргүүлэх, хэвлэмэл ном, зөвлөмж, сургалтын хэрэгсэл бүхий багцыг бага ангийн 1236

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүргэх ажлыг зохион байгуулж, хүүхдийн суралцах үйлийг нь дэмжсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

294. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулдаг 186 дугаар тусгай цэцэрлэгт түшиглэн хөдөлгөөний болон хэл ярианы бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллах хичээлийн бичлэгийг нийт багш нарт цахим хэрэгслээр дамжуулан хүргэсэн.

25 дугаар зүйл. Эрүүл мэнд

295. Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд 2020 оны 05 дугаар сард эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг шинээр тусгасан. Урт хугацааны тусламж, үйлчилгээний эрх зүйн орчин боловсронгуй болсноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал бүрэн хангагдана.
296. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/318 дугаар тушаалаар батлагдсан “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”-д үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн эмэгтэйчүүд, хөдөлмөрийн чадвар түр алдалттай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ гэсэн заалтуудыг онцлон тусгаж оруулсан.
297. Эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний соёлтой холбоотой стандартыг хэрэгжүүлэхээр “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS...:2023 стандарт”-ыг анх удаа боловсруулж, Стандартчилал хэмжил зүйн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан /стандартын дугаар одоогоор ирээгүй байна. Уг стандартад хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцах, эрүүл мэндийн байгууллагын гадна болон дотоод орчинд тавигдах шаардлагад хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчин бүрдүүлэх, хэвтэн эмчлүүлэх тасагт хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй өрөөг нэгээс доошгүй, зориулалтын тоноглол бүхий ариун цэврийн өрөөг төлөвлөх зэрэг 20 орчим тусгайлсан заалтыг тусгасан.
298. Нярайн дутуу төрөлтийг бууруулах, дутуу нярайд үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулах, нярайн амь насыг аврах, амьсгалын дистресс хам шинжийн эмчилгээнд хэрэглэх сурфактант эмчилгээг шинээр нэвтрүүлсэн.
299. Тархины саа, саажилт, уналт таталт оноштой байнгын диспансерийн хяналтад байдаг 19 хүртэлх насны хүүхдийн байнга хэрэглэдэг эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100%-ийн хөнгөлөлттэйгээр олгох асуудлыг ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. ЭМДҮЗ-ийн 2020 оны 13 дугаар тогтоолоор 70%-иар олон улсын нэршил бүхий 11 ерөнхий нэршлийн 41 худалдааны нэршлийн эмийг үнийн хөнгөлөлт үзүүлж байсан бол уг тогтоолоор нийт олон улсын нэршлээр 25, худалдааны нэршлээр 78 нэр төрлийн эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлсэн.
300. Эрүүл мэндийн сайдын А/407 дугаар “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хавсралтаар батлагдсан. ЭМДЕГ-ын цахим мэдээллийн системд уналт таталттай 5000 гаруй хүүхдийн мэдээллийг оруулж уналт, таталтын эсрэг эмийг 2022 оны 09 дүгээр сараас Ази Фармын салбараар олгож эхэлсэн. Цаашид уналт таталтын эмийг Новартис байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад оруулж ирсэн.
301. ХНХЯ, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг олон улсын жишгийн дагуу хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлд эцэг, эх, болон анхан лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн анхан шатны гарын авлага байдлаар сайжруулж, цахимжуулах ажлыг ЭМС-ын тушаалаар батлахаар боловсруулж байна.

302. Амаржих газруудын тусламж, үйлчилгээний чадавх, хүртээмжийг сайжруулах зорилгоор 2021-2022 онуудад 80 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээр бүх амаржих газрын төрөх орыг иж бүрэн шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй төрөх боломжтой болсон. 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй 41 үйлчлүүлэгч, 2023 оны эхний хагас жилийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 11 үйлчлүүлэгч эсэн мэнд амаржсан байна.
303. Эмнэлэг хяналтын комиссын дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/34 дүгээр тушаалаар батлуулж, 2023 онд эмнэлэг, хяналтын үйл ажиллагааны үр нөлөөллийн судалгааг хийхээр ажиллаж байна.
304. “Ховор тохиолддог өвчин, эмгэгийг эмчлэх болон гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, нөөц бэлэн байдлын асуудал хариуцсан байгууллагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгуулах” талаар Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Төв байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж байна.
305. ЭХЭМҮТ-д Ураг нярайн үеийн илрүүлэг, шинжилгээний талаар сүүлийн 10 жилийн судалгаа хийсэн. Үр дүнд нийт амьд төрөлтөд 0.5-1% нь хромсомын эмгэг илэрсэн байна. Илэрсэн өвчнүүдэд Дауны хам шинж 45,7%, Эдвардсын хам шинж 21,4%, бусад хам шинж 32.9% тус тус байна. 35-аас доош насны эхийн урагт 30.4%-д нь хромсомын эмгэг оношлогдсон нь жирэмсэн эмэгтэйчүүдийг нас харгалзахгүй пренатал хавсарсан илрүүлэг шинжилгээнд хамруулах, эрсдэлийг тооцох шаардлага гарсан тул Пренатологийн төв байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
306. Нийслэлийн төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын сэргээн засах эмчилгээний тасаг, кабинетын тоог нэмэгдүүлснээр 2020 оны эхний хагас жилд ойролцоогоор 5000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.
307. ДЭМБ-ын түншлэлийн хүрээнд Носсал институтээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах цуврал сургалтын 7 модулийг боловсруулж туршилт сургалтыг зохион байгуулсан.
308. ДЭМБ-аас зохион байгуулсан Туслах технологийн түргэвчилсэн үнэлгээг хийхэд ЭМЯ хамтран ажиллаж, үр дүнгийн тайланг 2021 оны 11 сард танилцуулсан.
309. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан мэдрэл, дотор, чих хамар хоолой нүд, шүд, сэтгэцийн эмч, хэл засал, сэргээн засалч эмч, удам зүйч, мэдрэлийн мэс заслын эмч нарын хамтарсан үзлэгийг жилд 1 удаа зохион байгуулах төлөвлөгөө гарган, 2022 оны үзлэгийг 08 дугаар сараас 500 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дээрх төрөлжсөн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулсан.
310. ДЭМБ, Геронтологийн үндэсний төвтэй хамтран “Эрсдэлтэй бүлгийн өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн коронавирусын эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд Нийслэлийн 9 дүүрэгт амьдарч байгаа Эрүүл мэндийн IV, V бүлгийн, албан ёсны асран хамгаалагчтай 6935 иргэнийг хамруулсан.
311. ЭМЯ-наас цахимаар зохион байгуулсан “Ковидын дараах сэргээн засах эмчилгээ” сэдэвт сургалтад НЭМГ-ын харьяа төр, хувийн хэвшлийн эмнэлгийн сэргээн засах эмчилгээний эмч, сувилагч, хөдөлгөөн засалч нийт 120 хүн хамрагдсан байна.
312. НЭМГ нь Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоотой хамтран эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгавран гадуурхлаас ангид байдаг чиглэсэн харилцаа хандлагын нөлөөллийн цуврал контентуудыг бэлтгэн гаргасан. Контентыг НЭМГ-ын болон харьяа байгууллагын цахим хуудсаар дамжуулан ковидын халдварын тандалт хариу арга хэмжээний баг, дархлаажуулалтын цэгт ажиллаж байгаа 1200 гаруй эмч, мэргэжилтэн үзсэн байна.

313. Нийслэлийн Өргөө, Амаржих, Хүрээ газруудад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан тусгай төрөх орны тусламжтайгаар энэ оны 3 улирлын байдлаар тулуур эрхтний бэрхшээлтэй 45 эмэгтэйчүүд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ авсан байна.
314. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/406 дугаар тушаалаар “Мэдрэлийн ёзоор тайрах мэс заслыг монголд нутагшуулах ажлын хэсэг”-ийг баталсан. Энэ хүрээнд мэдрэлийн ёзоор тайрах мэс заслыг Монгол Улсад нутагшуулах төрөлжсөн мэргэшлийн эмч нараас бүрдсэн “Үндэсний баг”-ийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/474 дүгээр тушаалаар байгуулсан. Үндэсний баг мэдрэлийн ёзоор тайрах мэс засал хийлгэх шаардлагатай нийт 250 хүүхдийн нэрсийн жагсаалтыг гаргасан. Цаашид мэс засал хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал болон 2023 оноос ЭМДҮЗ-ийн тогтоолд мэс заслын өртгийг тусган 0-18 настай хүүхдэд үнэ төлбөргүй үзүүлэхээр төлөвлөж байна.
315. Улсын хэмжээнд сэргээн засахын эмч 176, хөдөлгөөн засалч 134, хөдөлмөр засалч 35, сэтгэл засалч 8, сэргээн засахын сувилагч 384, бусад засалч 47 тус тус байна. “Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний арга хэрэгслийг нутагшуулах зорилгоор сургагч багш бэлтгэх сургалт”-ыг 2022 оны 05 дугаар сард нийт 129 эмч, мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан.
316. Эмнэлгийн мэргэжилтэнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харилцахад анхаарах асуудал” сэдэвт богино хугацааны сургалт 2 удаа зохион байгуулсан. Сургалтад анхан болон лавлагаа шатлалын 200 гаруй эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.
317. Амаржих газарт албан хаагчдыг хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцахад чадавхижуулан шаардлагатай үед ашиглах гарын авлага бүхий мэдээллийн хавтас байршуулан ашиглаж байна.
318. Агаарын тээврийн хялбаршуулсан үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн яамнаас “Агаарын тээврээр үйлчлүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан зэрэг тусламж, дэмжлэг шаардлагатай иргэдэд үйлчлэх агаарын тээврийн үйлчилгээний ажилтанг чадавхижуулах сургалтыг 2022 оны 04 сараас эхлэн нэг сарын хугацаатай бүсчилсэн байдлаар зохион байгуулж, нийт 127 иргэний нисэхийн албан хаагч оролцлоо.
319. Хэл заслын мэргэжилтэн бэлтгэх асуудлаар ЭМЯ, БШУЯ, ДЭМБ, ЭМЯ-ны дэргэдэх Сэргээн засахын мэргэжлийн салбар зөвлөл, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монголын бие, бялдар хөдөлгөөн заслын холбоо, хэл засалч мэргэжилтний төлөөлөл оролцсон хэлэлцүүлэг зохион байгуулсан.
320. НҮБХАС, Люксембургийн засгийн газрын дэмжлэгтэйгээр эх нярайн тусламж үйлчилгээнд шаардлагатай коронавируст халдвар, бусад нөхөн үржихүйн халдваруудын оношилгоог баталгаажуулах орчин үеийн молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Энэ үйл ажиллагааны хүрээнд 2022 оны төлөвлөгөөнд буй “Цар тахлын үед эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах нь” төслөөр эх, нярайн тусламж үйлчилгээнд шаардлагатай тус бүр нь 350 сая төгрөгийн өртөг бүхийн Молекул биологийн иж бүрэн 3 лабораторийг Улаанбаатар хотын Өргөө амаржих газар, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II-д тус тус хүлээлгэн өгөв.
321. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд болон нийгэм, сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг AIFO төрийн бус байгууллагатай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй байлгах” сэдвээр 2022 оны 09 дүгээр сард сургалт зохион байгуулсан. Сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн төлөөлөл, хөдөлгөөн засалч, сэргээн засалч эмч зэрэг нийт 50 гаруй мэргэжилтэн, Эрүүл

- мэндийн газар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмч, мэргэжилтнүүд хамрагдлаа.
322. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр мэдрэл судлалаар нийт 81 эмч үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж байна.
323. “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн I үе шатны төсөл”-ийн хүрээнд лавлагаа шатлалын 2 эмнэлэг /Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Чингэлтэй дүүргийн ЭМТ/, анхан шатны 9 эмнэлгийн барилга байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмжийг цогцоор сайжруулж байна. Үүнээс Хөвсгөл аймгийн Тариалан сум, Булган аймгийн Дашинчилэн сум, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сум, Дорноговь аймгийн Эрдэнэ сум, Говь-Алтай аймгийн Тайшир сумдын Эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг энэ ондоо багтаан дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.
324. Эрүүл мэндийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилготой уулзалт хэлэлцүүлгийг 2023 оны 02 дугаар сард зохион байгуулсан.
325. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл сургалтыг зохион байгуулах гарын авлагыг боловсруулсан бөгөөд сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж байна.
326. ХБХХЕГ-ын харьяа Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Сэргээн засах төв нь ХБИ-ийг улсын хэмжээнд харьяалал харгалзахгүй хүлээн авч, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношлогоо, эмчилгээний цогц үйлчилгээг үзүүлж жилдээ амбулаториор 5000, стационараар 2000, сэргээн засалтын кабинетуудаар давхардсан тоогоор 7000-8000 гаруй иргэдийг хүлээн авах хүчин чадалтай үйл ажиллагаагаа явуулж байна.
327. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь 2019 оноос улсын хэмжээнд харьяалал харгалзахгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авч, хөдөлгөөний чадвар алдалтыг богино хугацанд сэргээн засах, сэтгэхүйн үйл ажиллагааг сайжруулах, хоёрдогч хүндрэлээс сэргийлэх сэргийн засах тусламж үйлчилгээг цогцоор хүргэж байна. 250 ортой, өдөрт 500 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай.
328. Сэргээн засах төв эмнэлэг болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв эмнэлгийн үйлчилгээг цахимжуулах ажлыг ХНХЯ, АХБ-ны хамтарсан “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төсөл”-ийн дэмжлэгтэйгээр 2021 онд эхлүүлж хүлээн авах, мэдээлэл лавлагаа, амбулаторийн үзлэг, эмчилгээ оношлогооны кабинетууд, сэргээн засах тасгуудыг холбосон сүлжээг бий болгож, Axis системээр дамжуулан эмнэлгийн анхан шатны маягтын бүртгэл цахимд шилжин үйлчлүүлэгчдийг хүлээн авах, цаг товлох үйлчилгээг нэвтрүүлсэн. Ингэснээр үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, үйлчлүүлэгчид цаг алдахгүй түргэн шуурхай үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

329. Тандалт судалгаагаар коронавирусын халдварын магадлалтай, шинж тэмдэг бүхий тохиолдол илрэх бүрт шуурхай хариу арга хэмжээ зохион байгуулах баг бүрэлдэхүүнээрээ ажиллаж, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай хэрэгжүүлсэн. Эмчлүүлэгч нарын өвчний түүх, халдварын тусгаарлалтын орны хөдөлгөөний мэдээг тухай бүрт Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Статистик бүртгэл мэдээллийн хэлтсийн цахим программ болох hinfo-3, www.burtgel.mos.mn, ХӨСҮТ-ийн Бүртэл мэдээллийн хэлтэс, дүүргүүдийн Онцгой байдлын хэлтэс, ЭМДЕГ-т тус тус хүргүүлж ажилласан.
330. СЗСҮТ-ийн Сэргээн засах төв өөрсдийн санаачилагаар 32 төрлийн жижиг хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж 243,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжийг төвлөрүүлж, тоног төхөөрөмжийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн.

26 дугаар зүйл. Сэргээлт, нөхөн сэргээлт

331. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийг Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан бөгөөд иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэхэд цахимаар болон бичиг баримтад үндэслэн шийдвэрлэж болохоор зохицуулж өгсөн нь хөгжлийн бэрхшээлтэй, өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй иргэдийг заавал ЭХМК-ын хуралд оролцуулахгүйгээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.
332. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай” А/758, А/197 дугаар хамтарсан тушаалаар өвчний жагсаалтыг баталж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.
333. Уг жагсаалтыг батлахад Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Азийн хөгжлийн банкны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/89 дүгээр тушаалаар байгуулсан. Энэхүү ажлын хэсэг 16 удаа цахимаар, 5 удаа сургалт хэлэлцүүлэг, 1 удаа биечлэн хэлэлцүүлэг, хуралдааныг тус тус зохион байгуулж даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн боловсруулсан.
334. Хуучны мөрдөж байсан өвчний жагсаалт нь 10 бүлгийн 461 өвчнөөс 69 төрлийн өвчинг “Хугацаагүй” ангиллаар тогтоож байсан бол шинээр баталсан жагсаалтад “Хугацаагүй” ангиллаар тогтоож буй өвчний тоо 14-өөр нэмэгдэж 83, нийт өвчний тоо 2-оор нэмэгдэж 463 болгож, дараах өөрчлөлтүүдийг тусгав:
- Ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалтыг шинэчлэн боловсруулж, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих эсэхийг тодорхойлох хүснэгт нэмж, олон улсын оношийн кодыг өвчин тус бүрд тодорхойлж тусгав.
 - Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалтыг шинэчлэн боловсруулахад Олон улсын өвчний ангилал ICD-10-ыг баримтлав.
 - Мөн даатгуулагчийн бие махбодийн болон мэдрэлийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг үнэлэх зорилгоор өдөр тутмын үйлдлийн Бартелийн индексийн үнэлгээг мэдрэлийн өвчний жагсаалтад анх удаа ашиглахаар тусгав.
 - Энэхүү өвчний жагсаалтад эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал болон элэг, бөөр шилжүүлэн суулгах донорын хагалгааны заалтыг шинээр нэмж тусгалаа.
335. АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд “Үйлдлийн олон улсын ангилал /ICF/”-ыг нэвтрүүлэх чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлэхэд тохиромжтой сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлага, аргачлал боловсруулан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадварыг /ICF/-д суурилсан үнэлгээг туршиж” сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийслэлийн 6 дүүрэг, Архангай, Дархан, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл, Дорноговь, Баянхонгор аймгуудын ЭХМСК-ын магадлагч эмч, аймгуудын Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын, Нийгмийн халамжийн хэлтсийн дарга нарыг хамруулан, 20 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сонгон туршилтын үнэлгээ хийсэн. /ICF/-ыг эрчимжүүлэх чиглэлээр ХНХ-ын сайд, ЭМ сайдын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/76, 183 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

336. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын СЗҮТ 2020-2022 онд дараах сэргээн засах тусламж үйлчилгээг зорилтот бүлгийн 45.7 хувьд хүргэсэн. Үүнд:
- Эрүүл мэндийн сэргээн засах тусламж үйлчилгээнд нийт 14599 иргэн,
 - Боловсролын сэргээн засах тусламж үйлчилгээнд 1928 хөгжлийн бэрхшээлтэй иргэн,
 - Протез, ортопедийн үйлчилгээнд 1279 хөгжлийн бэрхшээлтэй иргэн,
 - Нийгмийн сэргээн засалт (сургалт, нөлөөллийн ажил, хөдөлмөр зуучлал)-ын үйлчилгээнд 1553 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийт 19359 иргэн хамрагдсан байна.
337. ХНХЯ АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Архангай, Дорнод, Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Дундговь аймгуудад “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийн барилгыг ашиглалтад хүлээн авсан. 2023 оны 3 дугаар улиралд үйл ажиллагааг эхлүүлэх бөгөөд эдгээр төвд сэргээн засах үйлчилгээг цогцоор нь үзүүлэх боломжтой болно.
338. Хөдөө орон нутаг болон алслагдмал бүс нутагт сэргээн засах тусламж үйлчилгээ хомс байгааг харгалзан жил бүр сэргээн засах тусламжийг явуулын үйлчилгээгээр хүргэх ажлыг зохион байгуулдаг. Энэ хүрээнд:
- Хөвсгөл, Булган, Орхон, Дорнод, Дундговь аймгуудын хөгжлийн бэрхшээлтэй хүнд “Эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх” сургалт, эрт илрүүлэг болон сэргээн засах цогц үзлэг хийж, эмчилгээ, дасгал хөдөлгөөн засал, зөвлөгөө мэдээллийг нийт 230 хүнд,
 - ХБХХЕГ, ХБХСЗХТ-ийн хамтарсан ажлын хэсэг Норвегийн тусламжийн байгууллагатай хамтран 2022 оны 04 дүгээр сард Ховд, Баян-Өлгий аймгуудад эрт илрүүлэг болон сэргээн засах цогц үзлэг хийж, эмчилгээ, дасгал хөдөлгөөн засал, зөвлөгөө мэдээллийг нийт 150 хүнд,
 - ХНХЯ, ХБХСЗХТ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисстой хамтран “Бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл хоцрогдлыг үнэлэх, эрт илрүүлэх, 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн цогц үзлэг” сэдэвт сургалт, үзлэгийг 2022 онд Дорноговь, Ховд, Баян-Өлгий, Орхон зэрэг 4 аймагт зохион байгуулж 213 эмч, эмнэлгийн ажилтан, 410 хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн хоцрогдолтой хүүхэд, 900 гаруй эцэг эх, амран хамгаалагчдыг хамруулан үзлэг оношилгоо хийж зөвлөгөө, зөвлөмж, мэдээллээр хангаж ажилласан.

27 дугаар зүйл. Ажил, хөдөлмөр эрхлэлт

339. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх мэдээллийг 5 дах хариултаас дэлгэрүүлж харна уу.

340. ҮСХ-ны 2022 оны тоон мэдээгээр нийт 115.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас 0-18 насны 11.8 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 15 мянга орчим нь хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс улсын хэмжээнд 4864 хөгжлийн бэрхшээлтэй хүн төрийн албанд ажиллаж байгийн 245 нь удирдах албан тушаал, 2811 нь гүйцэтгэх, 1808 нь туслах албан тушаал эрхэлж байна.
341. Хариулт 12-т дурдсан 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн батлахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар оруулсан зохицуулалтын талаар дурдвал:
- *Журмын 9.4 дэх хэсэгт “...хөгжлийн бэрхшээлтэй иргэн 9.1.1-т заасан шалгалтад 20 ба түүнээс дээш оноо авсан бол дараагийн шалгалтад оролцох эрхтэй.”;*
 - *Журмын 9.7 дах хэсэгт “Энэ журмын 9.1.1-т заасан шалгалтын үргэлжлэх хугацаа 40 минут, 9.1.2, 9.1.3-т заасан шалгалтын үргэлжлэх хугацаа тус бүр 30 минут байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний шалгалтын үргэлжлэх хугацааг тухайн*

- иргэний болон мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн уртасгасан цагаар зохион байгуулж болно.*”;
- 9.13 дах хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн энэ журмын 9.10, 9.11, 9.12-т заасан албан тушаалын сул орон тоог нөхөх шалгалтад оролцвол шалгалтын нийт авбал зохих оноо 100 байх бөгөөд 50 ба түүнээс дээш оноо авсан оролцогчийг шалгалтад тэнцсэнд тооцно”;
 - 9.14 дэх хэсэгт “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд энэ журмын 9.2.5-9.2.7, 9.3.1-9.3.3-т заасан шалгалтын үнэлгээнд давуу байдал олгож болно” гэж тус тус заасан.
342. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2 дахь хэсгийн хэрэгжилт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг төрийн албанд ажиллуулах эрхийг хангах, боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оноос эхлэн төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр сонгон шалгаруулалтын цахим системд бүртгүүлэх мэдээллийг “Хөгжлийн бэрхшээлтэй эсэх” гэсэн сонголттой болгосон. Сонголтод хамрагдсан иргэдтэй холбогдож тусламж, дэмжлэг шаардлагатай эсэхийг судалсны дагуу шалгалт өгөх орчныг бүрдүүлж байна. 2020-2023 оны хагас жилийн байдлаар нийт 242 хөгжлийн бэрхшээлтэй иргэн Төрийн албаны ерөнхий шалгалтад орсон байна. Энэхүү үйл ажиллагааг Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн.
343. 2021 онд хийсэн судалгаагаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийгмийн даатгалын санд бүртгэлтэй 25-аас дээш ажилтантай 6511 байгууллагын мэдээ ирснээс 3242 аж ахуйн нэгж, байгууллага буюу 50 гаруй хувьд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийхэд 9593 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 7256 иргэн ажиллаж байгаа буюу хуулийн хэрэгжилт аж ахуйн нэгж байгууллагад 61 хувь, төрийн байгууллагад 59 хувийн хэрэгжилттэй байгаа дүгнэжээ.
344. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж оруулж байна. Ялангуяа хөдөлмөрт бэлтгэж, ажилд зуучлах биш, ажилд зуучлаад ажлын байрыг нь тохируулдаг тогтолцоонд аажмаар шилжинэ гэж үзэж байна.
- 345. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Японы Жайка байгууллагатай хамтран “Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн мэдээллийг 64, 65 дах хариултаас дэлгэрүүлж харна уу.**
346. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэр томъёоны хэсгийн 4.1.14-т “Ажлын байрны дадлагажуулагч” гэж ажлын байран дээр аж ахуйн нэгж болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг холбон ажиллах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, энэ чиглэлийн арга зүйг эзэмшсэн хүнийг хэлнэ” гэж тусгасан. Түүнчлэн “Иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь дэмжлэг шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангасан тохиолдолд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу ажлын байрны дадлагажуулагч ажиллуулж болно.” гэсэн зохицуулалтыг нэмж тусгасан.
347. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх
 - Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох
 - Төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох
 - Аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох
 - Борлуулалтын дэмжлэг үзүүлэх
 - Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх
 - Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах
 - Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

- Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа зэрэг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт 2018-2022 он

Он	Зарцуулсан хөрөнгө /тэрбум/	Хамрагдсан хүний тоо	Шинээр бий болсон ажлын байр
2018	3.6	5692	1209
2019	3.5	5622	1161
2020	3.3	2844	1089
2021	6.4	3440	1265
2022	9.6	4427	1225
НИЙТ	26.4	22025	5949

348. 2023 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, санхүүгийн дэмжлэг гэх мэт арга хэмжээгээр бүлэглэн боловсруулж тухайн арга хэмжээ тус бүрийн хувьд хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт, төсвийн хуваарилалтыг тооцон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлан хэрэгжүүлж байна.
349. Монгол Улсын Засгийн газраас залуучуудын хөгжил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2021 оноос амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг хамруулсан.
350. ХНХЯ-аас Дэлхийн банктай хамтран “Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр”-ийг 2023 оны III улирлаас хэрэгжүүлэхээр удирдамжийг батлуулсан. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүртгэх, оролцоог хангах, сургахдаа бэрхшээлийн хэлбэрт нь тохирсон хүртээмжтэй арга ашиглах, орчин бүрдүүлэх /дохионы хэл, брайл үсэг/, хөтөлбөрт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний тооноос хамааран ажлын байрны дадлагажуулагчийг хамруулах зэрэг асуудлууд туссан.
351. ХБХХЕГ нь 2020 оны 03 дугаар сард Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас “Хөдөлмөр зуучлалын бирж” байгуулах эрхийн зөвшөөрлийн гэрчилгээг авч хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус биржийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, өрөө тасалгааны тохижилтыг хийж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн.
352. Ажлын байрны зарын нэгдсэн сайт www.zangia.mn платформ дээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломжтой ажлын байр” шинэ цэсийг нэмэлтээр бий болгосон. Хөдөлмөрийн бирж нь:
- 2020 онд 231 хүнд зөвлөгөө, мэдээлэл өгч, ажил идэвхтэй хайж буй 287 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг бүртгэн, мэдээллийн сан үүсгэж, 76 аж ахуй нэгж байгууллагаас 154 орчим ажлын байрны санал авсан. Эдгээрээс 76 ажил олгогч байгууллагуудад 215 ХБИ-ийг аж ахуйн нэгж, байгууллагад байнгын ажлын байранд зуучилсан.
 - 2021 онд хөгжлийн бэрхшээлтэй 1,003 иргэн Хөдөлмөрийн биржээр үйлчлүүлсэн ба 453 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл хүргэж, 193 иргэнийг цагийн болон байнгын ажлын байранд зуучилсан.
 - 2022 онд Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем (Lmis) санд нийт 201 иргэнийг шинэчлэн бүртгэсэн. Ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагуудын хүний нөөц, холбогдох мэргэжилтнүүдтэй утсаар болон биечлэн уулзаж хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломжтой ажлын байрны захиалгын ХЗЗ-3 маягтыг 70 байгууллагад

хүргүүлж 47 аж ахуй нэгж байгууллагаас 119 ажлын байрны захиалга авч 83 иргэнийг ажлын байранд зуучилсан.

353. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудыг санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ:

-2019 онд Хараагүйчүүдийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр нийт 52 байгууллагад 921,994,000.0 төгрөг;

-2020 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Борлуулалтын дэмжлэг, Хөдөлмөр эрхлэлтийн түр сургалт, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нийт 91 байгууллагад 1,001,488,660.0 төгрөг;

-2021 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Борлуулалтын дэмжлэг, Хөдөлмөр эрхлэлтийн түр сургалт, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байранд дадлагажуулах арга хэмжээ, Ажлын байр хадгалахад дэмжлэг үзүүлэх, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоог дэмжих сайжруулах, Аж ахуй нэгж, төрийн бус байгууллагуудын түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр нийт 179 байгууллагад 2,043,053,905.0 төгрөг;

-2022 оны жилийн эцсийн байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийн түр сургалт, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байранд дадлагажуулах арга хэмжээ, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцсэн тусгайлсан ажлын байрыг шинээр бий болгох төсөл арга хэмжээний чиглэлээр нийт 112 байгууллагад 2,440,023,685 төгрөг.

-2023 оны эхний хагас жилд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Борлуулалтын дэмжлэг, Хөдөлмөр эрхлэлтийн түр сургалт, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байранд дадлагажуулах арга хэмжээ, Аж ахуй нэгж, төрийн бус байгууллагуудын түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр нийт 64 байгууллагад 1,149,050,100.0 төгрөг тус тус олгосон байна.

354. **Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ:** ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 2019-2023 онуудад 55 ТББ-уудтай гэрээ байгуулан, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлж, нийт 342,840,866 төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тухайлбал:

2019 онд нийт 33 байгууллагад 209,638,400.00 төгрөг,

2020 онд нийт 3 байгууллагад 28,600,000.00 төгрөг,

2021 онд нийт 5 байгууллагад 35,455,800.00 төгрөг,

2022 онд нийт 11 байгууллагад 54,046,666.00 төгрөг,

2023 оны эхний хагас жилд 3 байгууллагыг 15,100,000 төгрөгөөр тус тус санхүүжүүлсэн.

355. **Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ:**

• 2019 онд 18 ААНБ, 52 ТББ-ын нийт 70 төслийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан 910,000,000 төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд нийт 182 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байнгын ажлын байртай болсон.

• 2020 онд 11 ААНБ, 60 ТББ-ын нийт 71 төслийн сонгон шалгаруулж гэрээ байгуулан 920,000,000 төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд нийт 184 хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдаж байнгын ажлын байртай болсон.

- 2021 онд 32 ААНБ, 33 ТББ хамрагдаж, нийт 65 төслийн сонгон шалгаруулж 1,180,000,000 төгрөгийн санхүүжилт олгож 118 ажлын байр бий шинээр болгосон байна.
 - 2022 онд ХБИ-ийн онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байрыг бий болгох сонгон шалгаруулалтыг 3 үе шаттайгаар зохион байгуулж, 100% эргэн төлөлттэй 23 ААНБ, 50% эргэн төлөлттэй 14 ТББ, нийт 37 байгууллагатай санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулан 1,045,000,000 төгрөгийн санхүүжилт олгож 73 ажлын байр шинээр бий болсон байна.
 - 2022 он: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд нийт 74 /үүнээс 30 ТББ, 44 ААНБ/ байгууллага хамрагдаж 2,095,000,000 төгрөгийн санхүүжилт олгож, 167 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байртай болоод байна.
 - 2023 оны эхний хагас жил: “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-ны санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/001 тушаал, ХБХХЕГ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/42 тушаалаар тус тус байгуулсан. Нийт 43 байгууллагад 1,090,000,000 (нэг тэрбум, ерөн сая) төгрөгийн санхүүжилт олгож, 190 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байнгын ажлын байртай болсон байна.
356. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан бусад дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг сайжруулах зорилгоор тогтмол оролцуулж байна. Тухайлбал, БНХАУ-ын Өвөр монголын Өөртөө засах орны Хөх хот болон Улаанцав хотноо зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэнд 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг бүртгэлийн хураамжаас чөлөөлж, хөнгөлөлттэй нөхцөлөөр оролцох боломжоор хангасан. Үзэсгэлэнд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд бараа бүтээгдэхүүнээ танилцуулж борлуулсан. Мөн “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнесийг дэмжих чиглэлээр 267 сая төгрөгийн зээлд 135 сая төгрөгийн батлан даалт олгоод байна. Цаашид бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагааг дэмжих, ажлын байр, борлуулалтыг сувгийг нэмэгдүүлэх чиглэлээр бодитой арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
357. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөөний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй удирдлагатай жижиг, дунд бизнес эрхлэгчид болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хүрээнд 3 хувийн хүүтэй зээлд батлан даалтын боломж нөхцөлийн сурталчилж, шаардлагатай мэдээллийг хүргүүлэв.
358. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулалтыг дэмжих хүрээнд байгууллагын цахим сайтаар сурталчилж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах телевизийн нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэв.
359. Хөшигийн хөндийн Шинэ нисэх онгоцны буудалд 2021 оны 07 дугаар сараас “Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний зөвлөл” төрийн бус байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдах талбай гаргаж, 2 хүнийг ажлын байраар хангасан төдийгүй 5 аж ахуйн нэгжийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.
360. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсролын салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг шинэчлэн гаргалаа. Судалгаагаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын

- сургууль, их дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагад 2261 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Энэ нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын байгууллагын нийт 102,829 ажиллагсдын 2,1 хувийг эзэлж байна
361. Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх зорилгоор Хиймэл оюун ухаанд суурилсан Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлж ашиглалтад оруулсан. “Ejob” платформ нь Онлайн портал, мобайл аппликэйшн, хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/ гэсэн 3 дэд систем 13 модулиас бүрддэг. Системийн хүрээнд хэрэглэгч өөрийн анкет буюу CV-г байгууллагуудад илгээх, амьдарч буй байршлаас хамааран 1-10 км радиусын хүрээнд ажил хайх, байршлаас үл хамааран ажлын байртай болох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах боломжуудыг бүрдүүлсэн. Тухайлбал, гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэн монголд байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай системээр дамжуулан холбогдож, гэрээт ажил, үүрэг гүйцэтгэх, мөн эх орондоо эргэж ирээд ажиллах боломжийг бүрдүүлсэн.

2023 оны 6 дугаар сарын байдлаар “Ejob” платформд бүртгэгдсэн үйлчилгээ авагчийн тоо:

1. Бүртгэлтэй ажлын байрны тоо – 29799,
 2. Ажил хайгчийн тоо – 42918,
 3. Ажил олгогчийн тоо – 7867,
 4. Ажилд зуучлагдсан иргэдийн тоо – 9549,
 5. Мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо - 9566 болсон байна.
362. Системийн нэвтрүүлэлттэй холбоотойгоор иргэд олон нийтэд таниулах ажлын хүрээнд 25113 ажил хайгч иргэн болон 2405 ажил олгогч байгууллага руу “Ejob” платформын танилцуулга, мобайл аппликэйшны холбоосыг масс мессэжээр илгээсэн. Тус систем нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй байдлаар хийгдсэн.

28 дугаар зүйл. Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал

363. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэжээгч нь нас барсан хагас болон бүтэн өнчин хүүхдүүд гэх зэрэг нийгмийн зүгээс анхаарал халамж зайлшгүй шаардлагатай 65.6⁵ мянган иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авч байна. Мөн 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээгээр тусламж олгох болсон бөгөөд энэ тусламжид нийт 12.8 орчим мянган хүүхэд хамрагдаж байна. Асаргааны тэтгэмжид байнгын асаргаа шаардлагатай иргэн /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд/-ийг асарч байгаа болон хүнд нөхцөлд байгаа хүүхэд, ганц бие харж хандах хүнгүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа 66.0 мянган иргэн байна.
364. КОВИД-19 цар тахлын үед зорилтот бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж амьжиргааг дэмжих зорилгоор 2020-2022 онд нийгмийн халамжийн тэтгэвэр 188 мянган төгрөгийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж олгосон. 2023 онд нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр үргэлжүүлэн тогтоож олгож байна. Харин байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэний асаргааны тэтгэмж /123,100 төг/ болон байнгын асаргаа шаардлагатай 16-аас дээш насны иргэнийг асарч байгаа иргэний тэтгэмж /84,500 төг/-ийг 2020 оноос хойш нэмэгдүүлээгүй байсан.
365. Хүн амын амьжиргааны түвшин бүсүүдийн дунджаар 2020 онд 207,880 төгрөг байсан бол 2023 онд 282,880 төгрөг болж нэмэгдсэн. Амьжиргааны түвшний хамгийн доод хэмжээ зүүн бүсийн амьжиргааны доод түвшин 271,800 төгрөг, Улаанбаатар хотынх 313,400 төгрөг байна.

⁵ 2022 оны 12 сарын нийгмийн халамжийн сангийн мэдээгээр

366. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаас 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталж, үүнийг үндэслэн Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг, нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 12.8 хувиар нэмэгдүүлж 325,000 төгрөг, харин 2020 оноос хойш нэмэгдээгүй байгаа асаргааны тэтгэмжийн хэмжээг 2023 оны амьжиргааны доод түвшинд хүргэж 275,000 төгрөгт хүргэж нэмэгдүүлэхээр тооцож уг арга хэмжээнд 89.8 тэрбум төгрөгийг батлан хэрэгжүүлж эхлэв. Нэмэгдлийг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:
- Нийгмийн халамжийн тэтгэвэр 288 мянгаас 325 мянган төгрөг,
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 288 мянгаас 325 мянган төгрөг,
 - Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэний тэтгэмж 84.5 мянгаас 275 мянган төгрөг,
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэний тэтгэмж 123.1 мянгаас 275 мянган төгрөг
367. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээ 550 000 (таван зуун тавин мянган) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 440 000 (дөрвөн зуун дөчин мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоолоо.
368. Ковид-19 цар тахлын үед хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг 2020 оны 05 дугаар 01-ний өдрөөс мөн оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нэг хүүхдэд 16.0 мянган төгрөг, 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр насанд хүрсэн нэг гишүүнд 32.0 мянган төгрөгт хүргэж, 2 дахин нэмэгдүүлж хэрэгжүүлсэн. 2020 онд уг арга хэмжээнд 44.3 мянган өрхийн 264.4 мянга орчим иргэн хамрагдсанаас 22.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан байна.
369. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тоот тушаалаар “Хүнсний эрхийн бичиг олгох журмыг” шинэчлэн баталсан. Уг журамд зөвхөн гэрээт дэлгүүрүүдээр үйлчлүүлдэг байсныг болиулж, НӨАТ-ын баримт буюу и-баримт хэвлэдэг 235.0 мянга орчим хүнсний дэлгүүр, зах, бөөний төвөөр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж цахимжууллаа. Нээлттэй, ил тод, тэгш хүртээмжтэй, сонголттой, хяналттай болгосон. Сонгон шалгаруулалтад шалгарсан зөвхөн гэрээ бүхий заасан дэлгүүрээр үйлчлүүлдэг байсныг болиулсан. 2021 онд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 13292, 2022 онд 9878 хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус тус хамрагдсан.
370. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Уг төсөлд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг хүн амын амьжиргааны доод түвшин, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан жил бүр нэмэгдүүлж байх, тэтгэврийн хэмжээ нь тухайн иргэний амьжиргааны түвшин, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ зэргийг харгалзан ялгаатай олгохоор тусгаж байна. Түүнчлэн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн насыг 18 нас болгож өөрчлөх, эрүүл мэнд, боловсрол болон хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг сайжруулах, халамж туслалцаа шаардлагатай зорилтот өрх, иргэний ийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн урт хугацааны үйлчилгээг бий болгох зохицуулалтууд тусгахаар ажиллаж байна.

Тэтгэврийн нэмэгдлийн хэмжээ, зарцуулсан хөрөнгө, оноор:

№	Он	Сарын нэмэгдлийн хэмжээ /төг/	Бүрэн тэтгэврийн доод хэмжээ /мян.төг/	Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ /мян.төг/	Дундаж тэтгэврийн хэмжээ /мян.төг/	Тэтгэврийн нэмэгдэлд тухайн жилд зарцуулсан хөрөнгө /тэрбум.төг/	Тухайн жилд тэтгэвэрт зарцуулсан нийт хөрөнгө /их наяд.төг/
1	2016	-	251.0	216.0	312.9	-	1.3
2	2018	27000	280.0	243.0	346.1	119.5	1.6
3	2019	24000	310.0	270.0	372.5	119.5	1.8
4	2020	25000-40000	350.0	300.0	416.1	150.6	2.2
5	2022	15-43%	500,0	400,0	549,5	637,4	3.0
6	2023	10-22%	550.0	440.0	683.2	396.4	-

371. Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох зорилт дэвшүүлснийг хэрэгжүүлж нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Төрөөс үзүүлж буй халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор “Нийгмийн халамжийн нэгдсэн систем”-ийг хөгжүүлж, 2020 онд нэвтрүүлэв. 2020 онд “Насны хишиг”, “Жирэмсэн эхийн тэтгэмж”, “0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж”, “Ихэр хүүхдийн тэтгэмж”, “Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж”, “Эхийн алдар” одонгийн мөнгөн тусламж гэсэн 6 үйлчилгээг, 2021 онд халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж зэрэг 20 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг нэмж нэвтрүүлэн 2023 оны байдлаар халамжийн 64 төрлийн үйлчилгээ бүрэн цахимжиж олголтыг хийж байна. 21 аймаг 330 сум, 9 дүүргийн 204 хороонд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг цахим эрхийн бичгээр үзүүлж байна. “Нийгмийн халамжийн нэгдсэн систем” нэвтэрснээр иргэн нийгмийн халамжид хамрагдах хүсэлтээ төрийн байгууллагад очилгүйгээр нийгмийн халамжийн цахим хуудас болох ehalamj.mn, төрийн үйлчилгээний цахим машин "ТҮЦ машин", ebagimt аппликейшныг ашиглан гаргах, олон байгууллагаар явж цаасаар бүрдүүлдэг баримт бичгийн тоо багасах, өргөдөл, хүсэлтийнхээ шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, өөрийн нэр дээрх арилжааны банкин дахь харилцах дансаараа дамжуулан халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөө авах зэрэг иргэнд ээлтэй олон давуу талууд бий болов.

29 дүгээр зүйл. Улс төр, нийгмийн амьдралд оролцох

372. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төр, нийгмийн амьдралд оролцох боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудад:

- Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байх

- Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байх
 - Санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна зэрэг зохицуулалтуудыг тусгаж өгсөн.
373. Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 23 дугаар тогтоолоор “Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага, санал авах байр бэлтгэх заавар”-ыг шинэчлэн баталсан. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх асуудлыг нарийвчлан тусгасан. Тодруулбал, MNS6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага, MNS6056 : 2009 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар зэргийг үндэслэл болгосон ба санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага хэсэгт дараах агуулгыг тусгасан:
- Санал авах байрны гадна орчин явган болон тэргэнцэртэй иргэн зорчиход саадгүй байх, хэрэв саад үүссэн бол санал авах өдрөөс өмнө тухайн асуудлыг шийдвэрлэх боломжтой байх,
 - Санал авах байрны гадна талд хаяг, мэдээллийн самбарыг нийтэд хүртээмжтэй байдлаар байрлуулах /харааны бэрхшээлтэй иргэд, өндөр настан болон олон нийтэд зориулсан мэдээ, мэдээллийг болон хаягийг тод харагдахуйц том үсгээр байрлуулах/,
 - Санал авах байр нь тэргэнцэртэй иргэн өөрөө орж гарах нөхцөл бололцоотой байх, орц гарц нь босготой бол тэргэнцэртэй иргэнд тохиромжтой байдлаар шийдэх,
 - Санал авах байрны гадна талын үүдэн хэсгийн шал, шат нь иргэд хальтирч гулгаж эрсдэлгүй байх /гялгар плита, шалтай бол хальтирч гулгахааргүй материалаар хамгаалалт хийх/, өндөр настан болон тэргэнцэртэй иргэд орж гарахад саадгүй, босгогүй байх, босготой тохиолдолд налуу байх,
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгайлан тоногдсон нэгээс доошгүй тооны санал бэлтгэх бүхээгийг зайлшгүй бэлтгэсэн байх,
 - Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайл үсэг бүхий хавтас, томруулдаг шил байх,
 - Санал авах байр бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байх.
374. Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа болон эрх зүйн орчны талаарх мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор тус Хорооны www.gec.gov.mn цахим хуудсыг сул харааны бэрхшээлтэй иргэд унших боломжтой хувилбарыг нэвтрүүлж, цахим хуудсыг шинэчилсэн.
375. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль, Монгол Улсын Их Хурлын 18, 28 дугаар тойрогт явагдсан нөхөн сонгуулиудаар сонгогчдод зориулсан мэдээ, мэдээллийг дохионы хэлээр тогтмол хүргэсэн. Мөн санал хураалтын дүн, үйл явцын талаарх шууд мэдээ, мэдээллийг олон улсын дохионы хэлээр, тэжээгч орчуулагчийн тусламжтайгаар анх удаа дохионы хэлний боломжит бүх хэлбэрийг ашиглан нэвтрүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран сонгогчдод зориулсан шторк, уриалгыг зөвхөн дохионы хэлний орчуулгатайгаар бэлтгэж нийтэд хүргэсэн.
376. Сонсголгүй иргэдийн мэдээллийг дэмжих “Бүтээмж” төв, 29 дүгээр сургуулийн багш нар, Дархан-Уул аймгийн Дархан найрамдал ТББ, Диф клубын дохионы хэлний багш, МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын ангийн оюутнууд, Бид чадна ТББ,

Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв зэрэг байгууллагын төлөөлөлтэй хамтран 2022 оны 11 сард хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгох эрхээ хэрэгжүүлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчинг тэдэнд ээлтэй болгоход чиглэсэн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлгийн үр дүнд эдгээр байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлсон бөгөөд тогтмол санал солилцох ажлыг зохион байгуулж хэвшсэн.

377. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд Монголын багш, эцэг эхийн холбооноос “Хөгжлийн бэрхшээлтэй сонгогч иргэн” төслийг хэрэгжүүлэв. Ингэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн бүлгүүдтэй хамтран 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хэр хүртээмжтэй буюу бие даан санал өгөх эрхийг хэр хангаж чадсан эсэхэд хараат бус хөндлөнгийн хяналт хийх ажлыг гүйцэтгэсэн. Үүний тулд хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн ажиглагчдыг СЕХ болон Бодлогод залуусын хяналт ТББ-тай хамтран бэлтгэж 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн мэдээлэл, орчны хүртээмжийг үнэлэх хараат бус, хөндлөнгийн ажиглагчаар бүртгүүлэв. Ингэснээр сонгуулийн мэдээллийн хүртээмж, санал авах өдөр сонгуулийн хэсгийн хороодын хүртээмжид хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй 16 ажиглагч, тэдний туслах, хөтөч, дохионы хэлний хэлмэрч болох 8 хүн нэмэгдэж нийт 24 хүн ажиллав.
378. ХБХХЕГ-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэн сонгуульд санал өгөх санал авах байрны дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг оновчтой зохион байгуулах, сонгуульд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохируулж хэвлэх талаарх хоёр төрлийн зөвлөмжийг боловсруулан Сонгуулийн ерөнхий хороо, улс төрийн томоохон намуудад хүргүүлсэн.
379. Сонгуулийн ерөнхий хороонд 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн дагуу сонгуулийн ерөнхий хорооноос Ерөнхий газартай хамтран 21 аймгаас тус бүр 2 дарга, нарийн бичгийн дарга нар нийт 42 хүн, нийслэлийн 9 дүүргээс мөн 2 сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг оролцуулан нийт 60 хүнд 10 удаагийн давтамжтай цахим сургалтыг зохион байгуулсан
380. Хөдөө орон нутагт санал авах байрыг бэлтгэхдээ ихэвчлэн монгол гэрт авдаг учир түр буюу зөөврийн налуу зам заавал байлгахгаар сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгуулсан.
381. Сонсголын бэрхшээлтэй сонгогч иргэн бэлтгэх төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонгуулийн тухай хууль, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх үүднээс сонгогчийн боловсролд зориулан 6 удаагийн онлайн сургалт, цуврал нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд түгээсэн.

30 дугаар зүйл. Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх

Соёлын арга хэмжээний хүрээнд:

382. Соёлын яамнаас харааны бэрхшээлтэй уншигчдад зориулан хэвлэмэл номыг тусгай форматад хөрвүүлэхэд шаардагдах зардалд 19.9 сая төгрөг зарцуулж, харааны бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн 23 номыг И-паб форматад шилжүүлэн хүртээмжтэй болгосон.
383. 2022 онд “Нүүдэлчин Монгол 2022” фестивалийг зохион байгуулж, 240 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулж, тэдний үйлдвэрлэсэн соёлын бүтээл, гар урлалын бүтээлээр үзэсгэлэн гаргасан. Түүнчлэн бүх нийтийн эх хэлний боловсролыг нэмэгдүүлэх 9 багц арга хэмжээ зохион байгуулснаас 2 арга хэмжээг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан зохион байгуулсан.

384. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үндэсний үнэт зүйл, түүх, соёлын өв, зан заншлыг сурталчлан таниулах, урлагаар дамжуулан нийгэмшүүлэн төлөвшүүлэх “Тэгш хүртээмж” тусгай сургалт, хөтөлбөрийг 2022 оны 03 дугаар улиралд хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрт 55, 29 дүгээр сургуулийн 25 сурагч, эцэг эх, багш нар хамрагдсан. Ахуйтай танилцах байгалийн сургалт, танин мэдэхүйн аялал, “Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг урлагаар дамжуулан нийгэмшүүлэн хөгжүүлэх” модуль сургалтуудыг цувралаар 2022 оны 07-09 дүгээр сард зохион байгуулсан.
385. Салбар дундын оролцоог хангасан “Соёлын бодлого ба тэгш хүртээмж” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулсан.
386. Соёл, урлагийг дэмжих сангаас соёлын үйлчилгээг хүртээмжтэй болгох, тэдний соёлын оролцоог нэмэгдүүлэх чиглэсэн 4 төслийг дэмжин ажилласан. Үүнд:
- Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны “Харааны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад зориулсан ардын аман зохионы эмхэтгэл хийж тэдэнд хүртээмжтэй хэлбэрээр хэвлэн сурталчлан таниулах” арга хэмжээг зохион байгуулж, ардын аман зохиолын төрөл тус бүрээс 3-ыг сонгон эмхэтгэл бэлтгэв. Энэ хүрээнд брайль кирилл бичгээр болон дейзи хэлбэрээр хэвлэсэн.
 - Шинэ үеийн нэгдмэл залуус ТББ-ын “Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан чимээгүй театр төсөл”-д 19.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан тайзны бүтээл хийж олон нийтэд хүргэсэн.
 - Хөгжмийн боловсрол эзэмших хүсэлтэй харааны бэрхшээлтэй суралцагч, оюутан, бие даан эзэмших иргэд болон тэдэнтэй ажиллаж буй багш нарыг дэлхий нийтэд хэрэглэж буй брайл нотыг Монгол тайлбартай, шугаман ноотыг брайль ноот, брайл ноотыг шугаман ноотонд хөрвүүлэгч GOOD FEEL программтай болох зорилготой “Монгол тайлбартай брайль нот төсөл”-ийг хэрэгжүүлсэн.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг уран зургаар хөгжүүлэх “Онцгой авъяастан төсөл”-д 39.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж 2022 оны II улиралд 70 дугаар сургуулийн 107 хүүхдийг хамруулсан.
387. Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Дэлхийн болон бүс нутгийн өвийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд харааны бэрхшээлтэй иргэнийг томилон ажиллуулж байгаа бөгөөд ажлын байрны тохируулгад нь 18.7 сая төгрөг зарцуулсан.
388. Музейн орчны стандарт, музейн барилга байгууламжийн стандарт, Музейн сан хөмрөгийн стандартыг боловсруулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчныг бүрдүүлэх чиглэлээр санал авч байна.
389. Төрийн болон орон нутгийн өмчийн бүх музей хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэ төлбөргүй үйлчилдэг. Богд хаан ордон музей үзмэрийн тайлбарыг харааны бэрхшээлтэй хүмүүст зориулж хүртээмжтэй хүргэхээр хэвлэлтэд өгсөн.
390. Орон нутагт оршин суух хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Өмнөговь аймагт Говийн байгаль түүхийн музейг шинээр ашиглалтад оруулсан бөгөөд одоогоор тус музейгээр 1200 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүн үйлчлүүлсэн.
391. Чойжин ламын сүм музейг 300 сонсголгүй иргэдэд үнэгүй танилцуулах өдөрлөг арга хэмжээг зохион байгуулсан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүн урлаг, спортын салбарт амжилт гаргах боломж” сэдэвт хэлэлцүүлгийг хийсэн.
392. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрөөр ТВ5, Малчин телевизийн сувгуудаар Цагаан шөнө лайв тоглолтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.
393. Шинэ үеийн нэгдмэл залуус ТББ-тай байгуулсан гэрээний дагуу 4 жүжигт тоглох 6 жүжигчид дохионы хэлний сургалтад хамрагдаж аливаа жүжиг, соёлын арга хэмжээгээ дохионы хэлээр олон нийтэд хүргэхээр бэлтгэгдэж Гэгээн муза Олон Улсын театрын урлагийн наадамд чимээгүй жүжиг төрөлд нэр дэвшиж өрсөлдсөн.

394. Дауны холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд соёлоор дамжуулан нийгмийн оролцоог идэвхжүүлж соёлын өвийг таниулах, автобустай аялал хийх ажлын хүрээнд 4 арга хэмжээг 79 хүүхдийг хамруулсан.
395. Нийт 29 зуслангаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулахад хүртээмжтэй орчинтой, боловсон хүчинтэй ажилладаг тухай судалгаа авснаас 14 зусланд хөгжлийн бэрхшээлийн байдлаас хамааран асран хамгаалагчтай болон асран хамгаалагчгүй байдлаар хүүхдүүдийг хүлээн авч амрааж байна.
396. ХБХСЗХТ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсролын дэмжих үйлчилгээг хүргэхэд төрт ёс, түүх, соёл, уламжлалын талаар мэдлэг ойлголтыг өгөх, уламжлалт ахуйтай танилцуулах зорилгоор “Монгол бахархлын өргөө”-г барьж сургалтад ашиглаж байна. Тус өргөө нь хүүхдүүдэд монгол уламжлалыг танин мэдэх, ёс заншил, өв уламжлалаа сэргээх, орчинд нь монгол гэрийн бүтэц, онцлогийг мэдэх, шагайн наадгайгаар гарын нарийн булчин хөгжүүлэх, шатар, даам нүүх, түүгээр дамжуулан амьдралын дадалд суралцуулах зорилготой. Өдөрт 15-20 хүүхдэд үйлчилгээ үзүүлж байна.
397. 2021 оноос эхлэн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар 2 байршилд отоглох цэг байгуулсан. Тус отоглох цэг нь 1 бүхээгтэй 7 тасалгаатай нийт 14 тасалгаатайгаас 2 тасалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэр бүхий иргэдэд үйлчлэх зориулалттай бөгөөд хөдөлгөөн дэмжих бариул султуураар тоноглогдсон.
398. Богдхан уулын дархан цаазат газрын Зайсангийн амны Дугуй цагаан орчимд 2га газрыг амрах талбай болгон 2022 оны 06 дугаар сараас тохижуулж эхэлсэн. Тохижилтын ажлыг Нийслэлийн төсвийн хөрөнгөөр үндсэн гүйцэтгэгчээр Хот тохижилтын газар, туслан гүйцэтгэгчээр Цагаан толгойн нуур ХХК хийж гүйцэтгэсэн. Тус газарт явган хүний зам, хүүхдийн тоглоомын хэсэг, сандал сүүдрэвч болон Кофе шоф, ариун цэврийн байгууламж, нэвтрэх цэгийн ажилтны байр зэрэг байгууламжуудад орох гарах налуу замыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүртээмжтэй тэгш нийгмийн харилцаанд орох боломжийг бүрдүүлэн хийж байна. Мөн ариун цэврийн байгууламжид 9 суултуур, угаалтуур төлөвлөснөөс эрэгтэй, эмэгтэй 1 суултуур, 1 угаалтуурыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан стандартын дагуу хийж суурилуулсан.
399. Тус байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжийг тэгш байдлыг хангах зорилгоор тухайн объект руу нэвтрэхэд гадна талд налуу зам тавьсан.

Спортын арга хэмжээний хүрээнд:

400. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг биеийн тамир, спортоор хичээллэх, паралимп, тусгай олимп, дифлимп, олон улсын тэмцээн, уралдаанд оролцох, амжилтыг нь шагнаж урамшуулахад төрөөс дэмжлэг үзүүлэн ажилладаг. Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ын дагуу шагнаж, урамшуулж байна.
401. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолбор” барих ажлыг 2016 оны 6 дугаар сард БНХАУ-ын Худалдааны сайдын Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр хэлэлцэн Монгол Улсын Гадаад хэргийн сайд, БНХАУ-ын Худалдааны сайд нарын түвшинд буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 20.4 сая ам.долларын төсөвт өртөгтэйгээр барихаар шийдвэрлэж үзэглэсэн. Тус ордонг барихаар Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/112 дугаар захирамжаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 15 жилийн хугацаатайгаар газар эзэмших эрхийг олгоод байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолбор нь нийтдээ 19,567.0м² талбай бүхий зоорьтой 7 давхар барилга байхаар төлөвлөсөн бөгөөд зочид буудал, 200м тойрог бүхий манеж, гадна талдаа 400м тартан зам, 200 ортой тамирчдын байрлах байр, 150 хүн зэрэг хооллох хоолны

- газар, хурлын танхим, заалны тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн явуулах спорт заал, фитнес заал, жудо бөх, хүндийн өргөлт, таеквандо, сагсан бөмбөг, суугаа волейбол, ширээний теннис, хөнгөн атлетик, байт харваа, хонхот бөмбөг, буудлага зэрэг пара спортын 10 төрөлд зэрэг хичээллэх боломжтой бэлтгэлийн заалтай олон улсын стандартад нийцсэн тусгай тоноглол бүхий цогцолбор байна. Спорт цогцолбор баригдсанаар жилийн 4 улиралд 200-400 тамирчин 10 төрлөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлэх юм.
402. 2017-2020 оны хооронд олон улсын тэмцээн, уралдаанд оролцон амжилт үзүүлсэн ч урамшууллаа авч чадахгүй байсан 43 тамирчинд олгох 268 гаруй сая төгрөгийг олгохтой холбоотой асуудлыг Засгийн газрын 2021 оны 200 дугаар тогтоолоор батлуулж, ХХҮЕГ-аас тамирчдын мөнгөн урамшууллыг олгох ажлыг зохион байгуулсан. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын урамшууллын асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Засгийн газрын 2018 оны “Журам шинэчлэн батлах тухай” 173 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, тус зардлыг бүхэлд нь биеийн тамир, спортыг дэмжих сангаас олгох зохицуулалтыг тусгахаар төлөвлөж байна.
403. Биеийн тамир, спортын улсын хороо, Монголын тусгай олимпийн хороо, Паралимпийн хороо, Дифлимбийн хороо гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, олон улсын уралдаан тэмцээнд оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай 2021-2023 онд хамтран ажиллах Санамж бичиг байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг биеийн тамир спортоор хичээллүүлж, хөгжүүлэх, олон улс, тив, дэлхийн хэмжээний уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх, тамирчдын гаргасан амжилт олон нийтэд түгээх, алдаршуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд Олон улсын уралдаан тэмцээнд оролцох зардлыг “Хүүхдийн төлөө сан”-аас гаргах зохицуулалтыг бий болгосон.
404. 2020 онд “Тэмүүжин таеквондо” клубтэй хамтран сонсголын бэрхшээлтэй хоёр хүүхдэд үнэ төлбөргүй таеквондо сургалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулсан, 2021 онд Паралимпийн олимпод Монгол улсаа төлөөлж оролцох эрхийг 30 тамирчин авсан байна. ТВ8 телевизийн “АМЬДРАХ САЙХАН” нэвтрүүлэгт харааны бэрхшээлтэй жудо бөхийн олон улсын хэмжээний мастер Н.Алтанцэцэгийг оролцуулан тамирчин хүний сайн жишээгээр нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.
405. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг урлаг, спортоор дамжуулан хөгжүүлэх чиглэлээр Шатар, нисдэг таваг, “Жюү жицү” Флорбол, Скүүтэр, хөл бөмбөг, ширээний теннисний дугуйланд 31 хүүхдийг хамруулсан. Төрийн болон “Тусгай олимп” ТББ- тай хамтран хөдөө орон нутгийн 8 аймагт нийт 400 гаруй хүүхэд, эцэг эхэд 30 цагийн “Спортоор дамжуулан хүүхдийг хөгжүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь” сургалт уулзалтыг зохион байгууллаа.
406. Спорт, биеийн тамир хөтөлбөрийн багш Л.Олонбаяр, Т.Нарантуяа нарын дасгалжуулсан охидын баг тамирчид 01 дүгээр сард “Улсын аварга” шалгаруулах Шалны хоккейн тэмцээнд амжилттай оролцож хүрэл медаль, Дорноговь аймагт 2022 оны 04 дүгээр сард болсон Жюү жицүгийн аварга шалгаруулах тэмцээнд дасгалжуулагч багш нар, 12 тамирчин, тэдний асран хамгаалагч-15 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 3 жинд өрсөлдөж 3 алт, 3 мөнгө, 6 хүрэл нийт 12 медаль хүртсэн бол энэ 11 сард АНЭУ-ын Аби Даби хотноо болох Жюү жицү” -гийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 3 хүүхэд, эцэн эх, багш нарын хамт оролцож байна. Урлаг, спортын арга хэмжээний хүрээнд 4 удирдамж боловсруулан нийт 400 гаруй хүүхдийг хамруулан ажилласан.
407. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, тэгш оролцоог хангах зорилгын хүрээнд пара хөнгөн атлетикийн ууган гавьяат тамирчин, олон улсын хэмжээний мастер Ж.Лхагважавын нэрэмжит “Дүнжингарав марафон” 9 дүгээр сард зохион байгуулав.

Тус марафоныг ХНХЯ, Биеийн тамир спортын улсын хороо хамтран зохион байгуулж, ХБХХЕГ, СЗСҮТ, ХБХСЗХТ, ХХХСХТ зэрэг байгууллагуудын албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг агентлагуудаас нийт 300 гаруй төрийн албан хаагчид, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо зэрэг хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын төлөөлөл, ерөнхий боловсролын сургуулийн өсвөр насны сурагчид, ард иргэд зэрэг нийт 1500 гаруй тамирчид оролцлоо. Марафон гүйлтийг мэргэжлийн тамирчдын 21 км-ын ангилал, гүйлт сонирхогчид иргэдийн дунд 4 насны ангиллаар зохион байгуулсан бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд бүрэн хараагүй, сул хараатай, гарын тайралттай, тэргэнцэртэй, саажилттай гэсэн 4 ангилаар зохион байгуулагдлаа.

31 дүгээр зүйл. Статистик болон мэдээлэл цуглуулах

408. Үндэсний статистикийн хороо нь хөгжлийн бэрхшээлийн статистикийн олон улсад харьцуулагдахуйц байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Ажиллах хүчний судалгаа /2020-2022 он/, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа /2020, 2022/ онуудад Вашингтон бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тодорхойлох богино багц асуудлыг тусгаж холбогдох мэдээллийг цуглуулсан.
409. Үндэсний статистикийн хороо, Боловсрол, шинжлэх ухааны яам хамтран бүх шатны боловсролын байгууллагад суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын мэдээллийг захиргааны болон албан ёсны статистикийн маягтад тусган холбогдох мэдээллийг 2020 оноос нийтэд тархааж эхэлсэн.
410. НҮБ-ын Статистикийн комиссын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын зарчим, зөвлөмж III” болон Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн хүрээнд Хүн ам, орон сууцны 11 дэх удаагийн ээлжит тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, мэдээллийг Хүн ам, өрхийн мэдээллийн сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Эрүүл мэндийн яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн захиргааны мэдээллийн сангийн мэдээлэлтэй уялдуулж, тооллогын үзүүлэлтийг боловсруулсан.
411. Үндэсний статистикийн хороо 2003 оноос эхлэн албан ёсны статистик мэдээлэл болох Нийгмийн зарим үзүүлэлтийн тайлан НЗҮ-1, НЗҮ-1А маягтаар аймаг, нийслэлээс жил бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж нийтэд тархааж байна.
412. Үндэсний статистикийн хорооны даргын 2021 оны А/106 тоот тушаалаар Хөдөлмөрийн зах зээлийн (Бүртгэлтэй ажилгүй иргэний сарын мэдээний маягт 3-ХЗЗ-2Б, Бүртгэлгүй ажилгүй иргэдийн сарын мэдээний маягт-3-ХЗЗ-4Б) анхан шатны бүртгэлийн болон захиргааны статистикийн маягтыг зөвшөөрсөн. Уг маягтад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг насны бүлэг, хүйс, аймаг, нийслэл дүүргийн задаргаагаар мэдээллийг нэгтгэн гаргаж байгаа бөгөөд энэхүү маягтын төсөлд ХНХЯ-наас тухай бүр саналыг авч, тусган ажилласан.
413. ҮСХ нь 2023 онд Нийгмийн халамжийн статистикийн захиргааны болон албан ёсны статистикийн маягт, нөхөх зааврын төслийг боловсруулж, ҮСХ-ны арга зүйн байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, даргын зөвлөлд хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон
414. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022оны А/ 313 дугаар т“ Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” тушаалаар Сургуулийн өмнөх боловсролын бүртгэлийн маягтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг мэдээг авахдаа даун, аутизмтай хүүхдийн мэдээллийг тусад нь авахаар нэмэлт өөрчлөлт оруулсан.
415. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоон мэдээллийг Нийгмийн халамжийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан

- /WAIS/ програмаас нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авсан хүний тоогоор гаргадаг.
416. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс нь 16 ба түүнээс дээш насны хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоодог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, ердийн өвчин гэсэн үндсэн 3 төрлийн шалтгааны улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж байна. Тус комисс нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож мэдээллийн санд төвлөрүүлдэг.
417. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоодог. ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл II”-ийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн статистик мэдээллийн нэгдсэн сан” байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлж, ашиглах арга зааварчилгаа өгөх сургалтыг 21 аймаг, 9 дүүргийн салбар комиссын 150 гишүүнийг хамруулан Улаанбаатар хотод зохион байгуулсан. Мөн www.cwd.mls.gov.mn домэйн нэр авч, “ХУР” болон ehalamj.mn системүүдэд холбох ажил хийгдэж байна.
418. Боловсрол, шинжлэх ухааны яам нь Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургууль /бага, дунд, ахлах, тусгай сургууль/ их, дээд сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо мэдээлэл, Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн салбартай холбоотой үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, бэрхшээлийн хэлбэр, насны бүлэг, хүйс, хөдөлмөр эрхлэлт, тэргэнцэртэй хүний тоо, байнгын асаргаанд байдаг хүний тоо зэрэг эдгээр үзүүлэлтүүдийг жилд нэг удаа ЭМТ-201 тайлангаар тус тус цуглуулж байна.
419. АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд “Монгол Улсын хөгжлийн бэрхшээлийн үзүүлэлтүүдийн эх үүсвэрүүд” сэдэвт харьцуулсан судалгааг хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээлэл, мэдээллийн системийн экспертийн үндэсний зөвлөх Д.Люунчимэгээр гүйцэтгүүлсэн. Уг судалгаанд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/112/87 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан.
420. Нийгмийн халамж, даатгалын сангийн тулгалт болон ҮСХ-ны Хүн ам, өрхийн мэдээллийн сан, Нийгмийн зарим үзүүлэлт мэдээний хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг тулгах, холбогдох маягтуудыг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.

32 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа

421. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж, оролцоог нэмэгдүүлэх хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь 3 олон улсын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
1. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл” /2018-2025/,
 2. ЖАЙКА байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бэхжүүлэх төсөл” /2021-2025/,
 3. Монгол дахь Норвегийн тусламжийн байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил төсөл” /2020-2024/
422. **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн мэдээлэл:**

Төслийн бүрэлдэхүүн 1. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавх бэхжүүлж институтчилэх чиглэлээр дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

423. Олон улсад ашиглаж байгаа стандарт арга хэрэгслийг судалж гэр бүлийн түвшинд хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх, эрт оношлох “Монгол хүүхдийн хөгжлийг үнэлэх түргэвчилсэн сорил”-ыг Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тусгах, хэрэгжүүлэх, энэ чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх ажлууд зохион байгуулж байна. Ингэснээр өрх, сумын эрүүл мэндийн төв нь хүүхэд бүрийг 9, 18, 36 сартайд нь эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэлтэд хамруулах тогтолцоо бий болно.
424. Европын орнууд, тухайлбал Швейцар, Австри, Герман зэрэг улсад нэвтрүүлсэн Бауман-хөгжлийн хоцрогдлын үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэх замаар хүүхдийн нарийн мэргэжлийн эмч, ажилтнууд хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдийн оношилгоо, үнэлгээ хийх туршилтын ажлыг эхлүүлээд байна. Уг аргачлалыг Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, төсөл хэрэгжиж буй 6 аймгийн нэгдсэн эмнэлэг, Эх нярайн үндэсний төвд нэвтрүүлэх, эмч ажилтнуудыг сургах, үзлэгийн үед ашиглах сонсголын, харааны багаж хэрэгслийг нийлүүлэх ажлууд хийгдэж эхлээд байна.

Төслийн бүрэлдэхүүн 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

425. Архангай, Дархан-уул, Дундговь, Дорнод, Ховд, Хөвсгөл аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв (ХБХХТ)-ийн барилга барьж ашиглалтад орууллаа. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй 23 000 орчим хүнд сэргээн засахын үйлчилгээг орон нутагт нь газар дээрээс хүргэх боломжтой боллоо.
426. Засгийн газрын 2021 оны 164 дүгээр тогтоолоор төсөл хэрэгжиж байгаа 6 аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах тухай шийдвэр гарсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/159 дүгээр тушаалаар ХБХХТ-ийн бүтэц, зохион байгуулалт, төвийн ажлын байрны үлгэрчилсэн жагсаалт, төвийн дүрмийг тус тус баталсан.
427. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн болон нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил гэр бүл, олон нийтийн дунд үр бүтээлтэй амьдрахад дэмжлэг үзүүлэх төрийн үйлчилгээний байгууллага юм. Төв нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-ХБХХЕГ-ын Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн удирдлагад ажиллана. Хөгжлийн төвийн эрхэм зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдэд олон улсын жишигт хүрсэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээг тав тухтай орчинд хүргэхэд оршино.
428. Төсөл хэрэгжиж байгаа 6 аймгийн ХБХХТ-ийн үйл ажиллагаанд шаардагдах 112 төрлийн 1224 ширхэг 1,457,622.00 ам.долларын өртөгтэй туслах технологи, 19 төрлийн 246 ширхэг компьютер, принтер, проектор, телевиз зэрэг 265,623.44 ам.долларын өртөгтэй тоног төхөөрөмжүүд, оффисын ширээ, сандал, шүүгээ зэрэг 172,497,000 ам.долларын өртөгтэй албан тасалгааны тавилгуудыг Дархан-уул, Дундговь, Дорнод, Ховд, Хөвсгөл аймгийн ХБХХТ-д хүргэж угсарч зохих өрөөнүүдэд байрлуулсан. Төвийн үйл ажиллагааг 2023 оны 3 дугаар улиралд эхлүүлэхээр бэлтгэж ажлыг хангаж байна.
429. ХБХХТ-д ажиллах сэргээн засахын ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, чадавх бэхжүүлэх чиглэлээр 2021-2022 онд зохион байгуулсан 6 удаагийн сургалтад нийт 280 оролцогч хамрагдсан.

Төслийн бүрэлдэхүүн 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн орчны хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

430. Орчны хүртээмжийг зохицуулж байгаа олон улсын туршлага, Монгол Улсын өнөөгийн хууль эрхзүйн баримт бичгийн судалгаа хийж барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээллийн хүртээмжийг сайжруулах зөвлөмж, санал боловсруулсан.
431. ХБХХЕГ-ын Протез, ортопедын үйлдвэрт туслах хэрэгслийн Оттобок машины 29 төрлийн 1110 ширхэг 25 000 ам.долларын сэлбэг хэрэгслийн худалдан авалт хийж хүлээлгэн өгсөн.
432. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Протез, ортопедын үйлдвэрийн үйл ажиллагаанд шаардлагатай 61 төрлийн 201 ширхэг дасгалын төхөөрөмжүүд, үзлэгийн ор, хэв авах хэрэгслүүд, оёдлын машин, гутлын түрий сунгагч зэрэг 1,489,803,000 төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.
433. Монгол хэлний бичвэрийг ярианд хөрвүүлэх ажлын хүрээнд программ хангамжийн хөгжүүлэлт хийж харааны бэрхшээлтэй Монгол хүмүүс Windows™, MacOS™, Linux™ бүхий компьютерүүд, Android™, iOS™ бүхий гар утас таблетуудыг ашиглах замаар мэдээлэл авах бүрэн боломжтой болгосон.
434. ХБХХЕГ-ын Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн агааржуулалтын системийн шинэчлэх ажлыг хийж үйлдвэрийн тоног төхөөрөмж, оёдолчны өрөө, эсгүүрчний өрөөнд агааржуулагч систем шинээр, гуталчны өрөө, технологич-эмч, оёдолчны өрөөнд үйлдвэрийн дугуй сэнс шинээр тус тус угсарч хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Төслийн бүрэлдэхүүн 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

435. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төв (ХБХХЭҮХНТ) байгуулах бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна. Үүнд:
 - а. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт ХБХХЭҮХНТ-ийн 8 давхар барилга угсралтын ажлыг 2022 оны 6 дугаар сард эхлүүлж 40 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилгыг 2024 оны 2 дугаар улиралд ашиглалтад хүлээн авч 3 улиралд үйл ажиллагааг эхлүүлнэ.
 - б. ХБХХЭҮХНТ-ийн бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний хамрах хүрээ, төвийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтын төслийг боловсруулаад байна.

Төслийн бүрэлдэхүүн 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дэмжих стратеги боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

436. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах нөлөөллийн ажлууд хийх, хэвлэл мэдээллийн стратеги боловсруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай хамтран ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулахад чиглэсэн 24 нийтлэл, 33 ярилцлага, 15 редакцын хэлэлцүүлэг, 30 сурвалжилга, нийт 102 бүтээгдэхүүн, телевизийн 20 минутын 40 нэвтрүүлэг, 30 секундын 22 шторк, радиогийн 4 нэвтрүүлэг, чэллэнж 2, инфографик 16, подкаст 10, богино хэмжээний 15 видео бэлтгэж олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээх ажлыг хийж гүйцэтгэлээ.
437. Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг Монгол Улсад хэрэгжүүлэхээр өмнө хийгдсэн оролдлогуудыг судалж нэвтрүүлэхэд тулгарсан асуудлуудыг тодорхойлсон. Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ын үнэлгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн

чадварыг үнэлэхэд ашиглах туршилт хийж, гарын авлага, зааврын төсөл боловсруулсан. Цаашид энэхүү үнэлгээг төсөл хэрэгжиж буй 6 аймгийн түвшинд туршиж нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

438. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик мэдээллийн нэгдсэн сан байгуулах чиглэлээр Үндэсний статистикийн хороо, ХНХЯ-тай хамтран ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээлэл цуглуулахад шаардагдах 25 маягтын загварыг боловсруулж батлуулахаар ажиллаж байна.

439. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бэхжүүлэх төсөл”-ийн мэдээллийг 64, 65 дах хариултаас дэлгэрүүлж харна уу.

440. Монгол дахь Норвегийн тусламжийн байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил төсөл” /2020-2024/-ийн мэдээллийг 7 дугаар зүйлд дурдсан байгааг дэлгэрүүлж харна уу.

441. Тэгш хамран сургах боловсролын чиглэлээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын салбарт олон улсын 3 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна.

1. ЖАЙКА-ын Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” II шат(2020-2024),

2. АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Тэгш хамруулах боловсролыг дэмжих” төсөл (2021-2024),

3. Дэлхийн боловсролын түншлэл” олон улсын байгууллагын санхүүжилтээр “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл (2023- 2026)

442. Жайка олон улсын байгууллагын Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”

Зорилт 1: “Үндэсний хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын боловсрол хариуцсан мэргэжилтний чадавх бэхэжнэ.”

443. Салбар комиссийн гишүүдэд зориулсан “Бүх гишүүдийн сургалт”, “Шинэ гишүүдийн сургалт” гэсэн 2 хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан. Бүх гишүүдийн сургалтыг 2021 онд 3 удаа, 2022 онд 1 удаа, 2023 онд 1 удаа ICF-д суурилсан хөгжлийн үнэлгээ хийх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах тухай лекц, дадлага ажил, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн нэгдсэн санг ашиглах аргачлалыг тайлбарлаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад бүх салбар комиссын хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа, зарим цэцэрлэг, сургуулийн боловсролд тэгш хамран сургаж буй үйл ажиллагааны жишээ, туршлагыг танилцуулсан.

444. Шинэ гишүүдэд зориулсан сургалт нь хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх дэмжлэг, үйл ажиллагааны талаарх ойлголт, мэдлэг дутагдах байдал нийтлэг ажиглагдаж ирсэнтэй холбогдуулан шинээр томилогдсон гишүүдэд зориулан нийт 8 төрлийн сургалтын видео лекц боловсруулах ажил зэргээр зохион байгуулагдаж байна.

Зорилт2: “Үндэсний хэмжээнд, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ үзүүлэх бааз (Тогтолцоо, төлөвлөгөө, хүний нөөц) бүрдэнэ.”

445. Улаанбаатар хот, Төв аймагт 2 цэцэрлэгийг туршилтын цэцэрлэгээр сонгосон бөгөөд тэгш хамруулдаг цэцэрлэгийн загвар бий болгохоор ажилласан үүний үр дүнд Сургуулийн өмнөх боловсролд хэрэгжүүлэх Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/206 дугаар тушаалаар батлагдсан. “Цэцэрлэгт тэгш хамран сургах үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөмж” боловсруулан нийслэлд 25 цэцэрлэг сонгон, эдгээр цэцэрлэгт тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Зорилт 3: “Үндэсний хэмжээнд, бага, дунд сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ үзүүлэх бааз (Тогтолцоо, төлөвлөгөө, хүний нөөц) бүрдэнэ.”

446. Нийслэлийн 9 дүүргийн Боловсролын хэлтэст томилогдсон тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн. мөн 25 сургуулийг түгээн дэлгэрүүлэх зорилтот сургуулиар сонгон, орчин бүрдүүлэх болон хичээл сургалтын үйл ажиллагаагаа сайжруулахад дэмжлэг үзүүлсний зэрэгцээ тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтнүүдтэй эдгээр сургуулиудад очиж мониторинг хийж, тэгш хамран сургадаг ангийн загварыг бий болгох зорилгоор хэлэлцүүлэг сургалт зохион байгуулж, нийслэлийн 9 дүүргийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Тэгш хамран сургах боловсролын хэрэгжилтийг шалгах хуудас боловсруулсан. Бүсийн төвөөр сонгогдсон аймгийн цэцэрлэг, сургуулиудад мониторинг хийж сайн жишээ, анхаарах асуудлыг БШУЯ болон харьяа байгууллагын төлөөлөлд танилцуулсан.

Зорилт 4: “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ үзүүлэх мэргэжил дээшлүүлэх сургалтад (Цахим сургалт, танхимын сургалт) хамрагдана.”

447. Одоогийн тэгш хамран сургах боловсролын чиглэлээр хэрэгжиж буй багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын талаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсний дараа багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын 40 гаруй дүрст хичээл бэлтгэн⁶ багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэсэн.

448. **АХБ-ны бүцэлтгүй түслэмжаар хэрэгжиж буй “Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл Дархан-уул, Дундговь, Дорнод аймгаг, нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн тус бүр 1 цэцэрлэг, 1 сургууль нийт сургалтын 8 байгууллагад доорх 3 бүрэлдэхүүний хүрээнд хэрэгжиж байна.(Дархан-Уул аймгийн 12-р сургууль, 7-р цэцэрлэг, (ii) Дорнод аймгийн 1-р сургууль, 8-р цэцэрлэг, (iii) Дундговь аймгийн Говийн ирээдүй сургууль, 3-р цэцэрлэг, (iv) СХД-ийн 105-р сургууль, 253-р цэцэрлэг)**

Бүрэлдэхүүн хэсэг 1: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дэд бүтцийг сайжруулж илүү хүртээмжтэй болгох

449. Зорилтот 4 сургууль, 4 цэцэрлэгийн дэд бүтцийг хүртээмжтэй болгон сайжруулах, барилгын засварын ажлыг 4 гүйцэтгэгч компани батлагдсан зураг төслийн дагуу 2022 оны 8 дугаар сарын 28-наас сараас 12 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэсэн. Барилгын засварын ажилд дараах ажлуудыг хийсэн. Үүнд, (i) тэргэнцэртэй хүүхэд нэвтрэх гадна налуу зам зассан, (ii) шатны дагуу хоёр түвшний өндөртэй бариул, хонгилын хананд нэг түвшний бариул суурилуулсан, (iii) охид, хөвгүүдэд зориулсан ариун цэврийн өрөөг буулгаж, шинээр засаж, тэргэнцэртэй нэвтрэхэд тохиромжтой жорлонгийн кабин, зохих бариул, ариун цэврийн угаалтуур суурилуулсан, (iv) хүүхдийн хөгжлийг дэмжих танхимуудыг зассан (v) анги танхимын хаягжилт, анхааруулах өнгийн болон брайл тэмдэглэгээ хийсэн, шатны эхлэл болон төгсгөлд гарт болон хөлд мэдрэгдэх резин товгор хөтөч хавтанг байрлуулсан. Зураг төсөл, хамгааллын хяналт шинжилгээний зөвлөх үйлчилгээ (175,499,999₮), Засварын зураг төсөл, төсөв, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө Засварын ажил (968,932,422₮) төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. ⁷

450. ХБХ-ийн сурах үйлийг дэмжсэн тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг (527,858,484₮) төгрөгийн санхүүжилтээр G003:Хараа, G009:Сонсгол, G010:Харилцаа, G011:Суралцахуй, G012:Хөдөлгөөний, G013:Зан төлөв, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах үйлийг дэмжих сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгслийг (19 төрлийн 212 ширхэг) нийлүүлэх тендерийг зохион байгуулан,тендэрт шалгарсан нийлүүлэгчидтэй гэрээг байгуулсан ба гэрээний дагуу барааг зорилтот сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлж дууссан.

⁶ Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”ii шаттөслийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан (Төслийн эхний хагас жил, төслийн явцын тайлан дугаар -4)

⁷ Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл 2023 оны 3дугаар улирлын тайлан

451. Зорилтот 8 сургууль, цэцэрлэгт хүүхэд хөгжлийг дэмжих танхимыг зассан бөгөөд танхимын G004:Тавилга, G005:Компьютер, цахилгаан хэрэгсэл, G006:Жижиг тоног төхөөрөмж, G007:Ном, G008:Тоглоом нийлүүлэх худалдан авалтыг 2022 онд зохион байгуулсан. Тендерт шалгарсан нийлүүлэгчидтэй гэрээг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан ба барааг зорилтот сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлж хүлээн авсан. Хүүхэд хөгжлийг дэмжих загвар танхим 8-ыг байгуулахад (631,657,008₮) -ний санхүүжилт шийдвэрлэсэн байна.

Бүрэлдэхүүн хэсэг 2: Тэгш хамруулах боловсролын үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд (1,129,855,237₮) төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн байна.

452. Сургуулийн өмнөх, бага, суурь ба бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах үзэл баримтлал, соёл болоод жендерийн тэгш байдлын зарчмууд хэрхэн туссан талаар товч дүн шинжилгээ хийж, хөгжлийн бэрхшээл, соёл, жендерийн асуудлыг тусган хэрэгжүүлэх зөвлөмжийн хүрээ гаргасан. Суралцахуйн түгээмэл загварын арга барил, зарчимд суурилсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих, багшид дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулсан.

453. Хөгжлийн бэрхшээлийн 6 төрлөөр арга зүйн 14 цахим хичээлийг боловсруулсан, .

454. “Тэгш хамруулсан сургалтыг хэрэгжүүлэх зөвлөмж” гарын авлага боловсруулж, зорилтот сургууль, цэцэрлэгийн багш нарт түгээсэн.

455. Тэгш хамран сургах боловсролын соёл, бодлого, үйл ажиллагааг хөгжүүлэх нь” танхимын сургалтыг зорилтот сургууль, цэцэрлэгийн 437 багш, туслах багш, 46 захирал, эрхлэгч нарт зохион байгуулсан,

456. 2022 онд дохионы хэлний хэлмэрчийн сургалтыг 11 багш, ажилтанд, брайл хэл ба технологийн сургалтыг 10 багш, ажилтанд зохион байгуулсан.

457. Орон нутгийн сургагч багшаар 36 сургагч багшийн нийслэл Улаанбаатар хотод 7 хоногийн хугацаатай бэлтгэгдэн, тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааг орон нутгийн сургууль, цэцэрлэгийн 1500 түүнээс дээш багшид түгээн дэлгэрүүлэх үүрэг хүлээгээд байна.

Бүрэлдэхүүн хэсэг 3: Тэгш хамруулах боловсролыг дэмжих эх үүсвэр, олон нийтийн оролцоо болон бодлогыг бэхжүүлэх (1,102,000,856.66₮):төсөвлөн хэрэгжүүлж байна.

458. Хөгжлийн бэрхшээл болон тэгш хамран сургах боловсролын талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 5 цуврал видео анимэйшн, 15 постер, 5 подкастыг бэлтгэн төслийн болон Боловсролын ерөнхий газар, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг сошиал хуудас, орон нутгийн телевизүүдээр түгээн дэлгэрүүлсэн Бүсийн зохицуулагчид аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтэстэй хамтран зорилтот сургууль, цэцэрлэгт олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, уулзалт, арга хэмжээг 2641 (үүнээс 70% эмэгтэй) хүнд зохион байгуулсан ба сургалт, арга хэмжээнд видео анимэйшн, постеруудыг ашиглаж байна.

459. Зорилтот аймаг, дүүргийн хэмжээнд 2021 оны 11 дүгээр сараас хойш боловсролын үйлчилгээний гадна буй 194 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлснээс 80 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлсэн.

460. Аймаг, дүүргийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, дэмжлэгийн багийн нийт 107 хүнийг танхимаар болон цахимаар чадавхжуулсан. 2023 оны 2-р улиралд дараагийн шатны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

461. “Тэгш хамран сургах боловсролд хамтдаа” эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага боловсруулан 1400 хувь хэвлүүлж танхимын сургалтыг 120 эцэг эх, асран хамгаалагчдад зохион байгуулав. Мөн бүсийн зохицуулагчид тус гарын авлагын дагуу сургагч багшаар бэлтгэгдсэн эцэг эхчүүдийн хамт сургалтыг зохион байгуулсан ба нийт 969 хүн хамрагдсан.

462. 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр ТХБ-ыг дэмжих 8 бичил төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан 8 иргэний нийгмийн байгууллагатай гэрээ байгуулан (тус бүр 22,8 сая ₮) бичил төслүүдийг хэрэгжүүлж байна.

463. ТХСБ-ын бодлогын 2 хураангуйг ТХСБ-ын 9 үндсэн шинж чанарын хүрээнд хийсэн дүн шинжилгээ болон олон улсын сайн туршлагын жишээн дээр суурилан олон улсын зөвлөх Паула Фредерика Хант боловсруулсан. Уг бодлогын хураангуйг 1200 хувь хэвлүүлж БШУЯ, харьяа байгууллагууд, аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтэс, бүх сургууль болон зорилтот орон нутгийн цэцэрлэгүүдэд түгээж байна.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх

2. Суралцагчийн үдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах

3. Сурагчийн сурлагын амжилтыг сайжруулах зорилгоор хосолсон сургалтын загварыг бий болгох зорилтуудын хүрээнд төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.⁸

464. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх 1 бүрэлдэхүүний хүрээнд ерөнхий боловсролын 18 сургууль, 300 багш, 130,766 бага, дунд ангийн суралцагч, бага, дунд ангийн 64,330 охид, 742 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төслийн үр дүнг хүртэнэ. (Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 25, эрдмийн хөтөч, 71 дугаар сургууль, Хан-Уул дүүргийн 118, 88, 15 дугаар сургууль Архангай аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын сургууль, Эрдэнэмандал сумын ерөнхий боловсролын сургууль, Эрдэнэмандал сумын ерөнхий боловсролын сургууль, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль, Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль, Увс аймгийн Баруунтуруун сумын ерөнхий боловсролын сургууль, Улаангом сумын ерөнхий хоёрдугаар цогцолбор боловсролын сургууль, Улаангом сумын ерөнхий хоёрдугаар цогцолбор боловсролын сургууль, Ховд сумын ерөнхий боловсролын сургууль, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль, Дарьганга сумын ерөнхий боловсролын сургууль, Түмэнцогт сумын ерөнхий боловсролын сургууль)

465. **“Дэлхийн боловсролын түншлэл” олон улсын байгууллагын санхүүжилтээр “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл” (2022- 2025)** он нийт 5 сая ам.долларын санхүүжилттэй:

- Ердийн сургуулийн багш нарыг тэгш хамран сургах боловсролын арга зүй, ялангуяа ГСТ-ний хэрэглээ болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний чиглэлээр сургалт зохион байгуулах,
- Хөгжлийн бэрхшээлийн тодорхой төрлүүдээр багш нарын хамтын ажиллагааны сүлжээг бий болгох /18 сургууль, ТББ, БШУГ/
- Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд тусгай боловсролын багш нарыг томилон ажиллуулах үйл ажиллагааг туршин хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимыг суралцагчдад зориулсан туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах
- Тэгш хамруулах чиглэлээр төслийн суурь судалгаа хийх ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

466. Бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллах хүрээнд:

467. Мэргэжлийн боловсролын салбарт анх удаа ХБИ-нд мэргэжлийн боловсрол олгох, хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэн амьдралын чанарыг сайжруулах зорилгоор Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр, хөдөлмөр эрхлэлтийг шинэчлэн дэмжих нь төсөл”-ийн дэмжлэгээр “Мэргэжлийн боловсрол, түншлэл” ТББ, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв, ажил олгогч, аж ахуй нэгж байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-тай хамтран 3 мэргэжлээр Мэргэжлийн боловсрол сургалтын стандарт, Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулсан. Үүнд: Цахим үйлчилгээний ажилтан, Архив, бичиг хэргийн ажилтан, Үйлчилгээний ажилтан гэсэн мэргэжлүүдийг аж ахуй нэгж

⁸ Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн танилцуулга

байгууллагууд, ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал хүсэлт, эрэлтэд тулгуурлан сонгон авсан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан боловсруулсан болно. Мэргэжлийн үүрэг,ажилбаруудыг DACUM аргачлалд үндэслэн чадамжид суурилсан сургалтын зарчим болох ажлын байран дээр зайлшгүй гүйцэтгэх ажилбаруудыг ажил мэргэжлийн дүн шинжилгээний арга зүйгээр тодорхойлж сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Суралцагчийн гарын авлага нь нийт 3 мэргэжлийн 22 чадамжийн нэгжээр хэвлэмэл болон цахим хэлбэрээр боловсруулагдаад байна.

468. НҮБ-ын Хүн амын сантай хамтран 2020 онд жендерт суурилсан хүчирхийллийн тухай гарын авлага боловсруулж, холбогдох төрийн байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

469. Хариулт 48-д дурдсан загвар төслийг НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлсэн.

470. Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй төслийн мэдээллийг 348 дах хариултаас дэлгэрүүлж харна уу.

33 дугаар зүйл. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих

471. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж, чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэн Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хяналт шалгалт хийх нийтлэг журмын төслийг боловсруулж батлууллаа.

472. ХНХЯ-аас яамдын батлан хэрэгжүүлэх “Салбарын хяналтын хуудас”-т хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаар зайлшгүй тусгуулах шаардлагатай асуудлыг жагсаалтыг боловсруулан хүргүүллээ.

473. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон барилга байгууламжид тавигдах шаардлага, аюулгүй байдлыг хангуулах МХЕГ-ын даргын 01/88 дугаар удирдамжийн хүрээнд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт уул уурхай, барилга, дэд бүтцийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 25, түүнээс дээш ажилтантай нийт 297 байгууллагад шалгалт хийж, 127 зөрчил дутагдал илрүүлж, 102 зөрчлийг арилгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй зөрчил гаргасан 57 байгууллагад нийт 11709,7 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт тавьж, харьяа аймаг, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн. Дээрх зөрчилд нь 15 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 22,500,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 70 байгууллагад 156 заалт бүхий хугацаатай албан шаардлага өгч, 297 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж хүргүүлэн ажилласан. Шалгалтын явцад 22 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангуулсан байна.

474. Барилга техникийн хяналтын чиглэлээр нийт 180 барилгад шалгалт хийж, 362 зөрчил дутагдал илрүүлж, 142 зөрчлийг арилгуулж, 48 албан шаардлага, 7 дүгнэлт, 15 зөвлөмж, 2 зөрчлийн хэрэг үүсгэн 1350,0 мянган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, бүрэн барагдуулж ажилласан байна.

475. 9 барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, ариун цэврийн өрөөнд тоног төхөөрөмж суурилуулсан, брайл зам, талбай, орох, гарах гарц, авто зогсоол, өрөө тасалгаа, давхар бүрд үйлчилгээний талаар заасан хаягжилтыг хийлгүүлж иргэдийн аюулгүй орчин хангуулж ажилласан.

476. Ковид-19 цар тахал, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 2021 онд төлөвлөгөөт шалгалтуудын 50 хувь нь хийгдээгүй. 2021 онд Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 1061 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллуулбал зохих орон тоондоо ажиллуулаагүй, ажлын байрны төлбөрийг төлөөгүй 195 зөрчил илрүүлэн зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

477. 2022 онд төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй боловч иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-д хяналт шалгалт хийж Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3–д заасан төлбөрийг төлөөгүй зөрчил илрүүлэн 119,0 сая төгрөгийг улсын ахлах байцаагчийн актаар нөхөн төлүүлж 1,5 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч бүрэн барагдуулсан байна.